

Ш.Батсүх, Я.Долгоржав, Б.Ганцоож

ШУУД АРДЧИЛАЛ- ИРГЭДИЙН ОРОЛЦОО

(Иргэний танхим, Орон нутгийн хөгжлийн сан)



УЛААНБААТАР ХОТ
2014



Konrad
Adenauer
Stiftung

50 JAHRE ZUSAMMENARBEIT WELTWEIT



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
УДИРДИАГЫН АКАДЕМИ

Ш.Батсүх, Я.Долгоржав, Б.Ганцоож

ШУУД АРДЧИЛАЛ- ИРГЭДИЙН ОРОЛЦОО

(Иргэний танхим, Орон нутгийн хөгжлийн сан)

УЛААНБААТАР ХОТ

2014

DDC
352.23
Б-34

Ш.Батсүх, Я.Долгоржав, Б.Ганцоож

ШУУД АРДЧИЛАЛ-ИРГЭДИЙН ОРОЛЦОО

© 2014 Зохиогчийн эрх хамгаалагдсан.

Энэхүү судалгааны ажлыг ХБНГУ-ын Конрад-Аденауэр сангийн захиалга, санхүүжилтээр Удирдлагын академийн судалгааны баг гүйцэтгэв.

Удирдлагын академи
Улаанбаатар – 36
Богд Жавзандамбын гудамж
Хан-Уул дүүрэг, Монгол улс
Утас: (976) 91055262
Имэйл: gantsooj1028@gmail.com

ISBN – 978-99973-0-540-4

“Адмон” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

АГУУЛГА

Өмнөх үг	5
Зургийн жагсаалт	7
Хүснэгтийн жагсаалт	9
Удиртгал	11
Судалгааны зорилго, зорилтууд	11
Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт	12
Судалгааны арга зүй	13
1. Шууд ардчилал-иргэдийн оролцооны онол, үзэл баримтлал	17
1.1 Шууд ардчилал-иргэдийн оролцооны ойлголт	17
1.2 Иргэдийн оролцооны үе шат, хэлбэр, арга хэрэгслүүд	18
1.3 Европын зарим орны туршлага	27
2. Орон нутгийн түвшинд шууд ардчилал- иргэдийн оролцоо хэрэгжих хүрээний бодлого, эрх зүйн орчин, хэрэгжилт	33
2.1 Бодлого, эрх зүйн орчинд хийсэн шинжилгээ	33
2.1.1 Шууд ардчилал-иргэдийн оролцоо	33
2.1.2 Иргэний танхимын үйл ажиллагаа (бүх түвшинд)	55
2.2 Орон нутгийн хөгжлийн сан ба иргэний танхим, иргэдийн оролцоо	72
Дүгнэлт	85
Зөвлөмж	87
Ашигласан материал	89

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

АНН	Аж ахуйн нэгж
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НӨУ	Нутгийн өөрийн удирдлага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
СХС	Сумын хөгжлийн сан
СЯ	Сангийн яам
УИХ	Улсын Их Хурал
ТАХ	Төрийн албан хаагч
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ИТ	Иргэний танхим
ӨУБ	Өөрөө удирдах байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага

ӨМНӨХ ҮГ

Монгол дахь Конрад-Аденауэр сангийн захиалгаар Удирдлагын академийн судалгааны баг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачлагаар 2009 онд байгуулагдсан “Иргэний танхим”, УИХ-аас 2011 оны 12 дугаар сарын 13-нд шинэчлэн найруулж баталсан “Төсвийн тухай” хуулийн 60 дугаар зүйлд заасан “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хэрэгжилтийг аймаг, нийслэлийн сонгож авсан сум, дүүргүүдэд иргэд болон төрийн албан хаагчдын санал бодолд тулгуурлан судалсан юм. Мөн судалгааны явцад энэ чиглэлээр гарсан бодлого, шийдвэрүүд, эрх зүйн баримт бичгүүдийг судалж, орон нутгийн иргэд, төрийн албан хаагчид, удирдах ажилтнуудтай уулзаж ярилцан судалгааны үр дүнгийн бодитой эсэхийг нягтлан ажиллаа.

Бидний судалгаа өргөн утгаараа “Шууд ардчилал-Иргэдийн оролцоо”-ны асуудлыг хөндөж байгаа юм. Сүүлийн жилүүдэд энэ асуудал дэлхийн улс орнуудад эрчимтэй хөгжиж, шууд ардчилал-иргэдийн оролцоог хэрэгжүүлэх олон хэлбэр, арга хэрэгслүүд бий болсон байна. Өндөр хөгжсөн орнууд үүнийг бодлогын баримт бичиг, хууль тогтоомжууддаа нарийн тусгаж, тэдгээрийг хэрэгжүүлэх гарын авлага, материалуудыг боловсруулан хэвлүүлж, иргэдээ энэ талын мэдлэг, мэдээллээр хангаж, оролцооны арга хэрэгсэлд сургах сургалтуудыг ч зохион байгуулдаг байна. Ийм байдлаар иргэдийн оролцоог бодит ажил болгох чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж ардчиллыг баттай хөгжүүлэх талаар анхаарч ажилладаг байна. Манай судалгааны баг энэ асуудлуудыг дэлгэрэнгүй авч үзээгүй ч Европын холбоо болон түүний гишүүн зарим орны туршлагыг тоймлон танилцуулсан байгаа.

Бидний судалгааны ажлын үр дүн бүх шатны шийдвэр гаргагчид, улс төр, төрийн удирдлагын чиглэлээр суралцагчид, энэ чиглэлийн судлаачид болон иргэдэд хэрэг болно хэмээн найдаж байна.

Энэхүү судалгааг хийх, судалгааны үр дүнг хэвлэн уншигчдад хүргэх боломж олгож, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Монгол дахь Конрад-Аденауэр сангийн хамт олонд гүн талархал илэрхийлье. Бидний судалгааны ажилд дэмжлэг үзүүлсэн бүх хүмүүст, ялангуяа судалгаанд хамрагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэд, албан хаагчид, удирдах ажилтнуудад баярласнаа илэрхийлэхэд таатай байна. Мөн судалгааны багт орж ажилласан нийт судлаачид, туслах ажилтнууд, түүний дотор судалгааны үр дүнг хэвлэлд бэлдэхэд үнэтэй цагаа харамгүй зарцуулсан Төслийн багийн зөвлөх, Удирдлагын академийн профессор Я.Долгоржав болон тус Академийн судалгааны ажилтан, төслийн багийн судлаач Б.Ганцоож нарт гүн талархал илэрхийлье.

Судалгааны багийн ахлагч, Удирдлагын академийн дэд захирал,
доктор, профессор Ш.Батсүх

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Оролцооны шатлал	19
Зураг 2.	Судалгаанд оролцогчдын насны бүлэг	38
Зураг 3.	Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин	38
Зураг 4.	Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал	39
Зураг 5.	Иргэдийн мэдээлэл авч буй байдал	40
Зураг 6.	Иргэдийн орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлж оролцож буй байдал	41
Зураг 7.	Орон нутгийн хөгжлийн бодлогын талаарх иргэдийн сэтгэл ханамж	45
Зураг 8.	Сонгуультай холбоогүйгээр орон нутгийнхаа бодлогыг сонирхож буй байдал	46
Зураг 9.	Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрт оролцож буй хэлбэр	47
Зураг 10.	Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэр гаргалтанд оролцож буй оролцооны хэлбэр, аймаг, нийслэлээр	47
Зураг 11.	Орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж байгаа ажлын талаарх иргэдийн үнэлгээ	49
Зураг 12.	Иргэдийн орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсч буй байдал	50
Зураг 13.	Орон нутгийн удирдлагууд үйл ажиллагааныхаа хэрэгжилтийг иргэддээ тайлагнадаг эсэх талаар иргэдийн үнэлгээ	51
Зураг 14.	Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрийг гаргахад цаашид оролцохыг хүсч буй байдал	52
Зураг 15.	Орон нутгийнхаа бодлого, шийдвэрт илүү их оролцох хүсэлтэй байгаа иргэдийн ямар хэлбэрээр оролцох хүсэлтэй байгааг нээлттэй асуултаар тодруулахад	52
Зураг 16.	Орон нутгийнхаа бодлого, шийдвэрт одоо оролцож байгаагаасаа илүү оролцохыг хүсэхгүй байгаа шалтгаан	55
Зураг 17.	Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхим дахь нээлттэй хэлэлцүүлэг	56
Зураг 18.	Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулагдсан арга хэмжээний тойм, түүнд оролцогчид	58
Зураг 19.	Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн оролцооны хэлбэрийг нээлттэй асуултаар тодруулахад	63

Зураг 20.	Иргэдийн Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцохыг хүсч буй оролцооны хэлбэрийг нээлттэй асуулгаар тодруулахад	65
Зураг 21.	Иргэний танхимын үйл ажиллагааны мэдээллийн хүртээмжийн талаарх иргэдийн үнэлгээ	66
Зураг 22.	Иргэний танхимын үйл ажиллагааны талаарх судалгаанд оролцогчдын үнэлгээ	66
Зураг 23.	Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй байдал	67
Зураг 24.	Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн оролцооны хэлбэрийг нээлттэй асуулгаар тодруулахад	71
Зураг 25.	Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалт, зарцуулалт, тайлангийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	80
Зураг 26.	Иргэдийн орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд оролцож буй байдал	80
Зураг 27.	Иргэдийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд оролцож буй байдал	81
Зураг 28.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж буй ажил тухайн орон нутгийн хөгжилд ямар өөрчлөлт авчирч байгаа талаарх иргэдийн санал бодол	82
Зураг 29.	Орон нутгийн иргэдийн оролцоог хэрхэн сайжруулах талаар иргэдийн санал бодол	83

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Судалгаанд хамрагдсан өрхийн тоо	12
Хүснэгт 2.	Иргэдийн оролцооны арга хэрэгсэл	22
Хүснэгт 3.	Иргэдийн оролцооны идэвхи, насны бүлэгт эзлэх хувь	41
Хүснэгт 4.	Иргэдийн оролцооны идэвхи, хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувь	42
Хүснэгт 5.	Иргэдийн оролцоотой удирдлагын тогтолцоо ямар зорилгод чиглэх ёстой талаарх иргэдийн төсөөлөл	43
Хүснэгт 6.	Орон нутгийнхаа хөгжлийн бодлогод иргэдийн сэтгэл ханамж, оролцооны идэвхи	45
Хүснэгт 7.	Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрт оролцож ирсэн оролцооны хэлбэр, насны бүлэг	48
Хүснэгт 8.	Иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж байгаа ажлын талаарх иргэдийн үнэлгээ, оролцооны идэвхи	49
Хүснэгт 9.	Иргэдийн орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсч буй байдал, насны бүлэг	51
Хүснэгт 10.	Иргэдийн орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсч буй байдал, оролцооны идэвхи	52
Хүснэгт 11.	Орон нутгийнхаа бодлого, шийдвэрт оролцох хүсэлтэй байгаа иргэдийн оролцооны хэлбэр, насны бүлэг	53
Хүснэгт 12.	Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрт оролцохыг хүсч буй оролцооны хэлбэр, хөдөлмөр эрхлэлт	54
Хүснэгт 13.	Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулагдсан арга хэмжээний тойм, сүүлийн 5 жилийн байдал	57
Хүснэгт 14.	Иргэдийн Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй байдал, насны бүлэг	63
Хүснэгт 15.	Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн оролцооны хэлбэр, насны бүлэг	64
Хүснэгт 16.	Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн оролцооны хэлбэр, хөдөлмөр эрхлэлт	64
Хүснэгт 17.	Иргэний танхимын үйл ажиллагаанд иргэдийн оролцохыг хүсч буй оролцооны хэлбэр, насны бүлэг	65
Хүснэгт 18.	Иргэний танхимын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ, насны бүлэг	67
Хүснэгт 19.	Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй байдал, насны бүлэг	67

Хүснэгт 20.	Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн оролцооны хэлбэр, насны бүлэг	71
Хүснэгт 21.	Иргэдийн Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд оролцож буй байдал, насны бүлэг	80
Хүснэгт 22.	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт тавихад иргэдийн оролцож буй байдал	81

УДИРТГАЛ

Манай улсын хувьд хууль эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх, шударга, нээлттэй, хариуцлагатай, хяналттай төрийг төлөвшүүлэх, эрх баригчид шийдвэр гаргахдаа ард иргэдээ сонсдог байх зарчмыг нийгэмд хэвшүүлэх, иргэдийн оролцооны үр нөлөөтэй тогтолцоо бүрдүүлэх, түүнийг бүх түвшинд хэрэгжих нөхцөлийг хангаж ажиллах шаардлага тулгарч байна.

УИХ-аас “Төсвийн тухай хууль”-ийг 2011 онд шинэчлэн найруулж баталсан, 2013 оныг “Шууд ардчилал-иргэдийн оролцооны жил” болгон зарласан, Монгол Улсын Ерөнхийлөгч “Иргэний танхим”-ыг байгуулж шууд ардчиллыг хөгжүүлэх, “Том төрөөс ухаалаг төр лүү” шилжих санаачлагыг өрнүүлсэн зэрэг нь төвлөрлийг сааруулж орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлд түлхэц өгч, практик амьдралд орон нутгийн хөгжлийн сан бүрдүүлэх, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлүүлэн хэрэгжүүлэх талаар хууль эрх зүйн шинэ орчин бүрдлээ. Мөн шинэчлэлийн Засгийн газраас “Шинэ сум” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн зэрэг нь төв, орон нутгийн харилцаанд, тухайлбал, иргэний оролцоо, төвлөрлийг сааруулах хийгээд төвлөрүүлэх хүрээнд шинэ шинэ өөрчлөлт бий болгож байна. Эдгээрийн ерөнхий хандлага, ололт амжилт, тулгарч буй бэрхшээл, үр дүнг онол, арга зүйн болон практик талаас нь судалж тодруулах хэрэгцээ улам бүр өссөөр байна.

Судалгааны зорилго, зорилтууд

Энэ судалгаагаар шууд ардчилал-иргэдийн оролцооны талаарх онол, үзэл баримтлал, Европын зарим орны туршлага болон Монгол дахь түүний хэрэгжилт, ялангуяа Иргэний танхим, Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн хэрэгжилтийн байдалд шинжилгээ хийж, судалгааны үр дүнд тулгуурлан санал, зөвлөмж боловсруулахыг зорилоо.

Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаа.

Үүнд:

- Шууд ардчилал-иргэдийн оролцооны талаарх онол, үзэл баримтлал, энэ хүрээнд хийгдсэн ажлуудыг тоймлон судалж, хэрэгжилтийг өөрийн орны бодит байдалд тулгуурлан авч үзэх,
- Судалгааны ажлын хүрээнд хамаарах бодлого, хууль тогтоомжийн байдалд шинжилгээ хийх,
- Манайд хэрэгжиж буй иргэдийн оролцооны хэлбэр болох Иргэний танхим, түүний Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хуваарилалтад гүйцэтгэх үүргийг онцгойлон авч үзэх,
- Орон нутаг дахь иргэний оролцоо, Иргэний танхим, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны талаарх иргэдийн санал бодлыг тандан судлах,
- Дээрх асуудлуудтай холбоотой санал, зөвлөмж боловсруулах зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаа.

Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт

Судалгааны хамрах хүрээ. Судалгааны объектод хамаарах асуудлыг нийслэлийн Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг, Өвөрхангай, Баянхонгор, Хэнтий, Сүхбаатар, Төв, Дундговь аймгуудын сонгож авсан сумдыг хамруулан судална.

Судалгааны түүвэр. Судалгааны түүврийг хийхдээ оролцогчдын байршил болон нас, хүйсийн харьцаа, ажил хөдөлмөр эрхлэлт, боловсролын түвшин зэргийг бүрэн төлөөлүүлэхийг эрмэлзсэн бөгөөд түүнийг судалгааны хамрах хүрээг тогтоох чухал шалгуур болгон авч үзлээ. Судалгаанд хамруулах албан хаагч, өрхийн хүрээг тогтоохдоо түүвэрлэлтийг хэд хэдэн үе шаттайгаар хийсэн. Уг судалгаанд нэгжийн түүвэрлэлтийг хүн амын тооллогын дүн, статистикийн мэдээлэлд тулгуурлан хийлээ.

Түүвэр олонлогийн хэмжээг тодорхойлохдоо түүний хэмжээг эх олонлогийн хэмжээтэй шууд хамааралтай байдлаар тогтоох хувь тэнцүүлсэн магадлалын аргыг хэрэглэлээ. Эдгээрийг иш үндэс болгон энэхүү судалгаанд хэрэглэх түүврийн загварыг боловсруулж, бүх аймаг, дүүргийн төлөөлөл байдлаар тооцоолсон болно. Судалгааны түүвэрлэлтэнд хамаарах гол ойлголтуудыг дор тодотгов. Үүнд:

Анхдагч нэгж: Судалгааны анхдагч нэгж буюу холбогдох чиглэлээр мэдээлэл өгөх хүмүүсийг *нэгдүгээрт*, орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын удирдлага, албан хаагчид, *хоёрдугаарт*, тухайн орон нутагт оршин суугаа өрх, энэ өрхийг төлөөлсөн өрхийн гишүүн байхаар сонгон авлаа.

Эх олонлог: Судалгааны эх олонлог нь судалгаанд хамруулахаар сонгосон орон нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчид, тухайн орон нутгийн нийт өрх юм.

Түүвэрлэлтийн арга: Судалгаанд магадлалт түүвэрлэлтийн нэг хэлбэр болох пропорциональ санамсаргүй түүвэрлэлтийн аргыг ашиглан аймаг нийслэл, сум, дүүрэг, баг, хороо тус бүрээс тодорхой төлөөллийг хамрууллаа.

Түүвэр олонлог: Эх олонлогийн хэмжээтэй уялдуулан түүвэр олонлогийг сонгох ерөнхий зарчимд тулгуурлан нийт эх олонлогийн 0,5 хувийг судалгаанд хамруулахаар төлөвлөсөн ба үүнээс түүвэр олонлогийн оновчтой хэмжээ буюу судалгаанд хамрагдах өрхийн тоо 1192 болж байгаа юм.

Нэг өрхийг нэг хэрэглэгч гэж үзэж, өрх бүрээс нэг хүнийг сонгож, асуулгын хуудас бөглүүлэх техникийг баримталсан болно.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан өрхийн тоо

Аймаг, дүүрэг	Өрхийн тоо	Судалгаанд хамруулахаар төлөвлөсөн өрхийн тоо	Судалгаанд хамрагдсан өрхийн тоо
Хангайн бүс			
Баянхонгор	23796	119	155
Өвөрхангай	32421	162	176
Төвийн бүс			
Дундговь	13282	66	148
Төв	27277	136	129

Зүүн бүс			
Сүхбаатар	16413	82	150
Хэнтий	21853	110	120
Улаанбаатар бүс			
Чингэлтэй	65423	327	331
Сонгинохайрхан	37914	190	194
Нийт	238379	1192	1403

Эх сурвалж: 1. Нийслэлийн ЗД-ын дэргэдэх Статистик мэдээллийн алба, Монгол улсын хүн амын үндсэн үзүүлэлтүүд, УБ., 2010 он
2. http://www.1212.mn/contents/map/map.jsp?pOrgId=976&pTblId=DT_NS0_0300_006V

Судалгааны арга зүй

Орон нутаг дахь иргэдийн оролцоог хангах нөхцөл боломж бүрдсэн эсэхийг орон нутаг дахь иргэдийн оролцоог хангах бодлого, хөтөлбөр, хууль, арга хэмжээний хэрэгжилт, оролцооны хэлбэрүүдийн өнөөгийн байдалтай нь уялдуулан шинжиллээ.

Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ:

- 1) Тухайн судалгаатай холбоотой онол, арга зүйн бүтээл, судалгааны тайлан зэрэг хоёрдогч эх сурвалжуудаар мэдээллийн сан бүрдүүлж баримт бичиг судлах, харьцуулан шинжлэх аргыг хэрэглэв.
- 2) Орон нутаг дахь иргэдийн оролцоог хангах чиглэлээр хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгүүдэд агуулгын шинжилгээ хийлээ.
- 3) Орон нутаг дахь иргэдийн оролцоо, иргэний танхим, ОНХС-ийн үйл ажиллагааг шинжлэхдээ тодорхой аймгууд, сум, нийслэл, дүүргийг сонгон авч статистик мэдээ тайлан, тоон болон чанарын мэдээллийг ашиглан дүн шинжилгээ хийж, нэгтгэн дүгнэх аргыг ашиглав.
- 4) Орон нутаг дахь иргэдийн оролцоог хангах чиглэлээр ажиллаж буй албан хаагчид, судлаачид, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, иргэдийн санаа бодлыг асуулга, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага зэрэг шинжилгээний аргуудыг ашиглан судаллаа.

Судалгааны хүрээнд доорх аргуудыг өргөн хүрээнд ашигласан бөгөөд энэ нь орон нутагт иргэдийн оролцоог хангах чиглэлээр тулгамдсан асуудлуудыг бодитой тодорхойлж, орон нутагт үзүүлж буй үр нөлөө, цаашид анхаарах асуудлуудыг үндэслэл сайтай тодорхойлоход дөхөм үзүүлсэн болно.

Баримт бичгийн судалгаа. Судлаж буй асуудалтай холбогдох ном зохиол, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, дүрэм журмуудыг судлав.

Ярилцлагын арга. Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагыг орон нутгийн албан хаагчид, иргэдийн дунд зохион байгуулж, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар мэдээлэл цуглуулав.

Ажиглалтын арга. Иргэдийн оролцоог хангах талаар төрөөс явуулж буй бодлого, түүнийг орон нутагт зохион байгуулж буй байдал, үр дүнгийн талаарх мэдээллийн үнэн бодит байдлыг хангах үүднээс ажиглалтын аргыг өргөн хэрэглэсэн болно.

Харьцуулалтын арга. Шууд ардчилал-иргэдийн оролцоо, Иргэний танхим, ОНХС-гийн үйл ажиллагаатай танилцаж, аймаг, сум, баг, хороодын үйл ажиллагааг харьцуулан жишиж, тулгамдаж буй нийтлэг асуудлын учир шалтгааныг илрүүлэх оролдлого хийсэн болно.

Санал асуулгын арга. Орон нутаг дахь иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж буй ажлын үр дүн иргэдэд хэр хүрч байгааг тандах үүднээс баримт бичгийн шинжилгээний үр дүн, мэдээлэлд тулгуурлан санал асуулгын хуудас боловсруулж, анхдагч мэдээлэл цуглуулж ажиллаа.

БҮЛЭГ 1

ШУУД АРДЧИЛАЛ-ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



1. ШУУД АРДЧИЛАЛ-ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээрээ шууд ардчилал-иргэдийн оролцоонд ихээхэн ач холбогдол өгч, түүнийг хэрэгжүүлэх бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлэх, оролцооны олон янзын арга хэрэгслүүдийг туршиж хэрэглэх, заавар журам, гарын авлага гаргах зэрэг олон ажлууд өрнөж байна. Манай оронд ч гэсэн энэ чиглэлээр санал санаачлага гарч, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж тодорхой ажлууд хийж эхэлсэн. Ялангуяа Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс энэ асуудалд онцгой анхаарч тодорхой асуудлаар иргэдийн санаа бодлыг сонсох, хэлэлцүүлэг өрнүүлэх, шийдвэр гаргахад иргэдийг оролцуулах зэрэг боломжийг олгох зорилгоор “Иргэний танхим” байгуулан ажиллуулж байна¹. Энэ талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

Энэ бүлэгт шууд ардчилал-иргэдийн оролцооны ойлголт, үе шат, хэлбэр, арга хэрэгслүүд болон Европын зарим орны туршлагыг авч үзлээ.

1.1 Шууд ардчилал-иргэдийн оролцооны ойлголт

Шууд ардчилал-иргэдийн оролцооны асуудал сүүлийн жилүүдэд ихээхэн яригдах болсон нь *нэгдүгээрт* засаглалын үзэл баримтлалын хүрээнд оролцоог чухалчилдагтай, *хоёрдугаарт* иргэдийн олонхи улс төрийн намууд болон улс төрчдийн гаргаж буй улс төрийн шийдвэрт сэтгэл хангалуун бус байдагтай, *гуравдугаарт* иргэдийг төлөөлж бүх түвшинд мандат авсан улс төрчид ихэнх тохиолдолд иргэдийг бүрэн төлөөлж чадахгүй байна гэж үзэж буйтай холбоотой юм. Шууд ардчилал-иргэдийн оролцоо нь төлөөллийн ардчилалд суурилсан өнөөгийн улс төрийн тогтолцоог халах букоу орлох гэхээсээ илүү түүний сул тал, дутагдлыг засаж залруулах зорилготой. Энэ нь мөн “Олны хүч оломгүй далай” гэдэг шиг нийгэмд байгаа идэвхитэй иргэдийн асар их хүч нөөцийг ашиглах тухай асуудал юм.

Шууд ардчиллыг нилээдгүй тохиолдолд дараах хоёр утгаар ойлгодог². *Нэгдүгээрт*, ард нийтийн санал асуулгад тулгуурлан эрх мэдлийг шууд ард түмэн хэрэгжүүлдэг нийгмийн зохион байгуулалтын хэлбэр, *хоёрдугаарт*, иргэдийн оролцоотойгоор шийдвэр гаргадаг улс төрийн арга гэж үздэг. Иргэдийн оролцоотой шийдвэр гаргадаг энэ арга нь төлөөллийн ардчиллын тогтолцооны нэг хэсэг байж болдог байна. Бид энд сүүлийн хоёрдахь утгаар нь авч үзсэн болно.

Иргэдийн оролцоо гэж улс төрийн шийдвэр гаргах үйл явц болон томоохон төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөх явцад иргэдийг оролцуулахыг хэлдэг. Иргэдийн оролцоо бол хүн төрлөхтний түүхийн явцад хамтын ажиллагааны зохион байгуулалтын дээд хэлбэрт хүрэх гэсэн байнгын тэмүүлэл юм³. Зарим оронд

1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хийж буй шууд ардчилал, иргэдийн оролцоотой холбоотой ажлуудыг “Шууд ардчилал-иргэдийн оролцоо” гарын авлагаас дэлгэрэнгүй үзэх боломжтой.
2 Энэ талаар http://de.wikipedia.org/wiki/Direkte_Demokratie хаягаар орж дэлгэрэнгүй үзнэ үү (2014 оны 11 дүгээр сарын 19-ний 17 цаг 47 минутад хандсан хандалт).
3 Martin A.Novak, Five rules for the evolution of cooperation. In Science. 314. Nr. 5805, 2006-12-08, p. 1560-1563, PMC 3279745 (<http://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC3279745/>), мөн <http://www.forschungsstelle-direkte-demokratie.de/>.

төсвийн төлөвлөлт хийхэд иргэдийг өргөнөөр оролцуулдаг болсон байна. Манай оронд 2012 оноос “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн төлөвлөлтөд иргэд оролцох боломж нээгдсэн⁴.

Иргэдийн оролцооны тухай ойлголт өнөөг хүртэл нэг мөр болоогүй байна. Тухайлбал, шууд ардчиллын чухал илэрхийлэл болох “Ард нийтийн санал асуулга”-ыг иргэдийн оролцооны хэлбэр гэж үзэх үү гэдэг асуудлаар судлаачид санал зөрдөг. Ер нь иргэдийн оролцооны их олон арга хэлбэр бий. Тухайлбал, иргэд улс төрийн сонгуульд саналаа өгөх, жагсаал цуглаанд оролцох, тодорхой асуудлаар гарын үсэг цуглуулах гэх мэт олон арга хэлбэрээр шийдвэр гаргахад оролцож болдог. Бидний энд авч үзэж буй иргэдийн оролцооны асуудал бол засаг захиргааны байгууллагууд шийдвэр гаргах, төлөвлөх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаандаа иргэдийг зориуд зохион байгуулалттайгаар оролцуулж тэдэнд мэдээлэл өгөх, саналыг нь сонсох, асуудлыг хамтран хэлэлцэх тухай юм. Орон нутгийн бүх шатны хурлын болон засаг захиргааны байгууллагууд үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод, хяналттай явуулахад иргэдийн оролцоо чухал байдаг. Түүнээс гадна иргэдийг асуудал шийдэхэд оролцуулснаар иргэд идэвхижиж өөрөө өөрийнхөө төлөө, оршин суугаа нутгийнхаа хөгжлийн төлөө санаачилга гарган ажиллах боломж олдоно. Ингэж идэвхи санаачлагатай иргэдийг дайчлан зарим асуудлыг тэдний оролцоо, дэмжлэг туслалцаатайгаар шийдсэнээр захиргааны байгууллагын зардал буурч, ажлын ачаалал багасах боломж ч бүрддэг байна.

Гадаадын зарим улсуудад тухайлбал, Европын Холбооны улсуудад иргэдийн оролцоо явцуу утгаараа зөвхөн орон нутгийн түвшинд л хэрэглэгддэг байна. Манай улсад ч гэсэн Үндсэн хуулиндаа зөвхөн баг, хорооны төвшинд шууд ардчиллын хэлбэрээр, иргэдийн шууд оролцоотойгоор асуудлыг шийдэхээр зохицуулж өгсөн байдаг. Харин бусад төвшинд төлөөллийн ардчиллын зарчмаар асуудлыг шийдэхээр хуульчилсан. Гэсэн хэдий ч дээр дурдсанчлан сүүлийн жилүүдэд гадаадын олон оронд төдийгүй манай оронд ч иргэдийн оролцоог бүхий л түвшинд нэмэгдүүлэх хүсэл эрмэлзлэл бий болжээ.

Ер нь оролцооны аргаар асуудлыг шийдэхдээ иргэдийг бүхэлд нь буюу тодорхой бүлэг хүмүүсийг оролцуулж (залуучууд, өндөр настанууд, тодорхой нутаг дэвсгэрийн оршин суугчид г.м.) шийдэх боломжтой байдаг байна. Түүнээс гадна иргэдийн оролцооны олон үе шат бий.

1.2 Иргэдийн оролцооны үе шат, хэлбэр, арга хэрэгслүүд

Иргэдийн оролцоо иргэдэд мэдээлэл өгөхөөс эхлээд тэдэнд шийдвэр гаргах бүрэн эрхийг нь өгөх хүртэл янз бүрийн үе шаттай байдаг. Иргэдийн оролцооны үе шат доороосоо дээшээ ахих тусам иргэдийн зүгээс нөлөөлөх нөлөөлөл нь улам бүр нэмэгддэг байна.

Иргэдийн оролцооны анхан шат нь тэдэнд бодитой бөгөөд тэнцвэртэй *мэдээлэл өгөх (inform)* явдал юм. Дараагийн шатанд иргэд төрийн байгууллагаас *зөвлөгөө авах (consult)* замаар асуудалд дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах өөр саналын хувилбар дэвшүүлэх боломжтой болдог. Үүний дараагийн шат

4 “Төсвийн тухай” Монгол Улсын хууль, 2011 он.

нь шийдэх гэж байгаа асуудалд иргэдийг *татан оролцуулах (involve)* замаар тэдний хүсэл эрмэлзлэлийг мэдэхээс гадна уг асуудлаарх тэдний эргэлзээг тайлахад чиглэгддэг. Иргэдийн оролцооны илүү боловсронгуй шат нь улс төр, захиргааны зүгээс иргэдийг хамтран ажиллагч түншээ гэж үзэж шийдвэрийн төсөл дээр хамтдаа янз бүрийн хувилбаруудыг олох, хамтын шийдвэр гаргах зорилгоор *хамтран ажиллах (cooperate)* боломжийг эрж хайх явдал юм. Иргэдийн оролцооны хамгийн дээд шат нь *иргэдээ хүчтэй болгож, тэдэнд шийдвэр гаргах бүрэн эрхийг нь өгөх (Empowerment)* юм. “Ардчилал бол ард түмний ноёрхол” гэсэн томъёолол энд жинхэнэ утгаараа хэрэгжинэ.

Иргэдийн оролцооны асуудлаар мэргэшсэн Америкийн судлаач Ш.С.Арнштайн (1969) “Ladder of Citizen Participation” буюу “Иргэдийн оролцооны шатлал” гэсэн загвар боловсруулсан байдаг (Зураг 1-ийг үзнэ үү). Дээрх үе шатууд ч гэсэн энэ загварт үндэслэсэн ангилал юм⁵.



Зураг 1. Оролцооны шатлал⁶

Ш.С.Арнштайн энэ загвараа улс төр, захиргааны байгууллагын зүгээс шийдвэр гаргахад иргэдийг оролцуулах зорилгоор боловсруулсан байна. Иргэдийн зүгээс шийдвэр гаргахад нөлөөлж оролцох өөр олон боломж байдгийг

5 Arnstein, S.R. (1969). A Ladder of Citizen Participation. In AIP Journal. July 1996. p. 216-224. Энэ талаар мөн НҮБ-аас эрхлэн гаргасан, 2008 онд орчуулагдан хэвлэгдсэн “Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар” номоос дэлгэрүүлэн үзнэ үү.

6 Patrizia Nanz, Miriam Fritsche (2012). Handbuch Buergerbeteiligung: Verfahren und Akteure, Chancen und Grenzen, Bonn, S. 23.

дээр цухас дурдсан байгаа. Ийм боломжуудыг уг загвар харгалзан үзээгүй байна. Түүнээс гадна оролцооны чанарын асуудлаар уг загвар ямар ч мэдээлэл өгдөггүй. Гэхдээ улс төр, захиргааны байгууллагын зүгээс иргэдийг ямар үе шатанд хэрхэн оролцуулах вэ гэдгийг шийдэхэд энэ загвар чухал ач холбогдолтой юм.

Оролцооны асуудал нь нийгмийн тодорхой бүлгүүдийн *төлөөллийн* асуудлыг хөндөж байдаг. Ямар төлөөллийг оролцуулах, ямар төлөөллийг оролцуулахгүй байх вэ гэдэг нь шийдэх ёстой чухал асуудлын нэг юм. Оролцооны аргаар асуудлыг шийдэхэд шийдвэрийн *хүчин төгөлдөр* буюу *хуульд нийцэн албан ёсны* болж чадаж байна уу гэдэг нь шийдвэрлэх ач холбогдолтой байдаг. Тийм учраас иргэдийн оролцоонд ямар арга хэрэгсэлийг сонгох вэ гэдгийг бодох хэрэгтэй юм. Америкийн судлаач А.Фанг (2006) оролцооны арга хэрэгсэлийг сонгохдоо дараах зүйлсийг харгалзах хэрэгтэй гэсэн байна⁷. Үүнд:

- Үргэлжлэх хугацаа, оролцогчдын тоо зэрэг зохион байгуулалтын асуудал,
- Оролцогчдыг сонгох асуудал,
- Энэ удаагийн арга хэмжээнд коммуникацийн ямар хэлбэр илүү давамгайлах,
- Сонгох арга хэрэгсэл нь ямар үүрэгтэй болох асуудлууд багтана.

Иргэдийн оролцооны хэлбэр

Иргэдийн оролцооны үндсэн хоёр хэлбэр байдаг. Нэгдэх нь хуулиар тогтоосон *албан ёсны оролцоо*, хоёрдахь нь иргэдийн *сайн дурын оролцоо* буюу *албан бус оролцоо* юм. Иргэдийн оролцооны албан ёсны хэлбэрийг хууль тогтоогчид нарийн хуульчилж өгдөг байна. Тухайлбал, иргэд ямар үе шатанд яаж оролцох, ямар хил хязгаарыг давахгүй байх зэрэг нарийн зохицуулалтуудыг хийж өгдөг. Иргэдийн сайн дурын оролцооны тухайд нэг талаар гүйцэтгэх засаглал буюу орон нутгийн засаг захиргааны зүгээс дээрээс нь санаачлага гаргах эсвэл иргэдийн зүгээс доороос санаачилга гаргах гэсэн хоёр боломж бий.

Албан ёсны оролцоо

Шийдвэр гаргах үйл явцад иргэдийг албан ёсоор оролцуулах асуудлыг ардчилал өндөр хөгжсөн орнуудад нарийн хуульчилж өгсөн байдаг. Ингэхдээ нэг талаар шууд ардчиллын арга хэрэгсэлээр, нөгөө талаар тодорхой хуулиудаар иргэдийг тодорхой асуудлаар шийдвэр гаргахад заавал оролцуулж байхаар заадаг. Манай улсад ч гэсэн иймэрхүү зохицуулалтууд бий болж байна.

Орон нутгийн иргэд шууд ардчиллын замаар иргэдийн хурал болон захиргааны байгууллагууддаа өргөдөл гарган хүсэлт тавих замаар асуудлаа шийдүүлдэг. Үүнийг *иргэдийн санаачлага* гэж нэрлэдэг. Хэрвээ энэ нь бүтэхгүй бол иргэд нэгдэж *шаардлага* хүргүүлж болдог. Ингээд бүтэхгүй бол орон нутгийн *нийт иргэдийн санал* асуулга явуулж, тэдний олонхийн саналаар асуудлыг шийдэх боломж бас байдаг байна. Мэдээж улсын хэмжээний томоохон асуудлуудыг *ард нийтийн санал асуулгаар шийдэх* боломжтой юм. Энэ бүхэн бол ардчилсан улс орнуудад хуульчлагдсан, зохион байгуулалттай хэрэгжүүлж болдог шууд ардчиллын арга хэлбэрүүд юм.

7 Fung, A. (2006). Varieties of Participation in Complex Governance. In Public Administration Review. December 2006. Special Issue. p. 66-75.

А.Гроусс, Б.Кауфманн нар 2002 онд Европын 30-аад улсад шууд ардчиллын арга хэрэгсэлийг амьдралд аль хэр хэрэглэж буй талаар харьцуулсан судалгаа хийсэн байна. Тэд судалгааныхаа үр дүнд судалгаанд хамрагдсан улсуудыг дараах байдлаар ангилжээ⁸.

- *Авангардууд*: Лихтенштайн, Швейцар
- *Ардчилагчид*: Итали, Словен, Латви, Ирланд, Дани, Литва, Словак
- *Болгоомжлогчид*: Франц, Испани, Австри, Швед, Норвег, Унгар
- *Айтхайчууд*: Польш, Их Британи, Финланд, Исланд, Эстони, Белги, Люксембург, Герман, Грек, Чех
- *Найдваргүйчүүд*: Румын, Португал, Болгар, Мальт.

Тодорхой хуулиудаар зохицуулсан иргэдийн оролцооны асуудлаар уг асуудлыг ямар зорилгоор боловсруулж, төлөвлөж байгааг иргэдэд аль болох эрт мэдээлж, тэдэнд мэдээлэлд тулгуурлан санаа бодлоо илэрхийлэх боломж олгох нь чухал байдаг. Тухайн асуудлыг боловсруулж төлөвлөж буй орон нутгийн байгууллагууд уг асуудалд иргэдийг ямар хэлбэрээр оролцуулахаа өөрөө шийддэг. Энэ чиглэлээр их өргөн дэлгэрсэн иргэдийн оролцооны арга хэлбэр бол иргэдтэй хийх уулзалт юм. Түүнээс гадна боловсруулж, төлөвлөж буй асуудлаа иргэд олж үзэж болохуйц газар (засаг захиргааны байгууллага, банк зэрэг) байрлуулдаг. Сүүлийн үед өргөн хэрэглэгдэж буй оролцооны хэрэгсэл бол интернет, нийгмийн сүлжээ зэрэг мэдээллийн технологийн бусад боломжууд юм. Үүнийг цахим оролцоо ч гэж нэрлэдэг. Энэ нь мэдээллийг шуурхай бөгөөд хялбар түгээх боломж олгохоос гадна иргэдийн саналыг богино хугацаанд авах боломж бас олгоно. Мөн цахим хэлэлцүүлэг ч хийх боломжтой.

Албан бус оролцоо

Дээр авч үзсэн хуулиар тогтоосон иргэдийн оролцооны албан ёсны хэлбэрээс гадна албан бус оролцооны олон арга хэлбэрүүд бий. Иргэдийн оролцооны албан бус хэлбэр нь ихэнхдээ иргэдийн өөрсдийн идэвхи санаачлагаар зохион байгуулагддаг. Гэхдээ тэдний сайн дураараа оролцож зохион байгуулсан ажлын үр дүн нь улс төр, захиргааны байгууллагын шийдвэрт тусгалаа олдог байх ёстой. Ингэж чадахгүй бол иргэдийн ихэнх нь санаачлага гаргахгүй, аливаа асуудалд оролцохгүй, идэвхигүй байдалд шилждэг байна. Иргэдийн оролцооны энэ хэлбэр нь иргэд, улс төрчид, захиргааны байгууллагын ажилтнуудын хооронд идэвхитэй, үр дүнтэй, харилцан ойлголцсон яриа хэлэлцээр хийгдэхэд чиглэгдэнэ.

Эдгээрээс гадна иргэдийн оролцооны олон арга хэрэгслүүд байдаг бөгөөд тэдгээрийг дор хүснэгтээр харууллаа⁹. Хүснэгтэнд дурдсан арга хэрэгсэл бүхэн тодорхой зориулалт, зорилготой, нарийн зохион байгуулалт, дараалалтай, үргэлжлэх хугацаа, оролцогчдын тооны хязгаартай байдаг. Иргэдийн оролцоог жинхэнэ утгаар нь хөгжүүлбэ гэвэл эдгээр арга хэрэгслүүдийг нарийн судалж, туршиж нэвтрүүлэх явдал чухал юм. Уншигчдад ойлгомжтой байх үүднээс энэ арга хэрэгслүүдээс “National Issues Forum” (Үндэсний хэмжээний асуудлаарх форум)-ыг жишээ болгон дэлгэрүүлэн авч үзье.

8 Andreas Gross, Bruno Kaufmann (2002). IRI Europa Laenderindex zur Volksgesetzgebung 2002. Ein Design- und Ratingbericht zu den direktdemokratischen Verfahren und Praktiken in 32 europaischen Staaten, Amsterdam 2002, S. 13 (http://www.aktion-volksabstimmung.de/uploads/media/Europa_Laenderindex_2002_03.pdf).

9 Bertelsmannstiftung (2012). Politik erleben, Buerger beteiligen: Charakteristika neuer Beteiligungsmodelle. Guetersloh, 2. Auflage, S. 68-69.

Хүснэгт 2. Иргэдийн оролцооны арга хэрэгсэл

Арга хэрэгсэл	Зорилго/Үйл ажиллагаа	Гол асуудлууд	Хамрах хүрээ	Гол захиалагч	Үргэлжлэх хугацаа	Оролцогчдын тоо, сонголт	Гол санаачлагч, эрх эзэмшигч	Түтсэн байдал
Эдгээ цагийн хотын цуглаан (21 st Century Town Meeting)	Шийдвэр гаргагчидын зөвлөгөөг сонсох, зөвлөлдөх, хамтарч шийдэх	Орон нутгийн хөгжил болон бодлогын асуудлаар мэдээлэл өгөх эсвэл шийдвэр гаргах	Орон нутгийн болон үндэсний хэмжээний асуудлууд	Орон нутгийн болон бусад захиргааны байгууллагууд	Нэг өдөр эсвэл нэг удаагийн цугларалт	500-5000 хүн, 10-12 хүнтэй бичил бүлэгт хуваагдан ярилцана;	AmericaSpeaks	Гол төлөв АНУ
Хүндэтгэлтэйгээр тандан судлах (Appreciative Inquiry)	Олон нийгэд болон нийгэмд бүхэлд нь нөлөө үзүүлэх	Урт хугацааны зорилго, арга хэмжээг төлөвлөх	Байгууллагын дотоод асуудал	Аж ахуйн нэгж, орон нутаг, захиргааны байгууллагууд	Ерөнхийдөө нэг өдөр, шаардлагатай гэж үзвэл хэдэн жил ч үргэлжилж болно	10-2000 хүн; өөрөө сонголт хийх, тохиолдлын болон зориудын сонголт хийх боломжтой	David Cooper- rider, Case Western Reserve University	Гол төлөв АНУ, Их Британи
Иргэдийн үнэлгээ/Төлөвлөлтийн нэгж	Шийдвэр гаргагчидын зөвлөгөөг сонсох, олон нийтийн хэлэлцүүдэд нөлөөлөх	Орон нутгийн буюу бүс нутгийн тодорхой асуудлууд, төлөвлөлтийн асуудлууд	Орон нутгийн болон бүс нутгийн түвшиний асуудлууд	Орон нутгийн улс төр, захиргааны байгууллагууд, эвсэл холбоод	Дор хаяж дараалсан дөрвөн өдөр	Ерөнхийдөө 100 хүн, тус бүр 25 хүнтэй бүлэг болж ажиллана; тохиолдлын сонголт	Peter C. Daniel, Вүшпергатын Их сургуулийн Иргэдийн оролцооны судалгааны газар	Гол төлөв Герман, мөн Европ
Иргэдийн төсөв	Шийдвэр гаргагчидын зөвлөгөөг сонсох, зөвлөлдөх, иргэдийн шийдвэр	Орон нутгийн санхүү (цогцоор нь буюу хэсэгчлэн)	Орон нутгийн түвшиний асуудлууд	Орон нутгийн улс төр, захиргааны байгууллагууд	Нэг өдрөөс олон жил	100-20000 хүн; Өөрсдөө сонголт хийнэ		Дэлхий даيار, гол төлөв Өмнөд Америк, Европ
Иргэдийн индэр	Шийдвэр гаргагчдын зөвлөгөө	Орон нутгийн бодлогын асуудлаар санаа болол төлөвшүүлэгчдийн судалгаа	Орон нутгийн түвшиний асуудлууд	Орон нутгийн улс төр, захиргааны санаа болол төлөвшүүлэгчдийг сонирхдог бусад оролцогчид	Жилд 3-4 удаа, нийтлээ 3-4 жил	500-2500 хүн; тохиолдлын сонголт	YouGov (eRap-e), Германц Шпайерийн Төрийн захиргааны институт	Гол төлөв Их Британи, мөн Герман

Иргэдийн зөвлөл	Олон нийтийн хэлэлцүүлэгт нөлөөлөх, зөвлөлдөх, шийдвэр гаргагчдын зөвлөгөөг сонсох	Орон нутгийн тодорхой асуудлууд, төлөвлөлтийн асуудлууд	Орон нутгийн түвшиний асуудлууд	Орон нутгийн төр, захиргааны байгууллагууд, эвсэл холбоод	Иргэдийн зөвлөл тутамд 2 өдөр, ойролцоогоор 4 сар, дараа нь шинэ иргэдийн зөвлөл (өөр хүмүүстэй)	8-12 хүн; тохиолдлын сонголт	Center for Wise Democracy	Австр, АНУ
Charlotte, Францаар машин, тэрэг гэсэн утгатай (Хотын болон бус нутгийн төлөвлөлтийг иргэдийн шууд оролцоотой хийдэг арга)	Олон нийтийн хэлэлцүүлэгт нөлөөлөх, шийдвэр гаргагчдын зөвлөгөөг сонсох	Орон нутгийн тодорхой асуудлууд, төлөвлөлтийн асуудлууд	Орон нутгийн түвшиний асуудлууд	Орон нутгийн төр, захиргааны байгууллагууд, эвсэл холбоод	Цор хаяж 4 өдөр (бэлтгэл болон уулзалтын дараах ажлуудад тус бүр 1 хоног нэмэгдэнэ), хэдэн долоо хоногийн зайтай олон удаа (2-4) уулзах боломжтой	Аль болох олон оролцогчидгүй бол төлөөлөхүүд үр дүн гарна; өөрөө сонголт хийх, мөн зориудын сонголт	National Cartrrete Institute	Гол төлөв АНУ, мөн Герман
Зөвлөлдөх санал асуулга (Deliberative Polling)	Мэдээлэл, Олон нийтийн хэлэлцүүлэгт нөлөөлөх	Олон нийтийн сонирхолд нийцэх янз бүрийн сэдэв	Орон нутгийн түвшиний болон үндэстэн дамнансан асуудлууд	Улс төрийн шийдвэр гаргагчид	2 удаагчсан дараалсан санал асуулга, түүний дундуур 2-3 өдрийн үечлэлтэй мэдээлэл өгөх	300-500 хүн; тохиолдлын сонголт (тодорхой шалгуураар)	James S. Fishkin, Center for Deliberative Democracy	Дэлхий даيار, гол төлөв АНУ
Тохиролцооны бага хурал/ Иргэдийн бага хурал	Олон нийтийн хэлэлцүүлэгт нөлөөлөх, зөвлөлдөх, шийдвэр гаргагчдын зөвлөгөөг сонсох	Олон нийтийн сонирхолд нийцэх эсрэг тэсрэг сэдвүүд	Орон нутгийн түвшиний болон үндэстэн дамнансан асуудлууд	Захиргааны байгууллагууд	3 өдрийн бага хурал, 2 удаагийн бэлтгэл ажлын уулзалт	10-30 хүн; тохиолдлын сонголт	Дани улсын Техникийн үр дагаврыг урдчилан тооцох газар	Гол төлөв Дани улс, мөн Европын бусад орнууд

Арга хэрэгсэл	Зорилго/Үйл ажиллагаа	Гол сэдвүүд	Хамрах хүрээ	Гол захиалагч	Үргэлжлэх хугацаа	Оролцогчдын тоо, сонголт	Санаачлагч, эрх эзэмшигч	Хаана хэрэглэгддэг
Зуучлах хэлэлцүүлэг (Mediation)	Шийдвэр гаргагчидын зөвлөгөөг сонсох, олон нийтийн хэлэлцүүлэгт нөлөөлөх	Олон нийтийн сонирхолд нийцэх эсрэг тэсрэг сэдвүүд	Гол төлөв орон нутгийн болон бүс нутгийн түвшиний асуудлууд	Орон нутгийн улс төр, захиргааны байгууллагууд эсвэл тэдэнтэй ойролцоо байгууллагууд	1-2 хоногоос хэдэн жил сонголт	10-100 хүн; зориулалтын сонголт		Гол төлөв Герман, мөн Европын бусад орнууд
Дотоодын асуудлаарх форум (National Issues Forum)	Мэдээлэл авах	Нийгэмд хамаатай асуудлуудаар мэдээлэл олж авах, шаардлагатай үед шийдвэр гаргагчидтай холбогдох	Гол төлөв орон нутгийн түвшиний асуудлууд	Орон нутаг, боловсролын байгууллагууд	1-2 хоног	10-20 хүн; өөрөө сонголт хийх	National Issues Forum Institut	АНУ
Задгай талбайн конференц (Open-Space-Konferenz)	Олон нийгэд болон нийгэмд нөлөөлөх	Янз бүрийн сэдвээр санал, санаануудыг цуглуулах	Орон нутгийн түвшиний болон үндэстэн дамнанасан асуудлууд, байгууллагын асуудлууд	Захиргааны байгууллагууд, эвсэл холбоод, сүм хийдүүд, боловсролын байгууллагууд, аж ахуйн нэгжүүд	1-5 хоног	20-2000 хүн; өөрөө сонголт хийх	Harrison Owen	Дэлхий даяар, гол төлөв АНУ, Герман
Тодорхой нутаг дэвсгэр дээрх хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн төлөвлөлтийн арга (Planning for Real)	Олон нийгэд болон нийгэмд нөлөөлөх, зөвлөлдөх	Орон нутгийн болон бүс нутгийн тодорхой асуудлууд, төлөвлөлтийн асуудлууд	Орон нутгийн болон бүс нутгийн түвшиний асуудлууд	Орон нутгийн улс төр, захиргааны байгууллагууд, эвсэл холбоод	Тодорхой хугацаанд хэдэн долоо хоног үргэлжилсэн олон тооны арга хэмжээнүүд	Хязгааргүй; өөрөө сонголт хийх	Tony Gibson, Neighbourhood Initiatives Foundation, Германд Берлиний Технологийн сүлжээ ТББ	Гол төлөв Их Британи, мөн Герман


Сценар зохиох ажил хэргийн уулзалт/Сценар зохиох бага хурал	Олон нийтэд болон нийгэмд нөлөөлөх, зөвлөлдөх, шийдвэр гаргагчидын зөвлөгөөг сонсох	Ирээдүйн хөгжлийн талаарх төсөөлөл, янз бүрийн сэдэвтэй холбогдолтой санаа бодлоос санаа авах	Орон нутгийн түвшиний болон үндэстэн дамнасан асуудлууд, байгууллагын асуудлууд	Захиргааны байгууллагууд, эвсэл холбоод, сүм хийдүүд, боловсролын байгууллагууд, аж ахуйн нэгжүүд	1-3 өдрийн багц арга хэмжээнүүд эсвэл хэд хэдэн удаагийн уулзалт	Нэг бүлэгт 25-30 хүн, олон бүлгүүд зэрэг ажиллаж болно; зориудын сонголт	Гол төлөв Европ
Бүх нийтийн кафе ярилцлага (World Café)	Олон нийтэд болон нийгэмд нөлөөлөх	Өргөн хүрээтэй ашиглаж болно	Орон нутгийн түвшиний болон үндэстэн дамнасан асуудлууд, байгууллагын асуудлууд	Захиргааны байгууллагууд, эвсэл холбоод, сүм хийдүүд, боловсролын байгууллагууд, аж ахуйн нэгжүүд	Нэг удаа 20-30 минут үргэлжилсэн олон удаагийн ярилцлага	12-1200 хүн; өөрөө сонголт хийх	Гол төлөв АНУ, Их Британи, мөн Европын бусад орнууд
Ирээдүйн бага хурал	Олон нийтэд болон нийгэмд нөлөөлөх, зөвлөлдөх, шийдвэр гаргагчидын зөвлөгөөг сонсох	Ирээдүйн хөгжлийн талаарх төсөөлөл, янз бүрийн сэдэвтэй холбогдолтой санаа бодлоос санаа авах	Байгууллагын асуудлууд, мөн орон нутгийн түвшиний асуудлууд	Захиргааны байгууллагууд, орон нутаг, эвсэл холбоод, аж ахуйн нэгжүүд г.м.	2-3 хоног	64 (36, 49, 81) хүн; зориудын сонголт	Гол төлөв АНУ, Их Британи, мөн Герман
Ирээдүйн ажлын байр	Олон нийтэд болон нийгэмд нөлөөлөх, зөвлөлдөх, шийдвэр гаргагчидын зөвлөгөөг сонсох	Ирээдүйн хөгжлийн талаарх төсөөлөл, янз бүрийн сэдэвтэй холбогдолтой зөвлөмжүүд гаргах	Байгууллагын асуудлууд, мөн орон нутгийн түвшиний асуудлууд	Захиргааны байгууллагууд, орон нутаг, эвсэл холбоод, аж ахуйн нэгжүүд г.м.	2-3 хоног	5-200 хүн; өөрөө сонголт хийх (Жирийн бүлэг хүмүүсээс)	Герман хэлтэй орнууд, ялангуяа Австр

*Үндэсний хэмжээний асуудлаарх форум (National Issues Forum)*¹⁰

Үндэсний хэмжээний асуудлаарх форум нь АНУ-д өргөн дэлгэрсэн байдаг. Энэ арга хэрэгсэл улс төрийн тодорхой сэдвүүдээр хөтлөгчийн тусламжтайгаар хэлэлцүүлэг өрнүүлж иргэдэд ардчилсан арга барил, хэлэлцүүлэг өрнүүлэх чадвар эзэмшүүлэх дасгал сургууль болдог. Үүнд оролцогчид хэлэлцэж байгаа асуудлыг заавал мэддэг байх албагүй. Нэг удаагийн хэлэлцүүлэгт сайн дураараа, өөрийн сонирхолоор бүртгүүлсэн 10-20 иргэн оролцоно. Энэ хүмүүст хэлэлцэж буй асуудалтай холбоотой, түүнийг олон талаас нь авч үзсэн өргөн хүрээтэй мэдээллийг өгч энэ мэдээлэлд тулгуурлан шийдлийн янз бүрийн саналуудыг гаргах боломж олгоно. Оролцогчид хэлэлцэж буй сэдэвтэй холбоотой асуудлаар санаа бодлоо солилцож ярилцах үүднээс дор хаяж нэг өдөр, ихэнхдээ хоёр өдөр цуглаж ярилцдаг.

“Үндэсний хэмжээний асуудлаарх форум”-аар хэлэлцсэн асуудлыг шийдвэрлэх саналыг улс төр, захиргааны шийдвэр гаргах түвшиний хүмүүст хүргэж, шаардлагатай тохиолдолд тэдэнтэй ярилцлага өрнүүлж болдог. Гол нь асуудлыг янз бүрийн өнцгөөс нь хэлэлцэж энэ явцдаа оролцогч иргэдийг мэргэшүүлэх, нийгмийн чадамжийг нь хөгжүүлэх зорилготой.

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ АСУУДЛААРХ ФОРУМ



10 Bertelsmannstiftung (2012). Politik beleben, Buerger beteiligen: Charakteristika neuer Beteiligungsmodelle. Guetersloh, 2. Auflage, S. 34-36.

Энэ Форумыг нутгийн захиргааны байгууллагууд, дунд сургууль, их дээд сургууль, бас бусад байгууллагууд ч өргөн хэрэглэдэг. АНУ-д эрүүл мэндийн, эрчим хүчний, сургуулийн бодлогын зэрэг орон нутгийн холбогдолтой янз бүрийн сэдвээр ийм хэлэлцүүлгүүдийг хийдэг байна.

АНУ-ын ашгийн бус байгууллага болох “National Issues Forums Institut” янз бүрийн асуудлуудаар жил бүр бүх муж улсуудад National Issues Forum-ийг зохион байгуулдаг. Тухайлбал, 2008 онд эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн асуудал, 2007 онд эрчим хүчний хямралын асуудал хэлэлцүүлгийн гол сэдвүүд байжээ. 2008 онд 40 муж улсад 138 хэлэлцүүлэг зохион байгуулагдаж түүнд 1000 гаруй иргэн оролцсон байна. 2007 онд 120 орчим хэлэлцүүлэг хийж түүнд нийтдээ 800 орчим иргэнийг хамруулжээ.

1.3 Европын зарим орны туршлага

Европын холбооны улсууд 2007 онд батлагдаж 2009 онд хэрэгжсэн “Лиссабоны гэрээ”-ээр улс төрийн шийдвэр гаргах үйл явцад болон иргэдийн үзэл бодлыг төлөвшүүлэхэд Европын иргэдийг ардчиллын суурь зарчмуудад тулгуурлан оролцуулж байхыг заасан байдаг¹¹. Үүний үндсэн дээр 2012 оны 4 дүгээр сараас “*Европын иргэдийн санаачлага*” гэсэн иргэдийн оролцооны арга хэрэгсэлийг Европын гишүүн орнуудад албан ёсоор нэвтрүүлэх шийдвэр гаргасан байна¹². Энэ арга хэрэгсэлийн дагуу Европын холбооны иргэд тэдний нийтлэг эрх ашгийг хөндсөн асуудлаар санал бодлоо нэгтгэж, тэр ч байтугай хуулийн төсөл санаачлан шийдвэр гаргагчдад хүргүүлэх боломжтой болсон байна. Гэхдээ энэ нь маш нарийн зохицуулалттай байдаг. Тухайлбал, Австри улсад 14000-аас дээш иргэн нэгдэж санаачлага гаргасан тохиолдолд түүнийг Европын холбоонд хүргүүлэх боломжтой болдог. Өөрөөр хэлбэл нэгдэж санаачлага гаргаж байгаа иргэдийн тооны хязгаар Европын холбооны гишүүн орон бүрд ялгаатай байдаг гэсэн үг юм.

Үүнээс гадна Европын парламентад 1993 оноос Өргөдөл гомдлын байнгын хороо байгуулагдсан. Мөн 1995 оноос Европын парламентаас Иргэдийн асуудал хариуцсан комиссарыг томилж ажиллуулах болжээ. Үүний гол зорилго нь Европын холбооны болон гишүүн орнуудын засаг захиргааны байгууллагуудыг ил тод нээлттэй, үр дүнтэй, хариуцлагатай ажилладаг ажиллуулахад туслах явдал юм. Ингэснээр иргэд Европын парламентын Иргэдийн асуудал хариуцсан комиссарт тодорхой байгууллагын талаар гомдол гаргах эрхтэй болсон байна. Энэ мэтчилэнгээр Европын улсуудад иргэдийн оролцооны өргөн боломж нээгдэж байна.

Гэхдээ Швейцараас бусад Европын улсуудад иргэдийн оролцоо дөнгөж саяхнаас хөгжиж эхэлжээ. Ихэнх улсад энэ зууны эхээр л иргэдийн оролцооны асуудлаар төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж, түүнд тулгуурласан гарын авлага, зөвлөмжүүд, мөн заавар журмууд гарч эхэлсэн байна. Энэ бүхнийг энэхүү судалгааны хүрээнд дэлгэрэнгүй авч үзэх боломжгүй юм. Тиймээс энд зарим орны туршлагаас товч дурьдая.

11 http://de.wikipedia.org/wiki/Vertrag_von_Lissabon

12 http://de.wikipedia.org/wiki/Europ%C3%A4ische_B%C3%BCrgerinitiative

ХБНГУ

Германы хотуудын зөвлөлөөс 2014 оны 4 дүгээр сард хотуудыг өөрсдийнхөө орон нутгийн иргэдийн оролцооны өнөөгийн байдлыг нарийвчлан авч үзэж тайлан гаргахыг зөвлөсөн байна. Үүнд тулгуурлан хотуудын дүрмийг шинэчлэх, орон нутаг дахь ардчиллыг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлно гэж үзжээ.

Холбооны улсын Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас том төслүүдийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хэрхэн хангах талаар гарын авлага гаргасан нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал алхам болсон байна. Мөн Бонн, Хайделберг, Хайлбронн, Лайпциг, Нюрнберг зэрэг хотууд Иргэдийн хурлаараа иргэдийн оролцооны үндсэн чиглэлүүдийг баталжээ.

Австри улс

Австри улс орон нутгийн идэвхи санаачлагатайгаар иргэдийн оролцооны олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээс гадна Холбооны улсын Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, байгаль орчин, усны аж ахуйн яам нь *“Европын тогтвортой хөгжил”* гэсэн санаачлага гаргаж иргэдийн оролцоог хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байгаа жишээ байна.

Грац зэрэг муж улсууд болон Вена хот иргэдэд зориулсан гарын авлага, иргэдийн оролцооны практик жишээ бүхий ном гаргаж иргэдийн оролцоог дэмжиж ажилладаг байна. Австрийн баруун хязгаарын Форарлберг муж улс 2013 онд Үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулж оролцооны ардчиллын элементүүдийг нэмж тусгаж өгчээ. Үүнийг хэрэгжүүлэх алхамуудыг мөн нарийн зохицуулсан байна. Тухайлбал, эхний ээлжинд тодорхой асуудлыг аль болох зардал бага орох, шуурхай хэрэгжих, энгийн аргыг ашиглан *“Иргэний зөвлөл”*-өөр хэлэлцээд саналаа боловсруулдаг байна. Дараа нь гаргаж буй саналаас гарч болох сөрөг үр дагаврыг улс төр, засаг захиргаа, мэргэжлийн байгууллага, иргэний төлөөлөл оролцсон ажлын хэсэг *“Иргэний кофе”*-нд хэлэлцдэг байна. Энэ бүхнийг журмаар маш нарийн зохицуулсан байдаг.

Швейцар улс

Ард нийтийн санал асуулгаар олон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлуудыг шийдэж байхыг Швейцарийн Үндсэн хуулинд заасан байдаг байна. Ингэснээр томоохон дэд бүтцийн төслүүдийг төлөвлөх явцад иргэд оролцох, санаа бодлоо илэрхийлэх, эсэргүүцэх зэрэг боломж бүрдсэн. Энэ нь олон нийтийн эрх ашгийг хөндсөн томоохон төслүүдийг ил тод байлгах, олон талын сонирхолыг тэнцвэржүүлэх боломжийг олгодог сайн талтай юм байна.

Европын холбооны улс

Дани улсын Аархус хотноо 1998 оны 6 дугаар сарын 25-нд болсон НҮБ-ын Европын эдийн засгийн хороо (UNECE)-ны хурлаар иргэд Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхээр эрхээ хамгаалуулах боломжийг баталгаажуулсан *“Аархусын конвенц”*-ыг баталжээ¹³. Энэ конвенц 2001 оны 10 дугаар сарын 30-нд хүчин төгөлдөр болсон байна. Уг конвенцэд эдүгээ 47 орон нэгдэн оржээ. Манай улс уг конвенцод нэгдэн орох санаачлагууд гарч буй ч хараахан нэгдээгүй байна.

13 <http://ec.europa.eu/environment/aarhus/>

Аархусын конвенц олон улсын түвшинд иргэдийн оролцоог баталгаажуулсан чухал баримт бичиг болсон юм. Үүний үндсэн дээр Европын холбооноос 2003 онд конвенцыг хэрэгжүүлэх заавар гаргажээ. Энэ зааврыг хэрэгжүүлэх зорилгоор Европын холбооны гишүүн улсууд Олон нийтийн оролцооны тухай хууль баталж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Дараагийн нэг чухал алхам бол 2007 оны 12 дугаар сарын 13-нд батлагдаж 2009 оны 12 дугаар сарын 01-нд хэрэгжиж эхэлсэн дээр дурдсан *“Лиссабоны гэрээ”* байлаа. Үүнийг Европын холбооны Үндсэн хууль гэж хэлж болно. Лиссабоны гэрээгээр анх удаа *“Европын иргэдийн санаачлага”*-ыг хуульчилсан юм. Үүнийг Европын холбооны улсын иргэд улс төрийн үйл хэрэгт оролцох ардчиллын чухал хэрэгсэл төдийгүй шууд ардчиллын шинэ элемент гэж үздэг. Уг арга хэрэгсэлийн тусламжтайгаар иргэд тодорхой асуудлаар Холбооны гишүүн улсуудын дөрөвний нэгийг тэдгээрээс сонгож, нэг сая иргэний гарын үсэг цуглуулсан тохиолдолд Европын комиссыг тухайн асуудлаар хуулийн төсөл санаачлахыг шаардах эрхтэй болсон байна. Гэхдээ иргэдийн санаачлагаар Европын комисс зөвхөн өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд хууль санаачилж болох бөгөөд Европын холбоог өргөтгөх асуудлаар иргэд санаачлага гаргах эрхийг хязгаарлаж өгчээ.

“Европын иргэдийн санаачлага” хэмээх иргэдийн оролцооны энэ арга хэрэгсэлийг хэрэглэх хүрээ, нөхцөл зэргийг нарийн зохицуулсан журмыг 2010 онд Европын парламент баталсан байна. Мөн 2009 оны 10 дугаар сарын 01-нд Олон улсын засгийн газрын бус байгууллагуудын бага хурлаар *“Шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцооны ёс зүйн дүрэм”*-ийг баталжээ¹⁴.

Энэ бүхнээс үзэхэд иргэдийн оролцооны асуудлаар Европын холбооны бодлого, эрх зүйн орчин бүрдэж гишүүн орнууд ч түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой алхамуудыг хийж байна.

Манай оронд ч гэсэн 2000 оны эхэн үеэс “Шууд ардчилал-Иргэдийн оролцоо”-г хөгжүүлэхэд анхаарч олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэн байна. Тухайлбал, Глоб Интернэшнл ТББ-аас 2005 онд “Мэдэх эрх-Шууд оролцооны эрх” гарын авлага боловсруулж иргэдийн оролцооны хэлбэрүүд, иргэд бодлого боловсруулах үйл явцад хэрхэн оролцох зэрэг асуудлуудыг авч үзсэн. Нээлттэй Нийгэм Хүрээлэн 2005 оноос энэ асуудалд анхаарч 20 гаруй судалгааны материал гаргасан байна. Тэдгээрээс 2006 онд МУИС-ийн багш Д.Бямбажав “Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоо: эрх зүйн орчин болон институцчилалыг сайжруулах нь” бодлогын судалгааг хийжээ. Судалгаагаар Монгол улсад төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоог хангасан эрх зүйн орчин болон институцчиллийг сайжруулах арга замуудыг тодорхойлж бодлогын зөвлөмжийг боловсруулахыг зорисон байна. Энэ хүрээнд нэгдүгээрт, Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад төрийн бус байгууллагын оролцоог зохицуулж буй эрх зүйн болон институциональ орчинг тодорхойлох, давуу болон сул талуудыг илрүүлэх, хоёрдугаарт, Дэлхийн бусад оронд төр-иргэний нийгмийн хамтын ажиллагаа, ТББ-ын оролцоог хангасан сайн туршлагыг өөрийн орны нөхцөл, шаардлагад тулгуурлан хэрэгжүүлэх боломж, арга замуудыг тогтоох, гуравдугаарт, Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоог дэмжих бодлогын сонголтыг тодорхойлох зэрэг асуудлыг авч үзсэн байна. Мерси

14 https://www.coe.int/t/ngo/Source/Code_German_final.pdf

Кор Монгол Олон улсын байгууллагын санхүүжилтээр 2007 онд судлаач Д.Бямбажав, С.Түмэндэлгэр нар “Орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо”-г Архангай, Хэнтий, Булган аймгуудад судалж тайланг хэвлүүлсэн. Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгээс 2013 онд Багийн Нийтийн Хуралд зориулсан “Багийн түвшинд иргэдийн оролцоо, эргэх холбоог сайжруулах нь” гарын авлагыг хэвлэн гаргажээ. Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас “Шууд ардчилал-Иргэдийн оролцоо” бодлогын баримт бичгийн эмхэтгэлийг Конрад-Аденауэр сангийн сахүүжилтээр 2013 онд хэвлэн гаргасан. Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачид төсвийн ил тод байдал хангалтгүй, иргэдийн оролцоо бага, үр дүн муутай хэвээр байгаад дүгнэлт хийж, түүний шалтгаан нөхцөлийг тодруулж, асуудлыг шийдвэрлэх арга замыг эрж хаих шаардлагын үүднээс судалгаа хийж “Төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоог дээшлүүлэх хөшүүрэг, арга зам” гэсэн тайланг 2014 онд хэвлүүлсэн байна. Швейцарийн Хөгжлийн агентлагийн санхүүжилтээр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэмжлэгтэй хэрэгжиж буй “Нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог дэмжих нь” төсөл 2012 оноос эхэлсэн бөгөөд энэ төслийн хүрээнд олон ажил хийгдэж байна. Түүнээс гадна НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Азийн сан, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Удирдлагын академи зэрэг олон байгууллагууд уг асуудалд анхаарал хандуулж, төсөл хэрэгжүүлэн үр дүнг хэвлэн олон нийтийн хүртээл болгож буйг тэмдэглэх хэрэгтэй.

Манай судалгааны баг “Шууд ардчилал-Иргэдийн оролцоо”-той холбоотой Монгол улсад хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүд, ном зохиолын тоймыг энэ судалгааны хүрээнд гаргахыг зориогүй ч энэ чиглэлээр хийгдсэн зарим ажлуудыг дээр товч дурдлаа. Бид гол нь энэ чиглэлийн бодлого, эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, иргэд, төрийн албан хаагчдын санаа бодлыг судлахыг зорьсон юм. Энэ талаар дараах бүлэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

БҮЛЭГ 2

ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ШУУД
АРДЧИЛАЛ-ИРГЭДИЙН ОРОЛЦОО
ХЭРЭГЖИХ ХҮРЭЭНИЙ БОДЛОГО,
ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХЭРЭГЖИЛТ

2. ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ШУУД АРДЧИЛАЛ-ИРГЭДИЙН ОРОЛЦОО ХЭРЭГЖИХ ХҮРЭЭНИЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХЭРЭГЖИЛТ

2.1 Бодлого, эрх зүйн орчинд хийсэн шинжилгээ

2.1.1. Шууд ардчилал-иргэдийн оролцоо

Өмнөх бүлэгт иргэний санаачлага, оролцооны олон хэлбэрүүдийн талаарх онол, үзэл баримтлалууд, тэдгээрийг улс орнууд зорилго, хамрах хүрээ, захиалагч, ашиг хүртэгчдийн байдлаас хамааран янз янзаар хэрэглэж байгаа тухай дурьдсан болно. Бид энэ хэсэгт иргэдийн жирийн оролцоог шийдвэр гаргаж оролцдог оролцооноос ялгаж авч үзэх болно. Өөрөөр хэлбэл, иргэд улс орны хэмжээний болон орон нутгийн түвшиний асуудалд шууд ардчиллын замаар шийдвэр гаргаж оролцох хэлбэрийг энд хөндөх болно. Хэдийгээр манай улс төлөөллийн ардчилал бүхий орон гэгдэх боловч Үндсэн хуулиараа шууд ардчилалд өргөн боломж олгосон орны тоонд зүй ёсоор ордог.

Манай улсад 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаар шууд ардчилал-иргэдийн оролцооны асуудал шинэ шатанд тавигдсан гэж үзэж болно. Үндсэн хуульд “Монгол улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”¹⁵, Монгол улсын иргэн, “Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй”¹⁶ гэсэн шууд ардчиллын суурь зарчмууд тусгагдсан байдаг. Мөн “Ард нийтийн санал асуулга” явуулах тухай заалт ч бий. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ¹⁷ гэж манай Үндсэн хуульд байгаа нь шууд ардчилалын хамгийн дээд хэлбэр болох ард нийтийн санал асуулга буюу референдумийг Үндэсний хэмжээнд явуулахыг хүлээн зөвшөөрсөн орон юм. Үүнийгээ ч амьдралд бодитой хэрэгжүүлэхийн тулд Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг батлан гаргасан байна.

1995 оны 10 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан “Ард нийтийн санал асуулгын тухай” хуулийн зорилт нь ард нийтийн санал асуулга явуулах зарчим, журмыг тодорхойлж, санал асуулгыг бэлтгэн зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах явдал юм. Ард нийтийн санал асуулгын тухай хуульд заасанчлан Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд оролцож, санал асуулгаар шийдвэрлэх асуудлын талаар саналаа нууцаар гаргах, санал асуулга авах өдөр эх орондоо байгаа 18 нас хүрсэн Монгол улсын иргэн үндэс угсаа, хэл, арьс өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн

15 Монгол улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1 дэх заалт

16 Монгол улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 9 дэх заалт

17 Монгол улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 16 дахь заалт

ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр санал асуулгад оролцож саналаа өгөх эрхтэй юм. Гэвч ард нийтийн санал асуулга хийх санаачлага нь иргэдээсээ биш, харин хууль санаачлагч эрх бүхий субъектүүд (УИХ, УИХ-ын гишүүд, Засгийн газар, Ерөнхийлөгч)-ийн зүгээс гарахаар хуульчлагдсан байна. Хэдийгээр иргэн хүн ард нийтийн санал асуулгаар шийдвэрлэх асуудлыг хөндөж тавьж болох боловч түүнийгээ зөвхөн хууль санаачлагчаар дамжуулах ёстой. Иймд ард нийтийн санал асуулгаар асуудал шийдвэрлэх санаачлагыг тодорхой тооны иргэд (тухайн үед сонгуулийн насанд хүрсэн нийт иргэдийг төлөөлж болох зохистой тооны иргэдийг түүвэрлэх замаар тогтоож болох юм) гаргах боломжийг уг хуульд нэмж оруулсан тохиолдолд ардчилал өндөр хөгжсөн орнуудтай нэгэн адил иргэдийн санаачлагаар референдум явуулах бололцоо бүрдэх юм.

Үүнээс гадна манай Үндсэн хуулинд шууд ардчилалын бас нэгэн чухал хэлбэр болох Иргэдийн нийтийн хурлыг хүлээн зөвшөөрч хуульчлан тусгажээ. Энэ нь “Нутгийн өөрөө удирдах байгууллага бол ... баг, хороонд иргэдийн нийтийн хурал, тухайн хуралдааны чөлөө цагт түүний тэргүүлэгчид мөн” гэсэн Үндсэн хуулийн заалт юм¹⁸. Баг, хорооны түвшинд ӨУБ нь нэгэнт баг, хорооны иргэдийн нийтийн хурал учраас Үндсэн хуулийн заалтын дагуу баг, хорооны “нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлаа бие даан шийдвэрлэх” бодит эрхтэй бөгөөд түүний “Эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” гэсэн Үндсэн хуулийн заалттай¹⁹. Энэ заалтын дагуу эдүгээ ч манай баг, хороодын түвшинд иргэдийн нийтийн хурлаараа өөртөө холбогдол бүхий асуудлуудыг хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд шийдвэрлэж байгаа шууд ардчиллын бодит илрэл юм.

Олон улсын практикт хэрэглэгддэг шууд ардчиллын түгээмэл хэлбэрүүдийн нэг нь орон нутгийн түвшний асуудлыг тухайн орон нутгийн иргэд шууд санал хураалтаар шийдвэрлэдэг шууд ардчиллын гурав дахь хэлбэр буюу орон нутгийн плебисцит (энгийн ард түмний шийдвэр гэсэн латин үгнээс гаралтай) буюу референдумын хуультай байх нь элбэг юм. Одоогоор манай улсад орон нутгийн түвшинд ард түмний санал асуулгаар асуудлыг шийдэх практик байхгүй байгаа бөгөөд холбогдох хууль ч хараахан үгүй байна. Энэ нь үндэсний болон орон нутгийн түвшний улс төрчдийн анхаарах асуудлын нэг мөн юм. Гэвч 1992 оны Үндсэн хууль батлагдахаас өмнө манай улсад шууд ардчилал гэж байгаагүй гэвэл үнэнд үл нийцнэ.

Шууд ардчилал-иргэдийн оролцооны асуудалтай холбоотой Монгол улсын түүхэнд тохиосон нэгэн содон үйл явдал бол 1945 онд болсон Ард нийтийн санал асуулга юм. Дэлхийн II дайны дараах улс төрийн ээдрээт нөхцөл байдал дунд манай улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдлын хувь заяаг хэрхэх тухай, нөлөө бүхий том гүрнүүд хэлэлцэж тодорхой болзол тавигдаад байсан эгзэгтэй үед БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчид (1945 оны 9 сарын 21-ний өдрийн 76 дугаар тогтоол), БНМАУ-ын тусгаар тогтнолын талаарх асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай түүхэн шийдвэр гаргасан байдаг.

1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр тэр үеийн манай улсын насанд хүрсэн нийт иргэд бараг бүгдээрээ (478 мянга гаруй хүн) улсын тусгаар тогтнолын төлөө саналаа хураалган оролцож улс, үндэстнийхээ гол үнэт зүйлийг хамгаалж чадсан нь бас нэг чухал тэмдэглэлт үйл явдал юм.

18 Монгол улсын Үндсэн хуулийн тавин ес дүгээр зүйлийн 2 дахь заалт

19 Монгол улсын Үндсэн хуулийн жаран хоёрдугаар зүйлийн 1.2 дахь заалт

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Монгол Улсын тусгаар тогтнолын тухай бүх ард түмний санал хураалтын 60 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд хэлсэн үгэндээ “...энэ өдрийг цаашид түүхэн энэ явдлыг дурсах, мөнхжүүлэх үүднээс төдийгүй улсынхаа тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлаа бататгах, эх орон, бүс нутаг, нутаг орон, хот тосгодоо хөгжүүлэх арга замын тухай нээлттэй өргөн хэлэлцүүлэг, бүтээлч хөдөлгөөн өрнүүлдэг, иргэдийн саналыг засаглалын бүх төвшинд сонсох “Нээлттэй хаалганы өдөр болгох” талаар санал дэвшүүлж улмаар “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай зарлиг гаргасан байна (2007 оны 5 дугаар сарын 24, № 97). Энэ нь шууд ардчиллаар асуудал шийдвэрлэх гэсэн шинэ оролдлого гэхээс илүү иргэний оролцоог идвэхижүүлэх чиглэлд түлхэц нэмсэн чухал зарлиг юм.

Шигтгээ 1. *Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулж байх тухай 2007 оны 5 дугаар сарын 24 өдрийн № 97 тоот зарлиг*

1. “БНМАУ-ын тусгаар тогтнолын талаархи асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай” БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны түүхэн шийдвэрийн дагуу Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулсан ард түмний санал асуулгыг явуулсан өдрийг тохиолдуулан Засгийн газар, орон нутгийн удирдлага, тэдгээрийн харьяаны бүх шатны байгууллага, албан тушаалтнууд бодлого боловсруулах, шийдвэр гаргахдаа иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, зөвлөгөөг сонсч тусгах зорилгоор жил бүрийн 10 дугаар сарын 20-нд орон даяар “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай.
2. Бүтэн жилийн турш иргэдээс ирүүлсэн бүтээлч, ажил хэрэгч саналыг гүйцэтгэх удирдлагын байгууллагууд, холбогдох албан тушаалтан хүлээн авах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, тэдгээрийн нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд үзүүлж байгаа эерэг үр дүн, үр нөлөөг нэгтгэн дүгнэж, ард түмэндээ мэдээлж байдаг эргэх холбооны тогтолцоог Засгийн газрын хэмжээнд бүрэлдүүлэн ажиллах нь зүйтэй гэж үзсүгэй.
3. Иргэдээс дэвшүүлж тавьсан санал, санаачилгыг дэмжиж хэрэгжүүлэх талаар эргэх холбооны тогтолцоо бүрдэж, тэдгээрийг дүгнэн мэдээлдэг “Нээлттэй хаалганы өдөр” буй болгож байгаатай уялдуулж өөрсдийн дэвшүүлж байгаа санал, санаачилгынхаа үр ашиг, үр нөлөө, хэрэгжих магадлал, ул үндэстэй тооцоо, судалгаа, ажил хэрэгч байдлыг дээшлүүлэхийг нийт иргэддээ зөвлөсүгэй.
4. Иргэдээс гарах санал, санаачилгыг ажил хэрэг болгох талаар гүйцэтгэх удирдлагын зүгээс авч буй арга хэмжээнүүдийг байнга сурталчлах, түгээх явдалд идэвх санаачилгатай оролцохыг нийт хэвлэл, мэдээллийн байгууллага, ажилтнуудад уриалсугай.

*“Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай
Ерөнхийлөгчийн зарлигийн заалтууд*

Бидний судалгааны ажлын хүрээнд холбогдох Үндсэн хуулийн дээр дурьдсан заалтууд, “Ард нийтийн санал асуулгын тухай” хууль, “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулж байх тухай Ерөнхийлөгчийн зарлигийн заалтуудын агуулга нь шууд ардчилал-иргэдийн оролцооны талаар үлэмж их бололцоо нээж өгсөн хууль, эрх зүйн чухал баримт бичгүүд гэдэг нь тодорхой байна. Үүнийг сайн ашиглах, улам баяжуулах шаардлага бий.

Юуны өмнө бусад орны сайн туршлага, практикаас сургамж авч орон нутгийн түвшинд сум, дүүрэг, аймаг, нийслэлд ард иргэдийнх нь нийтлэг ашиг сонирхолыг хөндсөн зарим асуудлыг орон нутгийн хэмжээний плебисцит (санал асуулга) явуулах замаар шийддэг болвол шууд ардчилалын дараах гурван хэлбэр манайд хэрэгжих бололцоотой болно.

- a. Бүх ард түмний санал асуулга
- b. Иргэдийн нийтийн хурал (Иргэдийн төлөөлөгчдийн хурал биш)
- c. Орон нутгийн реферэндум

Дээрх гурван хэлбэрийг иргэд шийдвэр гаргаж оролцдог шууд ардчиллын хэлбэрүүд гэж үзэх нь бий /en.m.wikipedia.org) Government in the United States. 1997. p. 17/.

Шууд ардчилалын энэ гурван хэлбэр нь иргэний оролцооны дээд хэлбэр болох тул тэр бүр байнга хийгдээд байдаг зүйл биш. Тэр тусмаа Ард нийтийн санал асуулгын тухай хууль хэдийгээр батлагдсан ч, өнөө хүртэл хийгдээгүй нь цаг хугацаа, хүч хөрөнгө, асуудал шийдэх төвөгтэй байдалтай холбоотой төдийгүй дээр нэгэнт тэмдэглэсэнчлэн иргэдийн санаачлагаар реферэндум явуулах бололцоо хуулиар хаагдмал байгаатай холбоотой гэж үзэж байна. Эдүгээ энэ хаагдмал бололцоог нээхийн тулд “Иргэний оролцооны тухай” хуулийн төслийг шинээр санаачлаад байгаа нь (Ерөнхийлөгчийн институт) сайшаалтай ч одоо нэгэнт байгаа ард нийтийн санал асуулгын хуульд өөрчлөлт оруулах, орон нутгийн түвшинд санал асуулга явуулах тухай хуулийг шинээр батлуулах замаар асуудлыг шийдэх нь илүү мэт. Цаашид орон нутгийн реферэндумын хуулийг баталж, үндэсний гэхээсээ илүү орон нутгийн реферэндумыг явуулж орон нутгийн түвшиний асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Тэгэхээр манай улсад шууд ардчилалд үндэслэсэн иргэний оролцооны хэлбэрүүдээс байнга хэрэглэх бололцоотой нь баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болж байгаа юм. Гэвч баг, хорооны түвшинд шийдвэрлэх асуудлын хүрээ хумигдмал, хөрөнгө нөөц ихээхэн хомс билээ. Харин шууд ардчиллын хэлбэр биш ч гэсэн Ерөнхийлөгч Н.Энхбаярын гаргасан “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай зарлиг нь зөвхөн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын түвшинд бус гүйцэтгэх эрх мэдлийн шугамаар үйл ажиллагаа явуулж байгаа Засаглалын бүх түвшиний байгууллагууд бодлого, шийдвэртээ иргэдийн санал бодлыг тусгаж байхад зарчмын чухал чиглэл болсон байна. Харамсалтай нь манай судалгаанд хамрагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд шууд ардчилалын болон иргэдийн оролцоог хангах талаар гарсан дээрх бодлого шийдвэрийн хэрэгжилт сулхан байгаа нь ажиглагдлаа. Үүний гол шалтгаануудын нэг нь урьд гарсан бодлого шийдвэрийг өвлөн авч хэрэгжүүлэх гэхээсээ ямар нэгэн шинэ санал, санаачлага гаргаж олны анхаарлыг татах үйл ажиллагааг шинээр эхлүүлдэг явдал байх шиг байна.



Манай улсад шууд ардчилал-иргэдийн оролцоог хангах чиглэлээр өөр санаа, санаачилгыг шинээр хэрэгжүүлэх оролдлогууд гарсаар байгаа юм байна. Үүний нэг илрэл нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Шууд ардчилал-иргэдийн оролцооны тухай” үзэл санаа юм. Энэ хүрээнд “Шууд ардчилал-иргэдийн оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг” (2012-2022 он) Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 176 дугаар зарлигийн хавсралт маягаар гарчээ.

Энэхүү бодлогын баримт бичиг нь Улсын Их Хурлаар хэлэлцэгдэн батлагдаж байж хүчин төгөлдөр болох тул түүний хэрэгжилтийн тухай асуудлыг ярих нь утгагүй хэрэг болно. Харин 2011 оны 12 дугаар сарын 23-нд Төсвийн тухай шинэ хууль батлагдан гарч, тус хуулинд “Иргэдийн оролцоо” гэсэн тусгай бүлгийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар оруулан баталсан. Энэ хууль батлагдаад 3 жил орчим болж байна. Ийнхүү манай улсад шууд ардчилал-иргэдийн оролцооны талаар хууль, эрх зүй болон бодлогын орчин харьцангуй сайн бүрэлдэж байна. Гагцхүү холбогдох хууль бодлогын хүрээнд нээгдсэн боломжуудыг гүйцэтгэх удирдлагын түвшин бүрт хэрэгжүүлж хэвшүүлэх үйл ажиллагаа дутмаг байгаа нь илт. Хууль тогтоомжийн заалт, бодлогыг тууштай хэрэгжүүлэх төдийгүй, шууд ардчилал-иргэдийн оролцооны хүрээнд олон улс, практикт нэвтэрсэн сайн туршлага, онол, арга зүйн дүгнэлт, зөвлөмжийг бүтээлчээр авч ашиглах явдал чухалчлагдаж байна. Эдгээр асуудлыг тодруулах зорилгоор бид иргэдийн оролцооны талаар дараах чиглэлээр асуулгын судалгаа хийсэн бөгөөд хураангуй үр дүнг дор танилцууллаа.



Судалгаанд хамрагдсан хүн ам, өрхийн шинж байдал

Монгол улсын нийт бүс нутгийг төлөөлүүлэн 3 бүсийн 6 аймаг, Улаанбаатар хотын 2 дүүргийн нийт 1403 өрхийг түүвэрлэн судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамруулах орон нутгийг түүвэрлэхдээ орон нутгийн байршил, хүн ам, өрхийн тоог харгалзсан бөгөөд тухайн орон нутгаас судалгаанд хамруулах өрхийн тоог орон нутгийн хүн ам, өрхийн тоотой пропорциональ байдлаар тооцож тэнцвэртэй төлөөллийг бүрдүүллээ. Тус судалгааны хүрээнд нэг өрхийг төлөөлүүлэн тухайн өрхийн нэг гишүүнээс судалгааны мэдээлэл авсан бөгөөд өрхөө төлөөлж судалгаанд оролцсон иргэдийг нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, оршин суугаа байршлаар нь харьцуулж үзлээ.

Нас: Судалгаанд оролцсон иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл оролцогчдын 55 хувь нь 35 хүртлэх, 45 хувь нь 35 ба түүнээс дээш насныхан байлаа. Судалгаанд хамрагдсан иргэдийг насны бүтцээр нь авч үзвэл 32 хувь нь 18-25 насны, 23 хувь нь 26-35 насны, 37 хувь нь 36-55 насны, 8 хувь нь 56-аас дээш насны хүн ам байв (Зураг 2).



Зураг 2. Судалгаанд оролцогчдын насны бүлэг




Зураг 3. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин

Хүйс: Судалгаанд хамрагдсан нийт өрхийн төлөөллийн 45.6 хувь нь эрэгтэйчүүд, 54.4 хувь нь эмэгтэйчүүд байлаа.

Боловсрол: Судалгаанд оролцогчдын дийлэнхи нь дээд боловсролтой иргэд байсан бөгөөд энэ нь судалгааны мэдээлэл, хариултын бодитой байдалд эергээр нөлөөлөх үзүүлэлт юм. Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын 5 нь буюу 53.8 хувь нь дээд болон тусгай дунд боловсролтой, ойролцоогоор 3 хүн тутмын 1 буюу 35 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байсан бол суурь болон бага боловсролтой, эсвэл боловсрол эзэмшээгүй хүмүүс нийт судалгаанд хамрагдагчдад ердөө 10 хувийг эзэлж байна (Зураг 3).

Хөдөлмөр эрхлэлт: Хүн амын нийгэм, эдийн засгийн шинж байдлыг тодорхойлогч үндсэн үзүүлэлтийн нэг нь хөдөлмөр эрхлэлт байдаг. Иргэд судалгаа авах үед чухам ямар ажил эрхэлж байгаа эсэхийг тодруулахад дараах үр дүн гарлаа (Зураг 4).




Зураг 4. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал

Судалгаанд хамрагдсан 4 иргэн тутмын нэг нь буюу 29.9 хувь нь судалгаа авах үед эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцоогүй буюу ажилгүй, суралцдаг, эсвэл тэтгэвэрт байдаг иргэд байна. Харин үлдсэн хувь нь ямар нэгэн орлого, цалинтай ажил эрхлэгчид байсан ба эдгээрээс хамгийн өндөр хувийг буюу 39.1 хувийг цалин хөлстэй ажиллагчид бүрдүүлсэн байна. Судалгаанд оролцогчдын 19.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.9 хувь нь ажил олгогчид байсан бол 8.3 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн, мал аж ахуй эрхлэгч, өрхийн үйлдвэрлэлд цалин хөлсгүй оролцогчид байв.

Байршил: Судалгаанд хамрагдсан өрхийн 878 нь буюу 62.6 хувь нь хөдөө орон нутгаас, 525 нь буюу 37.4 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдажээ. Харин хүн ам, өрхийн шинж байдлыг амьдарч буй байршилаар нь авч үзэхэд нийт судалгаанд оролцогчдын 53.9 хувь нь хот суурин газар (нийслэл, аймгийн төвд), 46.1 хувь нь сум болон хөдөөгийн багт оршин суугчид байв.


Иргэдэд тэдээлэл хүрч буй байдал

Орон нутаг дахь иргэдийн оролцоог сайжруулахад иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх нь туйлын чухал билээ. Тиймээс бид асуулгын судалгаагаар орон нутаг дахь иргэний оролцоо, түүний талаарх мэдлэг, мэдээлэл иргэд олон нийтэд хүрч буй байдлыг тодруулахыг зорилоо. Иргэд оршин суугаа орон нутгийнхаа бодлого, шийдвэрийн талаарх мэдээллийг ихэнхидээ телевиз, өдөр тутмын сонин хэвлэл, орон нутаг дахь засаг захиргааны байгууллагаас авдаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Иргэдийн мэдээлэл авч буй байдлыг аймаг, нийслэлээр харьцуулж үзэхэд онцгой ялгаа харагдахгүй байна.



Зураг 5. Иргэдийн мэдээлэл авч буй байдал, аймаг, нийслэлээр

Мэдээлэл авдаг эх сурвалжуудыг эрэмбээр нь харвал иргэдийн 54.5 хувь нь буюу ойролцоогоор 5 хүн тутмын 3 хүн нь телевизийн мэдээ, сурталчилгаанаас, 3 хүн тутмын нэг нь байгууллагын нээлттэй хаалганы өдрүүдээр, 5 хүн тутмын нэг нь орон нутгийн байгууллагаас гарч буй албан ёсны мэдээлэлүүдээс гэжээ. Харин брошур буюу нугалмал хуудас зэрэг хэвлэмэл материал, төлөвлөлт загвар харуулсан самбар зэрэг тус орон нутагт байрлах, зорилтот иргэддээ зориулсан мэдээлэл, баримтанд иргэд, олон нийт ач холбогдол бага өгдөг ба зорьж унших нь ховор байдаг байна.



- Байнга оролцдог
- Зарим үед оролцдог
- Оролцдоггүй

Зураг 6. Иргэдийн орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлж оролцож буй байдал

Иргэдийн оролцоо

Манай улсад баг, хорооны иргэд Иргэдийн нийтийн хурлаас өөр шууд ардчиллаар асуудлыг шийдэж байгаа хэлбэр байхгүй байна. Өнгөрсөн хугацаанд иргэд орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд хэрхэн оролцож байсныг тандахад судалгаанд оролцсон иргэдийн 10 иргэн бүрийн 2 нь байнга оролцож, харин 2 хүн бүрийн нэг нь зарим үед оролцдог гэжээ. Огт оролцдоггүй гэж 22 хувь нь хариулжээ.

Судалгааны үр дүнг хот, хөдөөгөөр харьцуулсан шинжилгээ хийж үзэхэд онцлох ялгаа ажиглагдахгүй байгаа хэдий ч хүн ам зүйн чухал үзүүлэлтүүд болох нас, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь харьцуулж үзэхэд дараах үр дүн ажиглагдлаа. Иргэдийн нас ахих тусам байнгын оролцоо нэмэгдэж байгаа бол нас залуужих тусам зарим үед оролцох оролцоо нэмэгдсэн дүн ажиглагдаж байна (Хүснэгт 4).

Хүснэгт 3. Иргэдийн оролцооны идэвхи, насны бүлэгт эзлэх хувь

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Байнга оролцдог	6	17	26	38	39
Зарим үед оролцдог	56	56	54	53	47
Оролцдоггүй	37	26	21	9	14
Нийт	100	100	100	100	100

Өөрөөр хэлбэл 46-аас дээш насны иргэдийн 38-39 хувь байнга оролцдог гэж хариулсан байхад 18-45 насныханы ердөө 6-26 хувь нь л тийм гэсэн хариулт өгчээ. Харин зарим үед оролцдог болон оролцдоггүй иргэдийн дийлэнхи нь 45-аас доош насныхан байна. Нас ахих тусам иргэдийн оролцоо тогтмолжих хандлагатай байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Иргэний оролцооны идвэхийг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар харьцуулан харвал орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд байнга оролцдог гэж хариулсан хүмүүсийн 25 хувийг цалин хөлстэй ажиллагч, 17 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 37 хувийг тэтгэвэрийн насныхан эзлэж байна. Мөн зарим үед оролцдог гэж хариулсан хүмүүсийн 32 хувийг цалин хөлстэй ажиллагч, 27 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 20 хувийг тэтгэвэрийн насныхан бүрдүүлжээ (Хүснэгт 5).

Хүснэгт 4. Иргэдийн оролцооны идэвхи, хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувь

Хөдөлмөр эрхлэлт	Байнга оролцдог	Зарим үед оролцдог	Оролцдоггүй
Цалин хөлстэй ажиллагч	25	32	32
Ажил олгогч	1	1	3
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	17	27	30
Нөхөрлөл, хоршооны гишүүн	3	-	-
Мал аж ахуй эрлэгч	-	-	-
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	1	1	-
Тэтгэвэрт	37	20	10
Оюутан, суралцагч	4	4	8
Ажилгүй	8	11	17
Бусад	4	3	2
Нийт	100	100	100

Дээрх үр дүнгийн хүснэгтээс харахад байнга болон зарим үед оролцдог хүмүүсийн 44-57 хувь нь цалин хөлстэй ажиллагч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тэтгэвэрийн насныхан байна. Харин ажил олгогч, нөхөрлөл хоршооны гүшүүд, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид, оюутан суралцагчид болон ажилгүй хүмүүсийн хувьд оролцооны идэвхи сул байгаа бол мал аж ахуй эрхлэгчдийн хувьд иргэний оролцооны идэвхи маш муу буюу огт оролцоогүй байна.

Орон нутаг дахь иргэдийн оролцоотой удирдлагын тогтолцоо ямар зорилгод чиглэсэн байх ёстой талаарх иргэдийн төсөөллийг тандахад иргэдийн 70-80 гаруй хувь нь доор өгөгдсөн чиглэлүүдтэй санал нэг байгаагаа илэрхийлсэн байна. Санал нэг байгаа хариултын үнэлгээний 34-66 хувь нь “бүрэн санал нэг” байгаагаа илэрхийлсэн хариулт байна.

Хүснэгт 5. Иргэдийн оролцоотой удирдлагын тогтолцоо ямар зорилгод чиглэх ёстой талаарх иргэдийн төсөөлөл, хувиар

	Бүрэн санал нэг байна	Санал нэг байна	Зарим талаараа санал нэг байна	Бага зэрэг санал нэг байна	Огт санал нийлэхгүй байна
Иргэд юу хүсэж, сонирхож байгааг улс төрчид илүү сайн мэдэх хэрэгтэй	58	23	9	5	5
Иргэдийн хүсэл, эрмэлзлэлийг тусгасан шийдвэрийг л улс төрчид гаргадаг байх ёстой гэж боддог	39	33	20	4	4
Орон нутгийн бодлогын асуудлыг сайн ойлгож байж, түүнд хяналт тавих боломж олдоосой гэж би боддог	43	39	12	4	2
Иргэд болон нутгийн нийт хүмүүсийн сайн сайхны төлөө шийдвэрүүдийг гаргахад иргэд илүү их хүчин чармайлт гаргаж байгаасай гэж хүсдэг	48	39	10	2	1
Улс төрийн шийдвэрүүдийг ойлгох мэдлэг олж авахад нь иргэдэд тусладаг байгаасай гэж хүсдэг	47	35	12	4	3
Улс төрийн шийдвэрүүдийн нөлөө илүү сайжраасай гэж хүсдэг	38	43	13	4	2
Улс төрийн шийдвэрийг ойлгох мэдлэг олж авахад нь иргэдэд тусладаг байгаасай гэж хүсдэг	34	44	17	4	1
Иргэд агуулгын хувьд өөр өөр саналтай байж түүнийг илэрхийлэх бололцоотой байгаасай гэж хүсдэг	66	27	4	2	1
Орон нутгийн бодлого урт хугацааны зорилгод илүү анхаарал хандуулдаг байгаасай гэж хүсдэг	47	40	10	2	1

Бүрэн санал нэг байгаа гэж хариулсан хариултаудыг харьцуулан үзвэл иргэдийн 58 хувь нь иргэд юу хүсэж, сонирхож байгааг улс төрчид илүү сайн мэдэх хэрэгтэй гэж хариулсан бол иргэд агуулгын хувьд өөр өөр саналтай байж түүнийг илэрхийлэх бололцоотой байгаасай гэж хүсч буйгаа хамгийн их илэрхийлсэн байна. Үүнд судалгаанд оролцсон иргэдийн 66 хувь нь бүрэн санал нэг байна гэж хариулжээ.


Эндээс дүгнэж үзвэл, иргэдийн оролцоог хангах талаар төрөөс явуулж буй бодлого үйл ажиллагаа иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд иргэд юу хүсэж, сонирхож байгааг улс төрчид илүү сайн мэдэх, нөгөөтэйгүүр иргэд санал бодлоо илэрхийлэх бололцоотой байгаасай гэдгийг иргэдийн талаас илүү хувь нь чухалд тооцож байна. Дараагийн түвшинд орон нутгийн бодлого урт хугацааны зорилгод анхаарч, улс төрд гарсан шийдвэрийн нөлөөг сайжруулж, гаргасан шийдвэрүүдээ иргэдэд ойлгуулах асуудалд анхаарах хэрэгтэй гэж үзжээ.

Шигтгээ 2. Засгийн газраас ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш олон нийттэй харилцах алба байгуулсан. Энэ алба нь иргэдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, харууг нь түргэн шуурхай хүргэх байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг. Манайх 2013 оны 3 дугаар сараас эхэлж энэ үйл ажиллагаагаа эхэлсэн. Манай хүлээж авсан санал гомдлын шийдвэрлэлт олон нийтэд нээлттэй болсон. Энэ нь Засгийн газрын 11-11 төв шиг санал, өргөдөл, гомдлын програмтын төслийг хэрэгжүүлж ажиллаж байгаа юм. Одоогоор 90 санал бүртгэгдсэн байна. Үүний 90% нь шийдвэрлэгдсэн байна. Иргэдэд мэдээлэл хүргэхийн тулд 45 хоног туталд нээлттэй уулзалт зохион байгуулдаг. Нээлттэй уулзалтаар нээлттэй утсаар ирсэн санал хүсэлтийн шийдвэрлэлтийг танилцуулдаг. Мөн иргэд өөрсдөө тодорхой санал хүсэлтээ уулзалтан дээр холбогдох удирлагуудад тавиад дор нь харуугаа авдаг. Мөн айлмгийн ЗДТГ-ын хийж бүтээж байгаа ажлуудыг тайлбарлаж тайлагнадаг байгаа. Мөн манай олон нийттэй харилцах алба 7 хоног тутал шуурхай мэдээлэлд хичнээн гомдол ирсэн үүнийг яаж шийдвэрлэсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг.

Өвөрхангай айлмгийн Иргэдийн санал, хүсэлт хүлээн авах төвийн ажилтантай хийсэн ярилцлагаас

Иргэдийн сэтгэл ханамж

Иргэдийн оршин суугаа орон нутгийнхаа хөгжлийн бодлогод хэр зэрэг сэтгэл ханамжтай байгааг тодруулахад судалгаанд оролцогчдын 7.9 хувь үнэхээр сэтгэл хангалуун, 35 хувь сэтгэл хангалуун, 33.5 хувь нь төдийлөн сэтгэл хангалуун биш, 15.9 хувь бага зэрэг сэтгэл хангалуун, 7.8 хувь огт сэтгэл хангалуун биш гэсэн хариултыг өгсөн байна.



- Үнэхээр сэтгэл хангалуун
- Сэтгэл хангалуун
- Төдийлөн сэтгэл хангалуун биш
- Бага зэрэг сэтгэл хангалуун
- Огт сэтгэл хангалуун биш

Зураг 7. Орон нутгийн хөгжлийн бодлогын талаарх иргэдийн сэтгэл ханамж, хувиар

Иргэдийн сэтгэл ханамжтай байдлыг нийслэл, аймгаар болон хүйс, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтээр харьцуулан үзэхэд онцгой ялгаа харагдахгүй байна. Насны бүлгээр нь харвал 36-аас дээш насныхны тухайд орон нутгийнхаа хөгжлийн бодлогод сэтгэл ханамжтай байдал өндөр байна. Харин 36-аас доош насны залуучуудын хувьд төдийлөн сэтгэл хангалуун бус байдаг гэж хариулжээ.


Харин орон нутгийнхаа хөгжлийн бодлогод хэр зэрэг сэтгэл ханамжтай байгааг оролцоотой нь харьцуулж үзвэл орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд байнга оролцдог буюу тус орон нутагт зохион байгуулагдаж буй үйл ажиллагаа, хийгдэж буй бүтээн байгуулалтад ямар нэгэн байдлаар оролцож, тэдгээрийн талаарх мэдээллийг авдаг иргэдийн 39 хувь нь сэтгэл хангалуун гэсэн үнэлгээ өгсөн байна. (Хүснэгт 7)

Хүснэгт 6. Орон нутгийн хөгжлийн бодлогод иргэдийн сэтгэл ханамж, оролцооны идэвхи, хувиар

Та орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлж оролцож буй байдал				
Орон нутгийнхаа хөгжлийн бодлогод сэтгэл ханамжтай байдал		Байнга оролцдог	Зарим үед оролцдог	Оролцдоггүй
	Үнэхээр сэтгэл хангалуун	15	6	2
	Сэтгэл хангалуун	39	19	8
	Төдийлөн сэтгэл хангалуун биш	23	43	44
	Бага зэрэг сэтгэл хангалуун	13	25	29
	Огт сэтгэл хангалуун биш	10	8	17
Нийт		100	100	100

Өөрөөр хэлбэл орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудалд санал, бодлоо илэрхийлж оролцдог иргэдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр байгаа нь харагдаж байна. Харин эсрэгээрээ зарим үед оролцдог, оролцдоггүй иргэдийн хувьд сэтгэл хангалуун бус байдаг ажээ.

Иргэдийн орон нутгийнхаа бодлогыг сонгуультай холбоогүйгээр хэр сонирходгийг тандахад төдийлөн сонирхдоггүй болон огт сонирхдоггүй гэж судалгаанд оролцогсдын 17.3 хувь нь хариулсан бол оролцогчдын талаас илүү нь буюу 55.7 хувь сонирхдог буюу маш ихээр сонирхдог гэж хариулжээ. Харин зарим үед сонирхдог гэж ойролцоогоор 3 хүн тутмын нэг нь буюу 27 хувь нь хариулсан байна.




- Маш их сонирхдог
- Сонирхдог
- Зарим үед сонирхдог
- Төдийлөн сонирхдоггүй
- Огт сонирхдоггүй

Зураг 8. Сонгуультай холбоогүйгээр орон нутгийнхаа бодлогыг сонирхож буй байдал

Иргэдийн сонгуультай холбоогүйгээр орон нутгийнхаа бодлогыг сонирхох байдлыг нийслэл, аймгаар харьцуулан үзвэл нийслэлийн иргэдийн 92.7 хувь нь зарим үед сонирхдог, сонирхдог, маш их сонирхдог гэж хариулсан байхад аймгийн иргэдийн 78 хувь нь ийм хариулт өгсөн байна. Мөн сонгуультай холбоогүйгээр орон нутгийн бодлогыг төдийлөн сонирхдоггүй, огт сонирхдоггүй гэсэн хариултын эзлэх хувийн нийлбэр нь аймагт (23), нийслэл (17.3)-ээс 4.7 пунктээр илүү байна. Эндээс дүгнэж үзэхэд нийслэлийн иргэдийг бодвол аймгийн иргэдийн орон нутгийнхаа бодлогыг сонгуультай холбоогүйгээр сонирхох байдал үл ялиг бага байна.


Иргэдийн оролцооны хэлбэр

Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрт өнөөг хүртэл ямар хэлбэрээр оролцож байгааг тодруулахад ямар нэгэн байдлаар оролцож байсан иргэдийн хариултаас харахад биеэр, цахимаар, бичгээр гэх мэт хэлбэрээр санал гомдлоо илэрхийлж оролцдог гэж илүүтэй хариулсан бол нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлагад оролцож ирсэн гэж нийт судалгаанд оролцогсдын 14 хувь нь хариулсан байна.



Зураг 9. Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрт оролцож буй хэлбэр, хувиар

- Улс төрийн байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр санал бодлоо илэрхийлж шууд оролцдог
- Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр шууд оролцдог
- Санал гомдлоо илэрхийлж оролцдог
- Байгууллагуудаар дамжуулж оролцдог
- Хуулиар олгогдсон оролцооны боломжуудыг ашигладаг
- Нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлагад оролцдог
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан санал бодлоо илэрхийлэх замаар оролцдог
- Цахим хэлбэрээр санал бодлоо илэрхийлж оролцдог (Facebook, Twitter, цахим санал асуулга гэх мэт)
- Жагсаал, цуглаанд нэгдэх замаар оролцдог
- Гарын үсэг цуглуулах замаар оролцдог
- Өнөөг хүртэл ямар нэгэн байдлаар оролцож байгаагүй




Зураг 10. Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэр гаргалтанд оролцож буй оролцооны хэлбэр, аймаг, нийслэлээр, хувиар

Оролцооны хэлбэр тус бүрийг насны бүлгээр харьцуулан харвал 56-аас дээш насныхны тухайд улс төрийн байгууллага, засаг захиргааны байгууллагын үйл ажиллагаа, хурал цуглаанд оролцох нь илүүтэй байдаг бол 46-55 насны иргэд жагсаал цуглаанд нэгдэх, санал гомдлоо илэрхийлэх хэлбэрээр оролцох нь илүү байдаг байна. Харин 36-45 насныхан байгууллагуудаар дамжуулж, гарын үсэг цуглуулах замаар, 18-35 насныхан цахим хэлбэрээр санал бодлоо илэрхийлдэг гэжээ.

Хүснэгт 7. Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрт оролцож ирсэн оролцооны хэлбэр, насны бүлэг, хувиар

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Улс төрийн байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр санал бодлоо илэрхийлж шууд оролцдог	9	10	15	13	22
Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр шууд оролцдог	2	4	7	12	21
Санал гомдлоо илэрхийлж оролцдог	22	26	20	37	29
Байгууллагуудаар дамжуулж оролцдог /ТББ, ашиг сонирхлын бүлгүүд гм/	9	7	11	6	10
Хуулиар олгогдсон оролцооны боломжуудыг ашигладаг	9	10	5	10	14
Нээлттэй, хэлэлцүүлэг, ярилцлагад оролцдог	7	8	18	15	29
Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан санал бодлоо илэрхийлэх замаар оролцдог	7	7	9	8	14
Цахим хэлбэрээр санал бодлоо илэрхийлж оролцдог / Facebook, Twitter... цахим санал асуулга гэх мэт/	31	20	9	3	-
Жагсаал, цуглаанд нэгдэх замаар оролцдог	7	4	9	13	11
Гарын үсэг цуглуулах замаар оролцдог	5	9	11	10	4
Өнөөг хүртэл ямар нэгэн байдлаар оролцож байгаагүй	28	26	25	16	15
Бусад	3	4	6	14	3

Орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж байгаа ажлыг иргэдийн талаас илүү хувь нь сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Харин хангалттай сайн гэж нийт иргэдийн 14.6 хувь нь хариулжээ. Тэгвэл



- Хангалттай сайн
- Сайжруулах шаардлагатай
- Хангалтгүй
- Хариулж мэдэхгүй

Зураг 11. Орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж байгаа ажлын талаарх иргэдийн үнэлгээ


тус асуудлын талаар ойлголт мэдлэггүй, мэдээлэлгүй байгаагаас шалтгаалж хариулж мэдэхгүй гэж ойролцоогоор 10 хүн тутмын нэг нь буюу 8.5 хувь нь хариулсан. Хангалтгүй гэсэн үнэлгээг 4 хүн тутмын нэг нь буюу 23.6 хувь нь өгсөн байна.

Орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо хэрхэн илэрхийлж оролцдог оос үл хамаарч иргэдийн 43-58 хувь нь орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж буй ажлыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Харин байнга санал бодлоо илэрхийлж оролцдог иргэдийн гуравны нэг нь тус ажилд хангалттай сайн гэсэн үнэлгээг өгчээ. Харин оролцооны идэвхи багатай болон оролцдоггүй иргэдийн тухайд хангалтгүй буюу хариулж мэдэхгүй гэсэн хариултыг түлхүү өгсөн байна.

Хүснэгт 8. Орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж байгаа ажлын талаарх иргэдийн үнэлгээ, иргэдийн оролцооны идэвхи, хувиар

Иргэдийн орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлж оролцож буй байдал				
Орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог хангах талаар зохион байгуулж байгаа ажлын талаарх иргэдийн үнэлгээ		Байнга оролцдог	Зарим үед оролцдог	Оролцдоггүй
Хангалттай сайн		33	8	6
Сайжруулах шаардлагатай		53	58	43
Хангалтгүй		11	22	26
Хариулж мэдэхгүй байна		4	12	24
Нийт		100	100	100

Иргэдийн орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад ямар үүрэгтэйгээр оролцох хүсэлтэй байгааг тандахад 8.4 хувь нь өөрийн саналыг боловсруулж өгөхийг, 27.0 хувь нь гаргасан саналуудад санал өгөхийг, 40.5 хувь нь гаргасан саналуудыг үнэлж дүгнэхийг, 12.9 хувь нь идвэхгүйгээр ажиглахыг хүсч байгаагаа илэрхийлсэн бол 11.3 хувь нь оролцохыг хүсэхгүй байна гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл иргэдийн 75.9 хувь нь буюу 4 хүн тутмын 3 нь орон нутгийнхаа удирдлагын шийдвэрт ямар нэгэн байдлаар оролцох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.




Зураг 12. Иргэдийн орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсч буй байдал

Иргэдийн хамгийн олон нь буюу 40.5 хувь нь гаргасан саналуудыг үнэлж, дүгнэхийг хүсэж байна гэсэн бол 27 хувь нь гаргасан саналуудад санал өгөхийг хүсч байгаагаас харахад иргэд өөрсдөө санал оруулах бус бэлэн гаргасан саналуудад саналаа өгөх, тэдгээр саналуудыг үнэлж дүгнэхийг илүүд үзсэн байна. Дээрх асуудлыг насны бүлгээр авч үзвэл тодорхой үүрэгтэйгээр удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсэхгүй байна гэж 18-25 насны залуучууд илүүтэй хариулжээ. Харин иргэдийн 40-60 хувь нь гаргасан саналд санал өгөх, үнэлж дүгнэх үүрэгтэйгээр орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсэж байна гэжээ. 56-аас дээш насныханы 63 хувь нь гаргасан саналуудад санал өгөхийг хүсч байгаагаа илэрхийлсэн байна.

Хүснэгт 9. Иргэдийн орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсч буй байдал, насны бүлэг, хувиар

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Оролцохыг хүсэхгүй байна	15	9	5	3	7
Идэвхигүйгээр ажиглахыг хүсч байна	8	11	7	10	8
Гаргасан саналуудыг үнэлж, дүгнэхийг хүсч байна	48	42	46	47	52
Гаргасан саналуудад санал өгөхийг хүсч байна	37	45	46	43	63
Өөрийн саналыг боловсруулж өгөхийг хүсч байна	20	25	19	20	18


Орон нутгийн удирдлагууд үйл ажиллагааныхаа хэрэгжилтийн талаар иргэддээ тайлагнадаг эсэхийг тодруулахад 20 хувь нь байнга тайлагнадаг, 45 хувь нь зарим үед тайлагнадаг, 12 хувь нь тайлагнадаггүй, 23 хувь нь тайлагнадаггүй эсэхийг нь мэдэхгүй гэж хариулсан байна.



Дээрх зургаас үзвэл ойролцоогоор 4 хүн тутмын нэг нь орон нутгийнхаа удирдлагууд үйл ажиллагааныхаа хэрэгжилтийг тайлагнадаг эсэхийг нь мэддэггүй, 2 хүн тутмын нэг нь зарим үед тайлагнадаг, ойролцоогоор 10 хүн тутмын нэг нь тайлагнадаггүй гэж хариулсан байна.

- Байнга
- Зарим үед
- Тайлагнадаггүй
- Тайлагнадаг эсэхийг нь мэдэхгүй

Зураг 13. Орон нутгийн удирдлагууд үйл ажиллагааныхаа хэрэгжилтийг иргэддээ тайлагнадаг эсэх талаар иргэдийн үнэлгээ



- Би цаашид илүү их оролцохыг хүсч байна
- Би одоо оролцож байгаагаасаа илүү оролцохыг хүсэхгүй байна

Зураг 14. Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрийг гаргахад цаашид оролцохыг хүсч буй байдал


Иргэд орон нутгийнхаа бодлого, шийдвэрийг гарахад илүү их оролцохыг хүсэж байна. Судалгаанд оролцогсдын 63 хувь нь орон нутгийнхаа бодлого, шийдвэрийг гаргахад одоо оролцож байгаагаасаа илүү их оролцохыг хүсэж байна гэж хариулсан бол үлдсэн 37 хувь нь оролцохыг хүсэхгүй байна гэжээ.

Орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлж хэрхэн оролцдогоос үл шалтгаалан хойшдоо орон нутгийнхаа бодлого, шийдвэрийг гаргахад одоо байгаагаасаа илүү их оролцохыг хүсч байна гэж нийт иргэдийн 5 хүн тутмын 3 нь хариулсан байна. Эндээс үзэхэд иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрт оролцох хүсэл сонирхол өндөр байгаа нь харагдаж байна. Энэ үр дүнг иргэдийн орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлж оролцох оролцоотой харьцуулж үзэхэд дараах дүн ажиглагдаж байна.

Хүснэгт 10. Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрийг гаргахад оролцохыг хүсч буй байдал, оролцооны идэвхи, хувиар

		Иргэдийн орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлэн оролцож буй байдал		
		Байнга оролцдог	Зарим үед оролцдог	Оролцдоггүй
Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрийг гаргахад илүү их оролцохыг хүсч буй байдал	Би одоо оролцож байгаагаасаа илүү оролцохыг хүсэхгүй байна	30	37	41
	Би цаашид илүү их оролцохыг хүсч байна	70	63	59
Нийт		100	100	100

Орон нутгийнхаа бодлого, шийдвэрийг гаргахад илүү оролцохыг хүсч байгаа иргэдийн хувьд бодлого шийдвэрт биеэр болон шууд хэлбэрээр оролцохыг илүүд үзэж байна. Мөн олон хэлбэрээр /цахим, санал асуулга, бичгээр, биеэр...гм/ санал өгөхийг хүсэж байна гэжээ. Нөгөөтэйгүүр бодлого, шийдвэрийн талаар хэлэлцэх хурал, хэлэлцүүлэгэд сууж өөрийн санал бодлыг илэрхийлэх зэрэгт ач холбогдол илүүтэй өгч байна.



Зураг 15. Орон нутгийнхаа бодлого, шийдвэрт илүү их оролцох хүсэлтэй байгаа иргэдийн ямар хэлбэрээр оролцох хүсэлтэй байгааг нээлттэй асуултаар тодруулахад, хувиар

Дээрх хэлбэрүүдээс хамгийн их нэрлэгдсэн ажлуудыг насны бүлгээр нь харвал хэлбэр тус бүрд нас насныхан ялгаатай байдлаар хариулжээ. Тодруулбал биеэр, шууд хэлбэрээр оролцоно гэж 36-аас дээш насныхан хариулсан бол хурал, хэлэлцүүлэг, ярилцгад оролцох гэж 46-55 насныхан, олон хэлбэрээр санал өгөх гэж 18-25 насны залуучууд ихэвчлэн хариулжээ.

Хүснэгт 11. Орон нутгийнхаа бодлого, шийдвэрт оролцох хүсэлтэй байгаа иргэдийн оролцооны хэлбэр, насны бүлэг, хувиар

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Оролцохыг хүсэж байна.	7	4	2	8	6
Бусад	1	-	-	-	-
Мэдээлэл авах	3	2	5	3	1
Бүлэг байгуулж, олны санал авсан ажил хийх	1	-	-	0	0
Биеэр, шууд хэлбэрээр оролцох	7	6	9	9	12
Хурал, хэлэлцүүлэг, ярилцлагад оролцох	5	2	8	12	8
Ажиглагчаар	-	1	1	-	-
Олон хэлбэрээр санал өгөх /интернэт, анкет, бичлэг...гм/	17	6	11	6	2


Мэдэхгүй	1	-	1	-	1
Хороогоор дамжуулж	-	-	1	-	-
Үнэлж, дүгнэх хэлбэрээр	-	-	2	1	1
Санал байхгүй	-	-	1	-	-
Иргэний үүргээ биелүүлэх	-	-	1	-	-
Нийт	42	21	42	39	31

Оролцооны хэлбэрийг ажил эрхлэлтээр авч үзвэл, биеэр, шууд хэлбэрээр оролцоно, хурал, хэлэлцүүлэг, ярилцлагад оролцоно гэж тэтгэврийнхэн илүүтэй саналаа бичжээ. Харин олон хэлбэрээр санал өгөх гэсэн хэлбэрийг цалин хөлстэй ажиллагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч нар илүү илэрхийлсэн байна.

Хүснэгт 12. Иргэдийн орон нутгийнхаа бодлого, шийдвэрт оролцохыг хүсч буй оролцооны хэлбэр, хөдөлмөр эрхлэлтээр, тоогоор

	Цалин хөлстэй ажиллагч	Ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Нөхөрлөл, хоршооны гишүүн	Мал аж ахуй эрлэгч	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлстэй оролцогч	Тэтгэвэрт	Оюутан, суралцагч	Ажилгүй	Бусад
Оролцохыг хүсэж байна	6	-	8	-	-	-	7	2	3	1
Бусад	-	-	-	-	-	-	-	1	-	-
Мэдээлэл авах	1	-	7	-	-	-	5	-	1	-
Бүлэг байгуулж, олны санал авсан ажил хийх	-	-	-	1	-	-	-	-	-	-
Биеэр, шууд хэлбэрээр оролцох	7	-	8	-	-	1	17	3	5	2
Хурал, хэлэлцүүлэг, ярилцлагад оролцох	10	1	6	-	-	-	14	-	4	-
Ажиглагчаар	1	-	-	-	-	-	1	-	-	-
Олон хэлбэрээр санал өгөх / интернэт, анкет, бичлэг...гм/	11	-	12	-	-	-	7	4	6	2
Мэдэхгүй	-	-	1	-	1	-	-	-	1	-
Хороогоор дамжуулж	-	-	-	-	-	-	1	-	-	-
Үнэлж, дүгнэх хэлбэрээр	1	-	-	-	-	-	3	-	-	-
Санал байхгүй	1	-	-	-	-	-	-	-	-	-
Иргэний үүргээ биелүүлэх	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт	38	1	42	1	1	1	55	10	20	5

Орон нутгийнхаа бодлого, шийдвэрт одоо оролцож байгаагаасаа илүү оролцохыг хүсэхгүй байна гэсэн иргэдээс яагаад гэсэн асуултыг нээлттэй хэлбэрээр асуухад 28.9 хувь нь завгүй, 18.7 хувь нь энэ талаар мэдээлэл байдаггүй учраас гэсэн хариултыг өгсөн юм. Мөн иргэд санал өгсөн ч тэдний саналыг хүлээж авдаггүй, дээгүүр шийдэгддэг, хэрэгжилт муу байдаг учраас оролцохыг хүсэхгүй байна гэж 12.4 хувь нь хариулсан бол мөн 12.5 хувь нь бидний саналыг хүлээж авдаггүй, дээгүүр шийдэгддэг гэж хариулжээ. Харин оролцогчдын 0.8-1.4 нь намын харьяалал нөлөөлдөг, олны аяыг дагана, ялгаварлан галуурхдаг, ач холбогдолгүй гэж боддог, байнга оршин суудаггүй гэж хариулсан байна.



Зураг 16. Орон нутгийнхаа бодлого, шийдвэрт одоо оролцож байгаагаасаа илүү оролцохыг хүсэхгүй байгаа шалтгаан, хувиар

2.1.2. Иргэний танхимын үйл ажиллагаа (Бүх түвшинд)

Шууд ардчилал-иргэдийн оролцоонд тулгуурласан ажлыг эрчимжүүлэх, түүнд дэм өгөх зорилгоор практикт хийгдсэн нэг ажил бол Монгол орон даяар зохион байгуулагдсан Иргэний танхимын үйл ажиллагаа юм. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилсан шууд ардчилал-иргэдийн оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах үзэл санааны хүрээнд хийгдсэн нэгэн томоохон ажил бол Иргэний танхим юм.

“Шууд ардчилал-иргэдийн оролцоотой төсвийн менежментийн үндэсний сургалт-зөвлөлгөөн” (2013 оны 2 дугаар сарын 25 төрийн ордон)-д Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлсэн үгэндээ шууд ардчилал-иргэдийн оролцооны талаар онцгойлон анхаарч түүний онол практикийн ач холбогдолыг хөндөж тавьсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Иргэний танхим”

Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон төрийн бодлого шийдвэрт иргэдийн байр суурь, үзэл бодлыг тусгах иргэдийн санал бодлыг шийдвэр гаргагчид сонсох, олон нийтийн санаа зовоож буй асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах зорилгоор байгуулагдсан Төрийн ордны 3 давхарт өмнөх Ерөнхийлөгчидийн албан ажлын өрөө, тасалгаануудыг тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээр өөрчлөн тохижуулж, тоног төхөөрөмж, техник хэрэгслэл зэргийг багагүй хөрөнгө төсөв зарцуулж ашиглалтанд оруулжээ. Одоогоор энд орон тооны гурван ажилтан ажиллаж байна.

Тус Иргэний танхим нь 2009 онд байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2009 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 20-р захирамжийн хавсралтаар батлагдсан журмыг мөрдөн ажиллаж байна. Уг журамд Иргэний танхимын зорилго, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлжээ. Бас иргэний танхимын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, иргэний танхимд хэлэлцэх төслийг олон нийтэд зарлах, хэлэлцүүлэгт саналаа ирүүлэх, хэлэлцүүлэгт оролцох дараалал, хэлэлцүүлгийн бэлтгэл хангах, хэлэлцүүлгийн дэг, хэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг шийдвэрт тусгах харилцаануудыг уг журамд тусгасан байна. Иргэний танхимын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нээлттэй хэлэлцүүлэг бөгөөд энэ нь оролцогч тал, асуудал оруулагч тал, зохион байгуулагчаас бүрдэнэ. Үүнийг бүдүүвчлэн харуулвал;



Зураг 17. Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхим дахь нээлттэй хэлэлцүүлэг

Манай улсад үйл ажиллагаа явуулдаг гадаадын болон Олон улсын байгууллага аж ахуйн нэгжийн төлөөлөл урилгаар оролцож болохыг уг журманд тусгаж өгчээ.

Нээлттэй хэлэлцүүлэгт оролцохыг хүссэн иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлэлцүүлэг зарламагц:

- Иргэний танхимд хаягласан захидал
- Факс
- Е-шуудан (irgen@president.mn)
- www.irgen.org.mn хаягаар саналаа ирүүлэх эсвэл биечлэн оролцох боломжтой.


Ажлын алба биечлэн оролцох хүсэлтэй, бүртгэгдсэн болон урилгаар оролцох иргэдийн нэрийг иргэний танхимын вэб сайтад хэлэлцүүлэг эхлэхээс нэг хоногийн өмнө байршуулах дүрэмтэй.

Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын үйл ажиллагаа нь дүрэмд заасан үндсэн хэлбэр болох нээлттэй хэлэлцүүлэгийн зарчмыг мөрдөн ажиллах учиртай. Энэхүү Иргэний танхим 2009 оны 12 дугаар сарын 15-нд нээгдэж, нээлтийн ажиллагаанд нь 150 хүн оролцож байснаас хойшхи таван жилд (2010, 2011, 2012, 2013, 2014) нээлттэй хэлэлцүүлэг ба бусад хэлбэрээр (Ажлын албаны хурал, хэвлэлийн бага хурал, мэдээлэл, сургалт, лекц, уулзалт, иргэний танхимыг үзэж танилцах гэсэн хүмүүст боломж олгох гэх мэт) үйл ажиллагаагаа явуулж иржээ. Тэдгээрийг зохион байгуулагдсан арга хэмжээний төрөл, оролцсон хүний тоо, ажлын цагийн ачаалал зэргээр тоймлон харуулвал дараах дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 13. Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулагдсан арга хэмжээний тойм, сүүлийн 5 жилийн байдал, тоогоор

	Зохион байгуулагдсан үйл ажиллагаа	2010		2011		2012		2013		8/1/2014		Бүгд	
		Тоо	Оролцогчид	Тоо	Оролцсон иргэд	Тоо	Оролцсон иргэд	Тоо	Оролцсон иргэд	Тоо	Оролцсон иргэд	Тоо	Оролцсон иргэд
1	Ажлын хэсгийн хурал	9	343	6	137	10	231	7	128	4	56	36	895
2	Нээлттэй хэлэлцүүлэг	15	1259	49	2738	36	2205	22	1353	11	609	133	8164
3	Уулзалт	14	790	16	874	12	454	20	1177	12	270	74	3565
4	Хуулийн төслийн хэлэлцүүлэг	13	779	8	492	2	123	11	721	13	645	47	2760
5	Хэвлэлийн бага хурал	13	482	3	100	3	60	10	274	1	15	30	931
6	Танхимтай иргэд танилцсан	3	105	13	372	4	111	7	310	1	8	28	906
7	ЕТГ-ын дотоод хурал	8	207	3	68	11	234	2	61	0	0	24	570
	Нийт	75	3965	98	4781	78	3418	79	4024	42	1603	372	17791

Тойм судалгааны дүнгээс харахад Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимаас зохион байгуулж буй нийт арга хэмжээнд иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг хийх ажил нь 35.8 хувийг, түүнд хамрагдаж буй оролцогчдын хувь 45.9 хувь байна. Энэ нь иргэний танхимын үйл ажиллагааг нээлттэй хэлэлцүүлэгт түлхүү чиглүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Бас иргэний танхимыг цагийн ачааллынх нь талаас харахад иргэдийн дунд зохион байгуулж буй нээлттэй хэлэлцүүлэгт зарцуулж байгаа цаг хугацааны жилийн дундаж нь 160 цаг буюу ажлын 20 өдөр болж байна. Харин нийт арга хэмжээнд зарцуулж буй цаг хугацаа нь 249.6 цаг буюу ажлын 31 өдөр болж байна. Энэ нь Ерөнхийлөгчийн дэргэдэх иргэний танхимын үйл ажиллагаа, зохион байгуулалт, танхим хийгээд цаг ашиглалтыг оновчтой, үр өгөөжтэй болгох талаар өөр хувилбар, үр ашигтай хэлбэр байж болохыг үгүйсгэхгүй байгаа юм.



- Нээлттэй хэлэлцүүлэг
- Уулзалт
- Хуулийн төслийн хэлэлцүүлэг
- Хэвлэлийн бага хурал
- Танхимтай иргэд танилцсан
- ЕТГ-ын дотоод хурал
- Ажлын хэсгийн хурал

Зураг 18. Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулагдсан арга хэмжээний тойм, түүнд оролцогчид, хувиар

Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулагдсан үйл ажиллагаануудыг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл ажлын хэсгийн хурал, нээлттэй хэлэлцүүлэг, уулзалт, хуулийн төслийн хэлэлцүүлэг, хэвлэлийн бага хурал, иргэний танхимтай танилцах, ЕТГ-ын дотоод хурал гэсэн үндсэн чиглэлүүдэд ангилж болохоор байна. Ийм байдлаар ангилж үзвэл дээрх хугацаанд нийт 372 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулсанд 17791 хүн оролцсон байна. Оролцогчдыг үйл ажиллагааны төрөлд эзлэх хувиар нь авч үзвэл дараах үр дүн ажиглагдлаа.

Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулагдсан үйл ажиллагаанд оролцогчдын 46 хувь нь Нээлттэй хэлэлцүүлэгт, 20 орчим хувь нь уулзалтанд, 16 хувь нь хуулийн төслийн хэлэлцүүлэгт, 5 хувь нь хэвлэлийн бага хуралд, 5 хувь нь ажлын хэсгийн хуралд, мөн 5 хувь иргэний танхимтай танилцсан байна. Харин 3 хувь нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын дотоод хуралд суух замаар иргэний танхимд оролцсон байна.

Иргэний танхимын талаар санаачилгыг гаргаж өөрийнхөө дэргэд түүнийг байгуулсан субъектын хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн институт нь аймаг орон нутагт байгуулагдсан иргэний танхимуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, удирдах хандлага гаргах бус харин санал зөвлөмж хүргүүлэх замаар ажлыг нь жигдрүүлэх, нэгдсэн гольдролд оруулах чиглэлээр анхаарч ажилладаг байна. Үүний нэг илрэл нь “Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимаас гаргасан “Иргэдийн оролцоонд тулгуурласан нутгийн өөрөө удирдах ёс” хэмээх гарын авлага ажээ.

Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимтай холбоотой ажилладаг нэгэн ажилтны ярианд тулгуурлаж IRI-ийн шугамаар хийгдсэн судалгаанд “2013 оны 10 дугаар сарын эх гэхэд бүх аймаг, Улаанбаатар хотын бүх дүүрэг болон нийслэлд Иргэний танхим байгуулагдсан ба нийт 283 байгуулагдаад байна. Цаашид Зүүн аймгуудад дахин 48-ыг байгуулахаар төлөвлөж байна.

Иргэний танхимын үйл ажиллагааг ихэнхидээ орон нутгийн ИТХ-ын ажлын алба эрхлэн явуулж байна. Эдгээр танхимын ихэнх нь “Иргэдийн оролцоонд суурилсан орон нутгийн өөрийн удирдлага” (2010) хэмээх гарын авлагыг мөрдлөгө болгодог гэж тэмдэглэсэн байна (дээр дурьдсан номын 9-р тал).

Энэхүү гарын авлагад “Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тухайн орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, харин төлөөлөгчид бол иргэдийн дуу хоолой, элч төлөөлөл юм. Тийм учраас иргэдийн саналыг тогтмол сонсож, тэдний оролцоотойгоор шийдвэр гаргах хэрэгтэй. Энэ л зорилгоор Иргэний танхимыг ИТХ-ын дэргэд санаачилж байгуулахыг төлөөлөгчдөд зөвлөж байна” (хуудас 2) гэж бичсэн байна. Үүнээс үзэхэд Иргэний танхим нь иргэд шууд ардчилалын замаар эцсийн шийдвэр гаргахад бус төлөөллийн ардчилалыг аль болох иргэдийн оролцоонд тулгуурлан цаашид хөгжүүлэх чиглэлд үйлчлэх учиртайг гаргаж өгчээ. Энэ гарын авлагад:

- Иргэний танхимын зорилго, үүрэг
- Иргэний танхим байгуулахад саад болж буй шалтаг шалтгааныг хэрхэн давж туулах,
- Иргэний танхимыг ажиллуулахад гарч болзошгүй алдаанаас хэрхэн зайлсхийх
- Иргэний танхимд хийх хэлэлцүүлгийн дэс дараалал зэрэгтэй холбоотой чухал зөвлөмжүүд агуулагдаж байгааг дурьдах нь зүйтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын үүрэг, үр нөлөөг гадны судалгааны байгууллагын бүтээлд ч өвөрмөц өнцгөөс үнэлж дүгнэсэн үзэгдэнэ. Тухайлбал, Бүгд Найрамдахчуудын Олон улсын хүрээлэнгээс гаргасан “Багийн түвшинд иргэдийн оролцоо, эргэх холбоог сайжруулах нь” бүтээлд: “Хэдийгээр иргэний танхимын уулзалт хэлэлцүүлэгүүдийг сум болон аймгийн түвшинд удирдан хэрэгжүүлдэг ч үндсэндээ Ерөнхийлөгчийн Тамгын газар дээр нийтэд нь хянаж байдаг. ЕТГ нь хэлэлцүүлгийн хуваарийг гаргаж олон нийтийн зөвлөмжийг хүлээн авч, хэлэлцүүлэг сонсголыг зохион байгуулж гарсан үр дүнгийн талаар олон нийтэд тайлагнадаг” гэж тодорхойлсон байна. Харин бидний судалгаанд хамрагдсан аймаг, сумд, нийслэл, дүүрэгүүдийн иргэний танхимын үйл ажиллагаа хэлэлцүүлэгүүдийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын зүгээс хянаж байгаа байдал харагдаагүй гэдгийг тэмдэглэж байна.

Аймаг, нийслэлийн Иргэний танхим

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачлагаар Ерөнхийлөгчийн дэргэдэх иргэний танхим 2009 онд байгуулагдсаны дараагаар аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд “Иргэний танхим” борооны дараах мөөг шиг ар араасаа цувран байгуулагдаж эхэлжээ. Гэвч 2013 оны эх гэхэд нийт аймаг, суманд бүрэн байгуулагдаж дуусаагүй байсан байна. Иймээс “Шууд ардчилал-иргэдийн оролцоотой төсвийн менежмент” үндэсний сургалт зөвлөлгөөнд Ерөнхийлөгч үг хэлэхдээ “Иргэний танхимгүй аймгийн удирдлага бол ичих хэрэгтэй, Иргэний танхимгүй сумын удирдлага ичих хэрэгтэй. Байгуулаагүй бол байгуулах хэрэгтэй. Ерөөсөө иргэдийн хурлын үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болоод явна. Заавал заал танхим шаардаад байх хэрэггүй. Иргэд чинь цуглахдаа хаана цугладаг юм тэр газраа иргэний танхимаа байгуулаад хүнд хариуцуулж яв” гэж хэлсэн нь “Иргэний танхим” аймаг, суманд байгуулагдах үйл явцад түлхэц өгсөн нь харагдаж байна. Судалгааны хүрээнд хамрагдсан нийслэл, дүүрэг, аймаг, сум бүрт эдүүгээ Иргэний танхимгүй газар алга байгаа бөгөөд тэдгээрийн зорилго, үйл ажиллагаанд чиглэл, дүрэм, бүтэц нь нийтлэгдүү байгаа ч байгуулсан субъект харьяалагдах байдал, танхимын багтаамж, тоног төхөөрөмж, орон тоо, тэнд ажиллаж байгаа хүний нөөцийн статус зэргээрээ ялгаатай тал ажиглагдаж байв.

Нийслэлийн иргэний танхим

Нийслэлийн Иргэний танхим нь НИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор 2011 онд байгуулагдсан, харьяаллын хувьд НИТХ-ын ажлын албанд “Иргэний оролцооны хэлтэс” байгуулагдсанаар түүнд харьяалагдах болжээ.

НИТХ-аас шийдвэр гаргаж (2012 оны 08 сарын 27-ны 2/07 тоот тогтоол) Монгол улсын Ерөнхийлөгчөөс дэвшүүлсэн шууд ардчилал-иргэдийн оролцоог төлөвшүүлэх хүрээнд тогтоол, дүрэм, журмын төсөлд иргэд байгууллагуудаас санал шүүмжлэл авах, нэмэлт өөрчлөлтийн санал оруулах, мэдээлэл хүлээн авч нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлж саналыг нь тусгах замаар НИТХ-ын түвшинд гаргах шийдвэрийг төгөлдөржүүлэн бодитой болгох зорилт дэвшүүлж иргэний танхимаа энэ зорилтыг хэрэгжүүлэх чиглэлд ажиллуулахаар болжээ.

Нийслэлийн Иргэний танхимын үйл ажиллагаа нийслэлийн иргэн бүрт нээлттэй байна гэсэн зарчимтай. 2013 онд давхардсан тоогоор нийтдээ 81 удаагийн сургалт, уулзалт, зөвлөлгөөн энд зохион байгуулагдаж 15852 иргэн хамрагдсан байна.

2014 онд 6 томоохон хэлэлцүүлэг, 10 сургалт, 23 удаа уулзалт зөвлөлгөөн зохион байгуулжээ. Эдгээр хэлэлцүүлгийн үр дүнд:

- Нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах баримт бичгүүдийн төслийг нээлттэй хэлэлцүүлж 2014 оноос эхлэн 52 байршилд 15309 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд эзэмшүүлэх асуудлыг боловсруулж НИТХ-ын 10/39-р тогтоолд тусгажээ.
- Нийслэлийн томоохон техникийн болон барилгын захуудын барилгын байршлыг тогтоох саналыг ч мөн хэлэлцүүлсэн байна. Энэ хэлэлцүүлэгт 500 өрхөд зар хүргэснээр 92 иргэн 11 хэвлэл мэдээллийн албаны 21 төлөөлөл ирж оролцжээ. Нийслэлийн Иргэний танхимын үйл ажиллагааны талаар уулзаж ярилцсан хүмүүс ажлын эхлэл тийм ч муугүй байгааг дурьдахын зэрэгцээ шүүмжлэх өнгө аяс цухалдуулах нь ч тааралдаж байв.

Шийтгээ 3. Нийслэлд “Иргэний танхим”-ыг НИТХ-ын ажлын албанд “Иргэний оролцооны хэлтэс”-д харьяалуулж байгуулсан. Үйл ажиллагаа санасан хэлжээнд хүртэл жигдэрч өгөхгүй байна. Хамгийн гол нь иргэний үүсгэл санаачилгаар, иргэдийн идэвхитэй оролцоонд түшиглэсэн уян хатан, иргэдийн өөрсдийнх нь зохион байгуулалтын хэлбэрээр ажиллавал үр дүнтэй байлаар байна. Зөвхөн танай нийслэлийн Иргэний танхим төдийгүй, хаа сайгүй л институтчилэгдсэн бүтэц таяаг руугаа хэлбийгээд байх шиг байна. Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхим ч гэсэн иргэд тэр бүр орох бололцоогүй “Ордонд” байгаа нь ч бодож үзтээр байгаа юм.

Нийслэлийн ИТХ-ын Иргэний оролцооны газрын дэргэдэх Иргэний оролцооны хэлтсийн дарга Баттулгын ярианаас

2014 оны 8 сарын мэдээгээр нийслэлийн 9 дүүрэгт Иргэний танхим ажиллаж байгаагийн дээр Хан-Уул дүүрэгт 16, Чингэлтэйд 19, Сонгинохайрханд 16, Сүхбаатарт 1, Баянзүрх 28, Баянголд 23, Багахангайд 2, Налайх 3, Багануурт 3 хороодод буюу 117 хороонд Иргэний танхим байгуулагдаад буй нь нийт хороодын 78% ажээ.

Нийслэлийн Иргэний танхимын үйл ажиллагаа нь мэдээлэл, сургалт, уулзалт давамгайлсан, харин хэлэлцүүлэг цөөн аж. Судалгааны тайлан бичиж байх энэ үед нийслэлийн Иргэний танхимд 2014 оны Шилдэг сэтгүүлчдэд олгох шагнал гардуулах ёслол болж байгаа нь үйл ажиллагааны нийтлэг төрхийг тодорхойлох мэт.

Иргэний танхим 300 хүний суудалтай, бүрэн тоноглогдсон том заалтай. Байгуулагдсанаасаа хойш уг хэлтсээс нэг улс төрийн ажилтан хариуцан ажилладаг.

Иргэний танхимын шаардлагыг хангахгүй зарим тоног төхөөрөмжийг сольж 4,227,000 төгрөгийн сэлбэлт хийсэн байна.

Тохижилтод 1,7 сая орчим төгрөг зарцуулсан гэнэ. Уг хэлтэс Нийтлэг үйлчилгээний газартай хамтран Иргэний танхимын ашиглалтын болон түрээсийн журмыг боловсруулж 2013 оны 6 дугаар сараас батлан мөрдөж буй.

Ярилцлага өгсөн хүмүүс хэлэхдээ нийслэлийн Иргэний танхим нь үйл ажиллагаа, зохион байгуулалт, удирдлагын хувьд дээшээ Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимтай, доошоо дүүрэг, хорооны иргэний танхимтай ажлын уялдаагүй бие даасан шинжтэй гэж хэлж байлаа. Энэ нь Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын хэсэгт дурьдсан зүйлүүдтэй бага зэрэг зөрүүтэй байна гэсэн сэтгэгдэл төрүүлж байлаа. Ядаж л нийслэлийн Иргэний танхимаас хорооны Иргэний танхимын дүрмийн төсөл боловсруулж тараасан. Түүнд хорооны Иргэний танхимын зорилго, зорилт, гүйцэтгэх үүрэг, удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаа танхимын үйл ажиллагаанд иргэний оролцоог тусгаж өгсөн байна. Энэ нь нийслэлийн Иргэний танхим, хороодын Иргэний танхим хоёрын хооронд бага ч гэсэн холбоо байгааг илтгэнэ.

Аймгийн Иргэний танхим

Аймгуудад байгуулагдсан Иргэний танхимууд нь нийтдээ ижил төстэй, аймаг орон нутгийн түвшинд гарч байгаа бодлого шийдвэрийн төсөлд иргэдийн саналыг авч тусгах, тэр чиглэлээр өргөн олны дунд бүтээлч хэлэлцүүлэг өрнүүлэх зорилготой аж. Гэвч бичиг баримтын болон ярилцлагын аргаар хийсэн судалгааны явцад зарим талын ялгаа ажиглагдаж байна. Үүнд: *Нэгдүгээрт*, ихэнхи аймгуудын Иргэний танхим харьяаллын хувьд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор тус хурлынхаа дэргэд байгуулагдсан байхад зарим аймгуудад Иргэний танхим нь аймгийн Засаг дарга эсвэл аймгийн ЗДТГ-ын даргын шийдвэрээр засаг талдаа, тамгын газрын дэргэд байгуулагдан ажиллаж байна (Тухайлбал, Өвөрхангай, Баянхонгор аймаг).

Хоёрдугаарт, аймаг, нийслэлийн Иргэний танхимын үйл ажиллагааны дүрэм нь бас л нийтлэгдүү, Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын журмыг үл ялих өөрчлөн орон нутгийн шинжтэй болгон баталсан байгаа ч зарим газар уг журмаа аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор, зарим газар Засаг даргын Тамгын газрын захирамжаар батлан мөрдөж байна.

Гуравдугаарт, Иргэний танхимд зохион байгуулагдах нээлттэй хэлэлцүүлгийн оролцогч тал, асуудал оруулагч талууд судалгаанд хамрагдсан аймгуудын хувьд нийтлэгдүү байгаа ч зохион байгуулагч талын хувьд янз янзаар томъёологдон хэрэгжиж байна. Тухайлбал, Нээлттэй хэлэлцүүлгийн Зохион байгуулагч нь Өвөрхангай аймагт Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Баянхонгор аймагт, Иргэний танхимын зөвлөл (энэ зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн засаг даргын зөвлөл, нутгийн захиргааны болон төрийн бус байгууллаг, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл орох бөгөөд зөвлөлийн ажлын албаны ажлын байрны тодорхойлолт, тэнд ажиллах хүнийг Тамгын газрын дарга батална), бусад аймгуудад иргэний танхимын зохион байгуулагч нь ИТХ-ын ажлын алба байгаа юм.

Дөрөвдүгээрт. Иргэний танхим байгуулахдаа бусдын жишгийг дагах гэхээсээ өөрийнхөөрөө хандаж өвөрмөц маягаар хандсан аймаг нь Өвөрхангай гэж болохоор байна. Энэ аймаг Иргэний танхимаа аймгийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагаатай холбож өгснөөс гадна Иргэний танхимынхаа дэргэд сайн дурын иргэний зөвлөл ажиллуулж нээлттэй хэлэлцүүлэгээс гарсан санал зөвлөмж нь бодлого, шийдвэрт хэрхэн тусч буйд хяналт тавих чиг үүрэг хүлээлгэсэн байна.

Тавдугаарт, Иргэний танхимын өмч хөрөнгө, тоног төхөөрөмж үйл ажиллагааны зардал, хариуцсан ажилтны хувьд бага зэргийн ялгаа байгаа ч зарчмын хувьд нийтлэг буй төрх ажиглагдаж байна.

Иргэний танхим, иргэдийн оролцооны хоорондын амьд холбооны талаар иргэдээс авсан санал асуулгын дүн тус бүтцийн үйл ажиллагааг зарим талаар тодруулж өгч байгаа юм.

Хүснэгт 14. Иргэдийн Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй байдал, насны бүлэг, хувиар

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Тийм	27	31	37	39	38
Үгүй	73	69	63	61	62
Нийт	100	100	100	100	100

Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож байсан иргэдийн 61 хувь нь ямар нэг хурал, сургалтанд хамрагдаж байсан байна. Харин 17 хувь иргэний танхимаас зохион байгуулагдсан үйл ажиллагаанд оролцож байсан гэжээ.



Иргэний танхимын үйл ажиллагаа нь одоогоор иргэдээ татах зорилгоор янз бүрийн хурал, сургалтуудыг зохион байгуулах арга барилаар ажиллаж байгаа болно. Хорооны Иргэний танхимын дүрмийн төсөл боловсруулж тараасан түүнд Хорооны Иргэний танхимын зорилго, зорилт, гүйцэтгэх үүрэг удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаа танхимын үйл ажиллагаанд иргэний оролцоог тусгаж өгсөн.

Хурал, сургалтанд иргэдийн 18-25 нас, 36-45 нас, 56-аас дээш насныхан, ажил эрхлэлтээр авч үзвэл цалин хөлстэй ажилтан, тэтгэврийнхэн илүүтэй хамрагдсан гэжээ. Үүнээс харахад иргэний танхимын үйл ажиллагаанд идэвхитэй оролцогчид нь 56-аас дээш насны тэтгэврийн хүмүүс байна.

Зураг 19. Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн оролцооны хэлбэрийг нээлттэй асуултаар тодруулахад, хувиар

Хүснэгт 15. Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн оролцооны хэлбэр, насны бүлэг, тоогоор


	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Иргэний танхимаас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцож байсан	4	4	2	6	2
Хурал, сургалтанд хамрагдаж байсан	14	8	21	8	12
Санал өгч байсан	2	1	1	1	-
Хийн дасгал, дасгал хөдөлгөөн хийхэд хамрагдаж байсан	1	3	-	5	2
Үйл ажиллагааг хамтран зохион байгуулж оролцож байсан	3	-	-	-	-
Спорт уралдаан тэмцээнд оролцож байсан	-	-	-	-	2
Бусад /шууд холбогдолгүй хариулт/	-	1	-	-	-
Нийт	24	17	24	20	18

Хүснэгт 16. Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн оролцооны хэлбэр, хөдөлмөр эрхлэлт, тоогоор

	Цалин хөлстэй ажиллагч	Ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Нөхөрлөл, хоршооны гишүүн	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлстгүй оролцогч	Тэтгэвэрт	Оюутан, сурагцагч	Ажилгүй	Бусад
Иргэний танхимаас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцож байсан	1	-	3	1	-	5	1	5	2
Хурал, сургалтанд хамрагдаж байсан	16	2	7	2	2	17	4	12	1
Санал өгч байсан	4	-	1	-	-	-	-	-	-
Хийн дасгал, дасгал хөдөлгөөн хийхэд хамрагдаж байсан	4	-	-	-	-	4	1	1	1
Үйл ажиллагааг хамтран зохион байгуулж оролцож байсан	1	-	-	1	-	-	1	-	-
Спорт уралдаан тэмцээнд оролцож байсан	-	-	1	-	-	2	-	-	-
Бусад /шууд холбогдолгүй хариулт/	1	-	-	-	-	-	-	-	-
Нийт	27	2	12	4	2	28	7	18	4

Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож байсан хүмүүсийн 22 хувь нь иргэний танхимаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох, 15 хувь нь хурал, зөвлөгөөнд оролцох байдлаар тус танхимын үйл ажиллагаанд оролцоно гэжээ. Эндээс өнгөц харахад иргэний танхимын үйл ажиллагаанд оролцохыг хүсэж байгаа боловч тус танхимын зорилгын талаарх мэдээлэлгүй байна. “Иргэний танхимын зорилго бол тухайн нутаг орны тулгамдсан асуудлаар шийдвэр гарагахад иргэдийн оролцоог хангахад үйлчлэх мэдээлэл түгээх хэрэгсэл, иргэд саналаа хэлэх индэр мөн”²⁰ гэсэн байдаг.

Гэтэл хороодын төвшинд иргэд иргэний танхим гэдгийг эсгий эдлэлийн сургалт, дасгал хөдөлгөөний сургалт, бүжгийн сургалт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар гэх мэтээр ойлгож байгаа нь судалгааны явцад ажиглагдсан. Угтаа бол иргэний танхимд иргэний оролцооны талаарх мэдээллийг иргэдэд түгээж, тэр чиглэлээр сургалт зохион байгуулж, зорилгынхоо хүрээнд ажиллах ёстой.



Зураг 20. Иргэдийн Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцохыг хүсч буй оролцооны хэлбэрийг нээлттэй асуултаар тодруулахад, хувиар

Хүснэгт 17. Иргэний танхимын үйл ажиллагаанд иргэдийн оролцохыг хүсч буй оролцооны хэлбэр, насны бүлэг, тоогоор


	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Санал хүргүүлж, солилцох	3	2	3	1	-
Иргэний танхимаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох	4	-	4	4	4
Чөлөөт цагаа өнгөрөөх /бүжиглэх, тоглох...гм/	-	-	1	1	1
Хурал, зөвлөгөөнд оролцох	-	-	4	4	3

20 Н.Баясгалан. “Орон нутгийн түвшинд иргэдтэй зөвлөлдөн, хамтран ажиллах арга”. 2012 он.

Иргэний танхимаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд тогтмол оролцоно.	5	4	3	2	2
Зорилтот бүлэгт хандсан үйл ажиллагаанд оролцох	-	-	-	1	-
Цахим хэлбэрээр	2	-	1	-	-
Сургалтанд хамрагдах	-	-	1	-	1
Бусад	2	1	-	1	5
Хамтарч ажиллана	-	-	1	-	1
Мэдээлэл авах	-	2	-	-	-
Нийт	16	9	18	14	17


Иргэний танхим байдаг гэдэг нь иргэдэд тодорхой хэмжээнд танигдсан байна. Гэхдээ иргэний танхимын үйл ажиллагааны зорилго, ач холбогдлын талаарх мэдээлэл муу байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.

Судалгаанд оролцогсдын 25 хувь нь Иргэний танхимын үйл ажиллагааны талаарх мэдээлэл хүртээмж муутай гэж дүгнэжээ.



- Хангалттай хүртээмжтэй
- Мэдээллийн хүртээмжийг сайжруулах шаардлагатай
- Хүртээмж муутай
- Хариулж мэдэхгүй

Зураг 21. Иргэний танхимын үйл ажиллагааны мэдээллийн хүртээмжийн талаарх иргэдийн үнэлгээ, хувиар




- Хангалттай сайн
- Сайжруулах шаардлагатай
- Хангалтгүй
- Хариулж мэдэхгүй байна

Зураг 22. Иргэний танхимын үйл ажиллагааны талаарх судалгаанд оролцогчдын үнэлгээ, хувиар

Хүснэгт 18. Иргэний танхимын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ, насны бүлэг, хувиар

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Хангалттай сайн	15	13	24	21	23
Сайжруулах шаардлагатай	38	44	36	51	42
Хангалтгүй	14	23	16	19	9
Хариулж мэдэхгүй байна	33	21	24	9	26
Нийт	100	100	100	100	100



■ Тийм
■ Үгүй

Зураг 23. Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй байдал

Иргэний танхимын үйл талаарх иргэдийн үнэлгээг насны бүлгээр харьцуулан авч үзэхэд 36-аас дээш насныханы 21-24 хүртэлх хувь нь хангалттай сайн гэсэн үнэлгээг өгсөн байна. Харин 35 хүртэлх насны залуучуудын 15 хүртэлх хувь нь ийм үнэлгээ өгчээ. Энд насны тоо нэмэгдэх тусам хангалттай гэсэн үнэлгээний эзлэх хувь нэмэгдэж байна. Нийт судалгаанд оролцогчдын 36-51 хувь Иргэний танхимын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэсэн үнэлгээ өгчээ.

Нийт судалгаанд оролцогсдын 42 хувь нь Иргэний танхимын үйл ажиллагаанд ямар нэгэн байдлаар оролцож байсан бол 58 хувь огт оролцож байгаагүй байна. Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй байдлыг насны бүлгээр нь нарийвчлан үзвэл нийт судалгаанд оролцогчдын 27-38 хувь оролцож байсан гэж хариулсан бөгөөд насны тоо нэмэгдэх тусмаа иргэдийн оролцоо нэмэгдэж байгаа үр дүн ажиглагдаж байна.

Хүснэгт 19. Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй байдал, насны бүлэг, хувиар

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Тийм	27	31	37	39	38
Үгүй	73	69	63	61	62
Нийт	100	100	100	100	100

Сум/Дүүргийн Иргэний танхим

Төрийн хууль тогтоомж, дүүрэг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, сум, дүүргийн Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагаас гаргаж байгаа бодлого, шийдвэрийг иргэдийн байр суурь, үзэл бодол, саналыг тусгаж шийдвэр гаргагчид мэдээлэх, олон нийтийн санаачилсан болон орон нутгийн түвшинд тулгамдсан асуудлыг ил тод, нээлттэй хэлэлцэх зорилгоор ИТХ-ын дэргэд Иргэний танхим байгуулагджээ.

Бид судалгааныхаа явцад Өвөрхангай аймгийн Арвайхээр, Есөнзүйл сум, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Бууцагаан сум, Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Жаргалтхаан, Хэрлэн сум, Сүхбаатар аймгийн Мөнххаан, Баруун-Урт, Түмэнцогт сум, Дундговь аймгийн Сайнцагаан, Дэлгэрцогт сум, Төв аймгийн Зуунмод сумд болон нийслэлийн Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдийн Иргэний танхимын үйл ажиллагаатай танилцаж, түүний талаар иргэд, албан хаагчдын санал бодлыг судлан тоймлов.

Сум, дүүргүүд дэхь Иргэний танхимын үйл ажиллагаа бүхэлдээ нийтлэгдүү дүр төрхтэй байгаа учраас бодит байдалд ямар байгааг Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Ажлын албаны даргын яриа ерөнхийдөө харуулж байгаа тул түүний ярилцлагаас дор оруулав.

Шигтгээ 4. *“...Нэг үеэ бодвол иргэдийн идэвхи сайжирч байгаа, бид зохион байгуулалттайгаар тодорхой ажлуудыг хийж байна. Хурлын ажлын албанд иргэний оролцооны хэлтэс байгуулагдан, 19 хороонд Иргэний танхим байгуулж ажиллах журмыг нь тэргүүлэгчдийн хурлаар баталж үйл ажиллагаа тогтмолжоод байна.*

Иргэний танхилаар дамжуулан дүүргийн шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах явдал чухал. Иргэдийг мэдээллээр хангах зорилгоор ИТХ-ын тэргүүлэгчдээс 2013 онд Нийтийн зар мэдээний журам баталж гаргасан. Нөгөөтэйгүүр Иргэний танхим маань Иргэдийн хөгжлийн төв байх ёстой. Бид энд тодорхой хуваарийн дагуу сургалтууд тасралтгүй зохион байгуулж эхлээд байгаа. Хувь хүнийг чадавхижуулах эрүүл мэнд, эрх зүйн чиглэлээр бас зарим төрлийн мэргэжил олгох сургалтуудыг зохион байгуулж байна.

Иргэдийн оролцоог зөвхөн санал авахаар хязгаарлаж болохгүй юм. Өнгөрсөн жилээс бид хороодод бүлэг үүсгэх ажлыг эхлүүлсэн бөгөөд одоогийн байдлаар 15 хороонд 26 бүлэг байгуулагдан 198 иргэн хамрагдаад байна.

Бүлгийн гол зорилго нь халтын хөдөлмөрөөр амьдрах орчноо сайжруулах, бүлгээрээ хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж ОНХС-ийн 20 сая хүртэлх төсөвтэй ажлыг тухайн хорооны иргэдийн бүлгээр гүйцэтгүүлэх, бүлэгт зориулж анхан шатны сургалт хийх, зээлд хамруулах зэргээр дүүргийн зүгээс дэмжиж ажиллаж байна.

*Чингэлтэй дүүргийн ИТХ-ын Ажлын албаны дарга
Ц.Алтанцацралын ярилцлагаас*

Чингэлтэй дүүрэгт ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 164 тоот тогтоол гарч иргэний оролцоог хангах, иргэдийн санал, санаачилгыг хэрэгжүүлэх зорилгоор дүүргийн 19 хороо тус бүрт Иргэний танхим байгуулахыг дүүргийн Засаг даргад үүрэг болгож, хороодын Иргэний танхим байгуулах төсөв хөрөнгийг дүүргийн 2014 оны нийгэм, эдийн засгийн зорилт, төсөв төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг даалгасан байна. Мөн хороодын Иргэний танхимын ажиллах журмыг дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 1 дүгээр сарын 23-ны 105 тоот тогтоолоор баталж хяналт тавьж ажиллахыг Иргэний оролцооны хэлтэст даалгасан байна.

Шаталсан бүтэц маягтай ажиллуулж байгаа дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан хороодын Иргэний танхимын ажиллах журам (Нийтлэг үндэслэл)-ын 1.1-д “Төрийн бодлого, шийдвэр хуулийн төсөл, дүрэм, журам, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас гарах шийдвэр, нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах үүрэг бүхий хороодын “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө” гэжээ.

Мөн журмын 3.7-д дүүргийн ИТХ-ын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс нь Иргэний танхимын үйл ажиллагааг зохицуулах, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт үнэлгээ хийх, сар улирлаар нийтийн хэлэлцүүлгийг төсөвлөж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал шийдвэрт хэрхэн тусч байгаад хяналт тавьж ажиллана.

Журмын 4.5-д Иргэний танхимын ажиллагаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөгөө дүүргийн ИТХ-ын хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтсийн даргаар батлуулна гэсэн зэргээс харахад Иргэний танхимуудыг шаталсан бүтэц рүү түлхэж буй шинж ажиглагдав.

Судалгаанд хамрагдсан Иргэний танхимуудын үйл ажиллагаа эхлэлийн байдалтай, нийтлэг агуулгатай, үйл ажиллагааны журамтай байв. Журам нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын баталсан журмыг үндсэнд нь хуулбарласан байлаа.

Шийтгээ 5. *ЗЗНДН-ийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 20.1 заалтыг үндэслэжээ. 3 заалтын эхнийх нь Иргэний танхим байгуулах тухай, хоёрдугаарх нь Иргэний танхим байгуулахтай холбогдуулж Иргэний танхим хариуцсан ажилтны орон тоо нэмж байгуулах, гуравдугаарх нь энэ ажилтны цалинг ТЗ-7-1 шатлалаар тогтоон үйл ажиллагаатай холбоотой зардлыг 2014 оны сумын ИТХ-ын төсөвт суулган албан ёсоор ИТХ, Санхүү төрийн сангийн хэлтэст хариуцуулжээ.*

Энэ сумын тухайд иргэний танхим байгуулах хөрөнгийн тооцоогоо Иргэдийн оролцоотой хэлэлцүүлэг хийхэд зориулж авах тоног төхөөрөмжид 12,745,000 төгрөг, ажлын албан хэрэгцээнд зориулж авах нөөтбүүк, принтер, хувилагч, зургийн аппарат, ширээний компьютер, диктафон зэрэгт 9,090,000 төгрөг нийтдээ 21,855,000 төгрөг шаардлагатай гаргаж тогтоолын төсөлд хавсаргасан байна.

Хэнтий аймагийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013.08.06-ны өдрийн №49 тогтоолын холбогдох хэсгээс

Энэ нь бүх сумдад холбогдолтой нийтлэгдүү хандлагын илэрхийлэл гэж үзвэл Иргэний танхим бий болсоноор төрийн албан хаагчдын тооны өсөлтөд ч, төрийн албан хаагчдын цалин болон үйл ажиллагааны зардлын өсөлтөд ч мэдэгдэхүйц нөлөөлсөн гэдэг нь харагдаж байна.

Шигтгээ 6. *Иргэний танхимд ажиллаж байгаа албан хаагчид төрийг бас иргэнийг аль алийг нь төлөөлөн ажиллаж байна. Иргэндээ бол төрийг, төрдөө бол иргэнийг төлөөлж ажилладаг. Дүүргийн Тамгын газраас Иргэний танхимын эд хогшилыг гаргаж ажилладаг. Өөрсдөө хариуцан ажилладаг. Иргэний танхимд шууд өгдөг мөнгө, санхүү одоогоор байхгүй байгаа.*

Иргэний танхим ажилсанаар давуу тал бий болж чадсан. Хороо болон дүүргүүд дээрээ очоод иргэд таань өөрсдийн санал хүсэлт, гомдол зэргийг байнга хүргэж чадаж байгаа. Иргэдийн оролцоо нэмэгдэж байгаа. Төвийн 1-6 дугаар хороонуудын иргэдийг цуглуулахад хүндрэлтэй байдаг. Төлөвлөсөн үйл ажиллагаанд оролцохдоо туу байдаг. Харин хорооллын буюу бусад хороодуудын иргэний оролцоо сайн байгаа.

Иргэдийн санал гомдол болон үйл ажиллагааныхаа талаар мэдээллийг вэб сайтаар дамжуулан хүргэдэг мөн утасаар хүлээж авдаг. Иргэний танхимын ажилчид өөр өөрсдөө иргэдийн санал хүсэлтийг авч шийдэж болох асуудлыг ярилцдаг.


Дүүргийн Иргэний танхим хариуцсан ажилтантай хийсэн ярилцлагын хэсгээс

Шигтгээ 7. *Сумдад байгуулагдсан иргэний танхимын зарим нь төсөв санхүүгийн шалтгааны улмаас гадны байгууллагуудаас хатааралтай ажиллах тохиолдол байна. Жишээ нь:*

Баянхонгор айтгийн ЗДТГ-ын дэргэдэх Иргэний танхим нь 2014 онд хийх үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө нь АНУ-ын хөгжлийн агентлагын санхүүгийн дэмжлэгтэйгээр Мерси Кор олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Иргэний танхим ба иргэний оролцоо” төслийн хүрээнд Баянхонгор айтгийн иргэдэд хүрч байна.

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Баянхонгор айтгийн Алартайван Итгэл ТББ

Ер нь Иргэний танхимд иргэд оролцохдоо анхны зориулалтын дагуу нээлттэй хэлэлцүүлэгт оролцох гэснээс өөр бусад шалтаг, шалтгаанаар оролцдог нь дор харуулсан Зураг 24, Хүснэгт 21-ээс харагдах болно.



- Хурал, сургалтанд хамрагдаж байсан
- Бусад үйл ажиллагаанд оролцож байсан
- Спорт уралдаан тэмцээн, дасгал хөдөлгөөн хийхэд оролцож байсан
- Санал өгч оролцож байсан
- Үйл ажиллагаа хамтран зохион байгуулж байсан
- Бусад шууд холбогдолгүй хариулт

Зураг 24. Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн оролцооны хэлбэрийг нээлттэй асуулгаар тодруулахад, хувиар

Хурал, сургалтанд иргэдийн 18-25 нас, 36-45 нас, 56-аас дээш насныхан, ажил эрхлэлтээр авч үзвэл цалин хөлстэй ажилтан, тэтгэврийнхэн илүүтэй хамрагдсан гэжээ. Үүнээс харахад иргэний танхимын үйл ажиллагаанд идэвхитэй оролцогсад нь 56-аас дээш насны тэтгэврийн хүмүүс байна.

Хүснэгт 20. Иргэний танхимын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн оролцооны хэлбэр, насны бүлэг, тоогоор

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Иргэний танхимаас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцож байсан	4	4	2	6	2
Хурал, сургалтанданд хамрагдаж байсан	14	8	21	8	12
Санал өгч байсан	2	1	1	1	-
Хийн дасгал, дасгал хөдөлгөөн хийхэд хамрагдаж байсан	1	3	-	5	2
Үйл ажиллагааг хамтран зохион байгуулж оролцож байсан	3	-	-	-	-
Спорт уралдаан тэмцээнд оролцож байсан	-	-	-	-	2
Бусад /шууд холбогдолгүй хариулт/	-	1	-	-	-
Нийт	24	17	24	20	18

2.2 Орон нутгийн хөгжлийн сан ба Иргэний танхим, иргэдийн оролцоо

“Төсвийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2011 оны 12 дугаар сарын 23-нд батлагдсанаар Орон нутгийн хөгжлийн асуудалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хууль эрх зүйн шинэ орчин бүрдсэн байна. Ялангуяа орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө зарцуулалтанд шууд ардчилал-иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг практикт хэрэглэх асуудал тулгарав. Энэ нь эхэндээ, одоо ч нийт иргэд, орон нутгийнханд тийм ч ойлгомжтой, шууд хэрэгжчих зүйл байсангүй. Ийм учраас Засгийн газар, Сангийн яамны зүгээс хэд хэдэн тогтоол, тушаал, заавар батлан гаргахад хүрчээ. Тухайлбал, Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай тогтоол (Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 30 дугаар тогтоол)-оор Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал, мөн “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ыг тус тус баталсан. Ингэснээр төв, орон нутгийн түвшинд шилжүүлэг тооцох аргачлал нэг мөр ойлгогдох болжээ. Харин Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244-р тушаалын хавсралтаар Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлагдсан байна. Энэхүү журам нь Засаг дарга нар тухайн шатын жилийн төсвийн төслийг боловсруулж, ИТХ-д өргөн мэдүүлэх, Орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутагт үйл ажиллагаа явуулдаг тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээгээр санхүүжих улсын төсвийн байгууллагын төсвийн захирагч жилийн төсвийн төсөл боловсруулж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх, батлагдсан төсвийг хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх, харилцааг зааварчлан таниулж байгаагаараа онцлог юм.

Энэ журмын 6.3-д Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд төсвийн тухай хуулийн 60.3-т заасан зүйлийг баримтлана. Тухайлбал,

- Орон нутгийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулж зарцуулахгүй байх,
- Хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх,
- Орон нутгийн дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдсан байх,
- Иргэдийн оролцоог хангасан байх,
- Зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр үүсвэртэй давхардуулахгүй байх,
- Төслийн төсөлд шинээр бий болсон, эсхүл сайжруулсан өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлын тооцоо төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгасан байхыг шаардаж байгаа зэрэг нь төлөвлөлтийг сайжруулах, хариуцлагажуулахад чухал бичиг баримт болжээ. Гэвч Төсвийн тухай (шинэчилсэн) хууль батлагдаж гарсанаас хойш 2-3 жилд төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэхэд иргэдийн оролцоо сул байсан нь судалгааны явцад харагдав. Иргэдийн оролцоо сул байгаад иргэдийн идэвхигүй байдал ч, сумын удирдлагын санаачилгагүй байдал ч нөлөөлж байх шиг байна.

Шигтгээ 8. *Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах хуулийн заалт, заавартай ч иргэдийн таань идэвхи сул, саналаа тэр бүр илэрхийлж сураагүй, илэрхийлж байгаа нэг нь ямар ч тооцоо, баримжаагүй, хэрэгжих үндэслэлгүй зүйл ярьдаг. Бидний зүгээс ч хот суурин газрынхантай адил иргэдийн саналаа цахим хэлбэрээр авах зэрэг бололцоо муутай юм... Иргэд, малчид ч санал асуулгын хуудсанд олигтой юм бичиж өгөхгүй юм даа...*

Сүхбаатар аймагийн Түмэнцогт сумын төрийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас

Орон нутгийн түвшинд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтанд иргэд идэвхгүй оролцох болсон явдалд нөлөөлж байгаа нэг томоохон хүчин зүйл нь “Шууд ардчилал-иргэдийн оролцоогоор асуудлыг шийднэ” гэж хэлж өдий төдий санал авч тэргүүлэх ач холбогдолоор нь жагсаан тухайн шатны Засаг даргын тамгын газарт хүргүүлдэг. Тэр нь ЗДТГ-аар орж дахин эрэмблэгдэж хянагдаад ИТХ-аас гарах шийдвэрт бараг юм үлдэж тусгагддаггүй юм байна. Үүнийг бидний судалгаанд хамрагдсан сум, дүүрэг, баг хорооны иргэдээс гарсан саналын жагсаалт, холбогдох шатны ИТХ-аас гарсан эцсийн шийдвэр хоёрын зөрүү нотлон харуулж байгаа юм. Энэ тухай жишээг нийслэлийн Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны иргэдээс санал авч 462 саналыг эрэмбэлээд 19 бүлэг болгон хувааж, Иргэний танхимаар тэнд цугларсан 39 иргэнээр хэлэлцүүлж дахин эрэмбэлж байгаа байдлыг харуулсан кейст тодорхой байгаа.

Шигтгээ 9. *Суманд хуваарилагдан ирж буй ОНХС-ийн мөнгөөр уг нь нийт сумынхаа эрх ашигт нийцсэн хүн бүр үр ашгийг нь хүртэж болохоор цөөн тооны чанартай, үлдэцтэй зүйлд зармаар байдаг, гэтэл иргэдийн саналыг аль болох харгалзах нэрээр олон зүйлд төсвөө тарамдуулж эцэст нь цөөн хэдэн хүнтэй бүлэг хадландаа хашаа барих, ганц хоёр өрх малаа усалдаг худаг гаргах тэт рүү орчих гээд байна ...*

Баянхонгор аймагийн Бөмбөгөр сумын Засаг даргын ярианаас

Өөр нэгэн жишээ бол хорооны иргэдээс санал авах ажлыг хорооны нийт 1497 өрхөд 1497 саналын хуудас хүргүүлж, иргэдээс өгсөн саналын хуудасны дүнг нэгтгэж, нээлттэй хэлэлцүүлэгт 1497 өрхийг төлөөлөн 132 иргэн оролцсон байна. Хэлэлцүүлэгийн явцад давхардсан тоогоор 32 иргэнээс 19 ажил үйлчилгээ хэрэгжүүлэх санал гарч хэлэлцүүлгийн шийдвэрт тусгуулахаар тогтсон байна.

Энэхүү зөрүү, зөрчил нь төсвийн төслийг боловсруулах батлахад хууль дүрмийн хүрээнд процедурын алдаа гарсанаас үүдэн гарч байгаа асуудал биш юм. Өнөөгийн хууль дүрмийн хүрээнд төсвийг боловсруулахад иргэдийн оролцоог хангахдаа тухайлбал, аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний

төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж жил бүрийн 3-р улиралд багтаан иргэд, олон нийтийн санал асуулгын хуудас ашиглах, ярилцлага зохион байгуулах, бусад дэвшилтэт технологийг ашигладаг. Тэгээд олон нийтээс хамгийн их санал авсан төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмблэн, иргэд, олон нийтэд танилцуулах ёстой. Олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсанаар иргэд нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан болон бусад шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалт гарган тухайн шатны ИТХ-д төсвийн төслийн хамт өргөн мэдүүлдэг. Ингээд ИТХ шийдвэрээ гаргадаг. Ийм ч хуультай. Сум, дүүргийн төвшинд ч ийм л процедур үйлчилдэг. Тэгэхээр зөрүү, зөрчил нь хуульд бус, ойлголтын зөрүүнд оршиж байна. Товчхон хэлбэл, эцсийн дүндээ төлөөллийн ардчилалын хүрээнд, хуулийнхаа дагуу шийдэгдэх асуудал дээр шууд ардчилал-иргэдийн оролцоогоор шийдэгдэх юм шиг ойлголт иргэдэд төрүүлж байгаад буруу нь байна.

Шигтгээ 10. *Ер нь бол 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс төсвийн хууль хэрэгжиж эхэлсэн бөгөөд улсын төсөв хэлэлцэхээс өмнө холбогдох яамдууд санал болгоод тэр дотроос орон нутагтай холбоотой саналыг авч үзсэн. 2014 оны болон 2015 оны ажлууд сумдад эрэлбээрээ хэрэгжээд явж байгаа. Иргэдээс тусгайлан авч үзнэ гэдэг нь учир дутагталтай. Айлгийн төв дээр хийгдэх ажлыг бусад сумаас авах нь зохимжгүй зүйл. Айлгийн төвийн сумдад хийгдэх ажлуудад бусад сумдаас хатаагүй илүү их хөрөнгө төлөвлөгдөж байгаа. Бусад сумдууд 300-гаад сая төгрөг төлөвлөгдсөн байхад айлгийн төвийн суманд 700-800 сая төгрөг төлөвлөсөн байна. Сум бол дорвитойхон ажил хийдэггүй. Харин айлгийн төвийн сум нь зам засах ажлыг хийж гүйцэтгэдэг.*

Иргэдийн хурал дээр очоод хэлэлцэхээр тодорхой өөрчлөлтүүд байна. ОНХС-аар хийгдээд иргэдийн хүндэтгэлийг хүлээж байгаа ажилууд нь сум суманд өөр байгаа.

Бүх юмыг иргэдийн саналаар авна гэхээр хөдөөгийн иргэдээс мал аж ахуйтай холбоотой санал гараад байдаг учраас малжуулах ажлыг ОНХС-аар хөрөнгөөр хийдэг. Мөн тарган сүргийн зарчмаар, малыг 100% эргэлтэнд оруулаад ажиллах нь үр ашиг багатай ажил шүү дээ. Тэгээд мянгат малчин ч гэсэн талаа үхүүлчихдэг. Мөн 2-рт худаг усны асуудал орж ирдэг. Гүний худгийг улсын төсвөөс гаргадаг. Сүүлийн жилүүдэд хэд хэдэн худаг сумдад гаргасан. Энгийн гар худгууд нь бэлчээрийн МАА-д ашиглахад зардал шаарддаггүй, нийтээрээ ашиглах боломжтой байдаг бол гүний худаг нь зовлонтой, мотор өгчихдөг, тэр нь нэг хүний мэдэлд байдаг.

*Орон нутгийн хөгжил сангийн асуудлаар
Сумын Засаг даргатай хийсэн ярилцлагаас*

Үүнийг нэг мөр болгож зөв ойлголт өгөхгүй бол бидний санал шууд ардчилалаар шийдэгдэхгүй байна гэж иргэд сэтгэл гонсойх төдийгүй манай Үндсэн хуулиар тодорхойлогдон албажсан төлөөллийн ардчилал, түүний

институцүүд болон зөвхөн баг, хорооны иргэдийн нийтийн хурал, түүний эрх хэмжээ, бодит бололцооны хүрээнд томъёологдож зөвшөөрөгдсөн шууд ардчилалын элемент хоёрын хооронд, бас ИТХ, ЗДТГ, нөгөө талаас иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, Иргэдийн нийтийн хурал, түүний ажлын албаны хооронд үл ойлголцол, зөрчил үүсгэж болохыг анхаарах хэрэгтэй. Дээр дурьдсан Засгийн газрын 30-р тогтоол, сангийн сайдын 244-р тушаалаар батлагдсан журмын хүрээнд иргэдийн оролцоо-шууд ардчилалын замаар ОНХС-ийн хөрөнгө зарцуулалтанд гайхам амжилт олж чадаагүй тэр ч бүү хэл зарим сорилттой тулгарчээ. Тухайлбал, ОНХС-ийн мөнгийг зөвшөөрөгдсөн чиг үүргийн хүрээнд зарцуулаагүй гэдэг үндсэлэлээр Аудиторын байгууллагын зүгээс сум, орон нутагт хэрэгжсэн олон төсөл, арга хэмжээнд зарцуулсан мөнгийг үндэслэлгүй зарцуулсан гэж акт тавьжээ. Түүний доор Иргэний танхимын санхүүжилттэй холбоотой актууд ч тавигдсан байна.

Шигтгээ 11. *Бид өнгөрсөн жил сумандаа Иргэний танхим байгуулж байр засах, тоног төхөөрөмжинд хэдэн сая төгрөг зарцуулсан. Гэтэл аудитын байгууллага болохгүй гээд акт тавьчихаад байгаа. Ер нь Иргэний танхим гээчийн эрх зүйн үндсийг л тодорхой болгомоор байгаа юм.*

Баянхонгор айтгийн Бууцагаан сумын Засаг даргын ярианаас

Харин энэ бүхнийг зарим талаар зохицуулахад хэрэг болж болмоор нэгэн заавар гарсан байна. Энэ бол Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 43-р тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” юм. Түүний зорилго нь ОНХС-ийн үйл ажиллагааг энэ зааврын дагуу төлөвлөх, санхүүжүүлэх, зарцуулалтанд хяналт тавих, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, программ хангамж ашиглахыг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон явдал ажээ. Бидний судалгааны өнцгөөс харвал ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт Иргэний танхимын үйл ажиллагаа хоёрыг ямар нэгэн байдлаар холбож өгөх чиглэл гаргасанаараа онцлог байна.

Уг зааврын Долоо-д тодорхой хэлбэл 7.3-д дүүрэг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргүүд (Төсвийн тухай хуулийн 58.3-д заасан)-ийг зааж өгсөний зэрэгцээгээр 7.3.6-д хуульд заасан бусад чиг үүрэг гэж 9 зүйл заасны доор 7.3.6-д Иргэний танхим шинээр байгуулах, тохижилт, техник тоног төхөөрөмж гэж оруулж өгчээ.

Үүнчлэн уг зааврын 7.4-д “Сум ОНХС-ийн хөрөнгөөр төсвийн тухай хуулийн 58.4-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх болно” гэж тэмдэглээд 7.4.7-д “хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх” гэж 10 зүйл тэмдэглэсний дотор, 7.4.7-д “Иргэний танхим шинээр байгуулах, тохижилт, техник, тоног төхөөрөмж” (бодвол тоног төхөөрөмж худалдан авах тухай өгүүлж байх шиг байна) гэж бас оруулжээ.

Эндээс харвал одоо ОНХС-аас хөрөнгө гаргаж Иргэний танхим шинээр байгуулах, түүнд зориулж тохижилт хийх, тоног төхөөрөмж худалдан авч болох юм байна. Гагцхүү хуульд заасан бусад үндэслэл гэдгийн дор Иргэний танхим

байгуулах, тоног төхөөрөмж худалдан авах зэргийг оруулж байгаа нь ямар хуульд заасан үндэслэлээр гэсэн асуулт тавихад хүргэлээ. Энэ асуултын хариу нь манай судалгаагаар иргэний танхим шинээр байгуулах гэсэн заалт бүхий хууль байхгүй юм байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

Иргэний танхимыг “албажуулж” ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөх, нээлттэй хэлэлцүүлэг хийхэд түүний үүрэг оролцоог зайлшгүй болгож өгсөн нэгэн хэсгийг энэ зааварт суулгаж өгсөн байна (Зургаа. Аймаг, нийслэлийн түвшинд хөрөнгийг төлөвлөх). Энэ зааврын дагуу Аймаг, нийслэлийн засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хийх зүйлсийн урьдчилсан жагсаалт гаргах учиртай. Түүнийгээ аймаг, нийслэлийн дэргэдэх иргэний танхимаар нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 10 дугаар сарын 31-ний өдөр хүртлэх хугацаанд зохион байгуулж улмаар ийнхүү иргэний танхимаар хэлэлцүүлсэн төсөл, арга хэмжээний саналыг нэгэтгэн иргэд олон нийтээс хамгийн их санал авсан (ажлын хэсгийн санал дүгнэлтээр баталгаажсан) хөтөлбөр, арга хэмжээний дарааллыг иргэд олон нийтэд мэдээллийн хэрэгсэлээр болон иргэний танхимаар дамжуулж 11-р сарын 30-ны дотор танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулна гэж байгаа. Энэ нь нэг талаас нь харвал, асуудал иргэний танхимын шүүлтүүрээр хэд хэдэн удаа орж нөгөө талаас нь харвал өнөөгийн байдлаар аймаг, нийслэл, сум дүүргийн алинд ч гэсэн иргэний танхим гэдэг нь Засаг даргын тамгын газрын юм уу, эсвэл ИТХ-ын ажлын албаны дэргэдэх нэгэн жижиг аппарат болон хувирсан байгаа (1-2 хүнтэй, 25-350 хүртэл хүний суудалтай заал, танхим) бодит байдлыг бодолцвол өргөн олон түмний санал хэрхэн тусгагдах нь эргэлзээ төрүүлж байгаа юм. Үүнийг бататгах зорилгоор дараах “Кейс”-г энд оруулж байна.

Кейс 1: “ОНХС-ийн хөрөнгийг иргэдээс санал авч Иргэний танхимаар хэлэлцүүлэх затаар шийдэж байгаа байдлыг харуулсан

Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны Иргэдийн хурал

2014 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Иргэний танхимдаа цуглаж “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний асуудлыг иргэний танхимд цугларсан 39 иргэн хэлэлцсэн байна. Хурал 18:30-19:30 цагийн хороонд үргэлжилсэн. Энэ хуралд дүүргийн ЗДТГ-аас хоёр хэлтсийн дарга, нэг мэргэжилтэн оролцожээ.

Хэлэлцсэн гол сэдэв нь дүүргийн ЗДТГ-аас нийт 926 өрхийн тоогоор 926 саналын хуудас бэлтгээд хаягандаа байгаа 718 өрхөд тарааж түүнээсээ 462 саналын хуудас буюу 64.3 %-ийг буцаан хурааж авчээ. Энэ 462 хүний саналыг бүлэглэж үзэхэд дараах 19 ажил болсныг 39 иргэн эрэмбэлж шийдсэн байна. 462 хүнээс ирсэн 19 ажлыг доор сийрүүлэв.

1	Камер тавих	287
2	Цэцэрлэг сургуулийн өргөтгөл барих	258
3	Гэрэлтүүлэг тавих	144

4	Ногоон байгууламж нэмэгдүүлэх	122
5	Цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай байгуулах	105
6	Авто машины замын зогсоол	99
7	Явган хүний зам тавих	60
8	Тохижилтын ажил	59
9	Хог боловсруулах үйлдвэр байгуулах, пункер тавих	39
10	Байрны орцны засвар үйлчилгээ	35
11	Орон сууцны фасад засвар	19
12	Борооны ус зайлуулах хоолой тавих	16
13	Нийтийн бие засах газар байгуулах	13
14	Сантехникийн засвар	12
15	Авто зам барих	11
16	Хаягжилт хийх	11
17	Дээврийн засвар	5
18	Хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ	3
19	Мэргэжил олгох сургалт зохион байгуулах	1
Нийт		462

Хуралд ирсэн 39 хүн иргэдээс саналын хуудсаар авсан саналын эрэмбийг дахин хэлэлцэн (хэрэгтэй хэрэггүйг нь шүүж өмнөх жилийн дутагдал тухайлбал сүүдрэвчийг 5 саяар үнэлж бариулсан байсан. Яг үнэндээ 450,000₮, би төсөвчин хүн мэдэлгүй яахав гэхчлэн) 10 ажлыг олонхиорхоо хасч 9 ажлын төсөлд шинэ эрэмбэ тогтоосноор хурал дуусчээ.

Энэ эрэмбэ нь хорооны ИНХ-ын 4-р тогтоолын хавсралт болж доорх байдлаар батлагджээ.

№	Хэлэлцэгдсэн төслийн санал	Төслийн саналыг дэмжсэн иргэдийн тоо
1	19, 39 дүгээр байрны фасадын засвар	25
2	15 дугаар байрны өмнөх тохижилт	23
3	Хорооны нутаг дэвсгэрт камер тавих ажил	18
4	Цэцэрлэг сургуулийн өргөтгөл барих	13
5	12, 13, 14 -р байрнуудын сантехникийн их засвар	25
6	Нийтийн бие засах газар барих	18
7	5, 33, 39-р цэцэрлэгийн орчимд хурд сааруулагч тавих ажил	26
8	Гудамж талбайн хаягжилтын ажил	25
9	5, 6, 7 дугаар байрны дээвэр засвар	Олонхийн саналаар (2014.06.06)

Энэ жишээнээс харахад 900 гаруй өрхийг төлөөлж 39 хүн хуралдаад эрэмбэ тогтоож байгаа нь уг шийдвэрийн легитим шинж хичнээн доогуур байгааг харуулж байна. Үүнийг “Шууд ардчилал”, “Иргэний танхим”-д болсон хэлэлцүүлэг гэсэн чамин үгээр халхавчлах арга үгүй юм.

Энэ эрэмбэд багтсан 9 төслийг дүүргийн ИТХ-аар орж шийдэгдэхийн тулд дүүргийн Засаг даргын холбогдох алба хэлтэс, албан тушаалтны шүүлтүүрээр орох урт замыг туулна. Хууль журамд тусгагдсан эдгээр төсөл нь хуульд заасны дагуу ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөл батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх, орон нутгийн дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдсан байх, бий болсон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлын тооцоо, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ гээд шаардлагад нийцэх эсэх нь тодорхойгүй зүйл.

Кейс 2: “ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажил үйлчилгээг харуулсан кейс

Иргэний танхимаар хэлэлцэгдэж эрэмбэлэгдсэнээс хойш тухайн төсөл урт замыг хэрхэн туулдгийг үл өгүүлэн Чингэлтэй дүүргийн ИТХ-аар тус дүүргийн 4-р хороонд ОНХС-аас хуваарилсан хөрөнгө, түүгээр юу хийж байгааг жишээнээс харна уу.

Чингэлтэйн 4 хорооны иргэдээс гарсан санал явган хүний зам, авто замын хурд сааруулагч, Авто машины дулаан гараж, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, ахмад настан, залуучууд, чөлөөт цагаа өнгөрүүлэх, иргэний танхим, заалтай болох, бага сургууль, цэцэрлэг өргөтгөх, жишиг өрхийн эмнэлэгтэй болох, нийтийн бие засах газар зэрэг санал асуулгаар голлон бараг түүний дотор нийт хорооны иргэдэд хамаатай бус ч тухайн байр сууцныхантай холбоотой дээвэр засах асуудал гардаг байна.

Тухайлбал, 2013 оны гүйцэтгэлээр ОНХС-ийн хөрөнгөөр Чингэлтэй дүүргийн 4-р хороонд 96,6 сая төгрөгийн ажил хийснийг харуулбал (Засаг дарга С.Отгонсүрэнгийн ярьсанаар):

№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэгч	Төсөвт өртөг
1	54-р байрны борооны ус зайлуулалт	Түрүү гарав ХХК	10,6 сая
2	32-р байрны фасад засвар	Даян тэрхи ХХК	17,5 сая
3	33-р байрны фасад засвар	Даян тэрхи ХХК	19,5 сая
4	41-р байрны фасад засвар	Modern city ХХК	24,5 сая
5	54-р байрны фасад засвар	Даян тэрхи ХХК	24,5 сая
	Дүн		96,6 сая

Бас нийслэлийн хөрөнгөөр 120 сая төгрөгийн ажил хийсэн нь 19-р байрны дээврийг Даян тэрхи ХХК 35.0 сая төгрөгөөр, 32, 39-р байрны дулаан болон цэвэр усны шугам, хоолой солих ажлыг “Эцэг, Эх, Хүү” ХХК 129 сая төгрөгөөр тус тус хийжээ.

Иргэдийн оролцоо иргэний танхимаар дамжиж гарсан саналын үр дүнд ОНХС-ийн шугамаар хийгдэж буй ажлуудын үр дүнд орон нутгийн мэдлийн өмч хөрөнгө зузаарч олон нийтийг хамарсан үйлчилгээний төрөл, чанар сайжрахгүй байгаа нь дээрх жишээнүүдээс харагдаж байна. Дээрх жишээнүүдээс харахад ОНХС-ийн хөрөнгөөр хувьчлагдсан орон сууцны фасад, сантехникийн шугам засаж байгаа нь хорооны нийт иргэдийн эрх, ашиг сонирхолд төдийлөн нийцэхгүй байна.


Зарим сумдад нийтийн эрх ашигт нийцсэн гэж хэлж болохоор худаг гаргах, цахилгаан дамжуулах дэд станц барих зэрэг ажил хийгдсэн ч чанарын шаардлага хангаагүйгээс үйлчилгээ нь доголдож, зогсоход хүрч байна. Хэдийгээр иймэрхүү ажлуудыг орон нутгийн өмчид бүртгэж хүлээж авдаг ч хүлээж авах комисст зарим тохиолдолд мэргэжлийн хүмүүс оролцдоггүйгээс асуудал үүсдэг байна.

Аймгийн төвөөс алслагдсан сумдад тэр бүр мэргэжлийн хүн газар дээр нь очиж хүлээж авах комиссын үйл ажиллагаанд оролцож чаддаггүй учраас суманд гаргасан худгийн гүний хэмжээ зохих түвшинд байгаа эсэхийг орон нутгийн албан хаагчид шалгаж чаддаггүй учир өвөл болж хүйтэрмэгц хүлээж авсан худаг нь хөлдсөн тохиолдлоуд гарсан байна. Гүйцэтгэсэн объектыг хүлээж авсаны дараагаар цахилгааны шийд шатаж гэмтсэнийг аймгаас мэргэжлийн хүн ирж хүлээж аваагүйтэй холбож тайлбарлах тохиолдолд гарч байна.

Энэ бүхэн нь “Иргэний танхим” л ОНХС-ийн хөрөнгийг шууд ардчилал-иргэдийн оролцоотой төлөвлөж, хуваарилж зарцуулахад чухал үүрэгтэй цорын ганц арга зам уу гэсэн асуулт тавихад хүргэж байна. Энэ судалгааны эхний хэсэгт товч өгүүлсэн иргэний оролцооны тухай онол, концепциуд, түүний олон хэлбэр, ялангуяа шууд ардчилалын замаар шийдвэр гаргадаг үндсэн хэлбэр болох Ард нийтийн санал асуулга, Орон нутгийн түвшин дэх санал асуулга (реферэндум), Ард иргэдийн нийтийн хурал, эдгээртэй холбогдол бүхий гарсан хууль, бас Монгол Улсын Ерөнхийлөгчийн нээлттэй хаалганы өдөр зохион байгуулахтай холбоотой гарсан зарлиг хууль, эрх зүйн актуудын агуулга нь Иргэний танхимаар дамжуулж иргэний оролцоог хангах хэлбэрийг онцгойлон авч үзэх цорын ганц арга зам биш гэсэн дүгнэлтийг хийхэд хүргэж байна.


Орон нутгийн хөгжил сангийн талаарх санал асуулгын судалгааны дүн

Орон нутгийн хөгжлийн сантай холбогдуулж авсан асуулгын судалгаанаас харахад иргэд ОНХС-ийн хуваарилалт, зарцуулалт, ажлын тайлангийн талаарх мэдээлэл муутай байна. Учир нь дүүрэг, хорооны зүгээс ажлын тайлангаа жилдээ 1-2 удаа ИНХ-аар хэлэлцдэг. Орон нутгийн бодлого, шийдвэрийн талаар иргэдэд мэдээлэл төдийлөн хүрэхгүй байгаа нь мэдээллийг гол төлөв хэвлэмэл байдлаар тараадагтай холбоотой байж болох юм. Иргэдийн дөрөвний нэг нь энэ талаарх ойлголт мэдлэггүй байгаа нь тус асуултад хариулсан байдлаас харагдаж байна.



- Хангалттай хүртээмжтэй
- Сайжруулах шаардлагатай
- Хангалтгүй
- Хариулж мэдэхгүй байна

Зураг 25. Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалт, зарцуулалт, тайлангийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал, хувиар



- Тийм
- Үгүй


Зураг 26. Иргэдийн орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд оролцож буй байдал, хувиар

Судалгааны явцад иргэдээс ОНХС-ийн хөрөнгөөр юу хийх талаар санал асуулгыг хороодын хэсгийн ахлагч нар хариуцаж авдаг. Хэсгийн ахлагч нарын зүгээс нийт өрхийн дор хаяж 80 хувийг энэ асуулгад хамруулж мэдээлэл бүрдүүлдэг гэж байгаа. Гэтэл энэ мэдээлэл иргэдээс авсан мэдээлэл 2-ын хооронд маш их зөрүү байгаа нь анхаарал татаж байна.

ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцож байсан иргэдийг насны бүлгээр харьцуулан харвал нас ахихын хэрээр оролцоо нэмэгдэх хандлага харагдаж байна.

Хүснэгт 21. Иргэдийн орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд оролцож буй байдал, насны бүлэг, хувиар

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш
Тийм	19	24	31	24	38
Үгүй	81	76	69	76	62
Нийт	100	100	100	100	100




Зураг 27. Иргэдийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд оролцож буй байдал

ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцож байсан иргэдийн дундажаар 43 хувь ОНХС-тай холбоотой төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт тавих бүх үйл явцад оролцох боломж гардаггүй гэж хариулжээ.

Хүснэгт 22. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт тавихад оролцож буй байдал, хувиар

	Тогтмол оролцдог	Сонирхсон үедээ оролцдог	Оролцох боломж гардаггүй	Оролцохыг хүсдэггүй	Нийт
Төлөвлөлт	22	31	40	7	100
Хэрэгжилт	18	30	44	9	100
Тайлагналт	19	34	40	7	100
Хяналт тавихад	12	28	48	12	100


ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцсон гэж хариулсан иргэдийн хувьд төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнах үйл явцад сонирхсон үедээ оролцдог гэж 33-37 хувь нь хариулсан нь СХД-ээс харьцангуй илүү оролцоотой гэх ойлголтыг өгч байна. Үүнээс иргэдэд мэдээлэл бага хүрч байна гэж дүгнэж болохоор байна. Харин ойр орчимд хийгдсэн ажилуудыг харж, тодорхой мэдээлэлтэй байгаа иргэдийн хувьд нийтийн сайн сайхны төлөө чиглэсэн өөрчлөлтүүдийг авчирч байна гэсэн хариултыг өгчээ.



Зураг 28. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж буй ажил тухайн орон нутгийн хөгжилд ямар өөрчлөлт авчирч байгаа талаарх иргэдийн санал бодол, хувиар

Иргэдийн оролцоог сайжруулах чиглэлээр судалгаанд оролцогчдын санал

Орон нутаг дахь иргэдийн оролцоог сайжруулах чиглэлээр судалгаанд оролцогчид ямар саналтай байгааг тодруулахад тэдний 26 хувь иргэдэд мэдээлэл хүргэх хэрэгтэй, 17 хувь нь иргэдийн идвэхийг нэмэгдүүлэх хэрэгтэй, 12 хувь нь олон нийтийг хамарсан ажил зохион байгуулах хэрэгтэй гэсэн санал бичсэн бол тэдний 30 хувь нь иргэдэд нээлттэй байх, иргэдийн оролцоотойгоор ажлуудыг зохион байгуулах, иргэдийн хурал цуглаанд оролцуулах, иргэдтэй эргэх холбоотой байх, иргэдийн асуудлыг шуурхай шийдвэрлэх асуудлыг сайжруулах шаардлагатай гэж үзжээ.



Зураг 29. Орон нутгийн иргэдийн оролцоог хэрхэн сайруулах талаар иргэдийн санал бодол, хувиар

Иргэдийн оролцоог сайжруулах чиглэлд иргэдэд мэдээлэл хүргэх, идэвхижүүлэх, олон нийтийг хамарсан ажил зохион байгуулах зайлшгүй шаардлага байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Энэ чиглэлээр судалгаанд хамрагдсан зарим аймагт тодорхой санаачлагууд гарч үр дүнд хүрч буй ажлууд ч байна. Турхайлбал, Өвөрхангай аймагт “Иргэний үүргийн дэвтэр” бий болгож иргэдтэйгээ түүгээр дамжуулан тогтмол харьцаг болсон бол Баянхонгор аймагт ч мөн “Өрхтэй харилцах дэвтэр”-ийг санаачлан хэрэгжүүлсэн байна. Энд Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж буй “Өрхтэй харилцах дэвтэр”-ийн талаар тухайлан авч үзье.



Уг дэвтэрийн загварыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, Монгол Улсын Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2012 оны 2 дугаар тогтоолыг үндэслэн Баянхонгор аймгийн Засаг даргын 2013 оны 04 сарын 04-ний өдрийн 197 тоот захирамжаар батлан хэрэгжүүлж эхэлсэн байна. “Өрхтэй харилцах дэвтэр” нь төрийн ажил үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, өрхийн гишүүдийг мэдээлэлжүүлэх, зөвлөх, хамтран ажиллах, оролцоог бий болгох зорилготой юм.

Дэвтэрийг санаачлан хэрэгжүүлэгчдийн зүгээс ач холбогдолыг нь төрийн ажил үйлчилгээ өрхийн гишүүдэд хүрч, тэднийг үнэн зөв мэдээллээр хангаж, тухайн өрхийн хэрэгцээнд тулгуурласан ажил, үйлчилгээг бодитоор нь үзүүлж хэвшсэнээр өрхийн гишүүд чадваржиж, “ШУУД АРДЧИЛАЛ”-ын зарчмаар иргэдийн идэвх оролцоотойгоор төрийн бодлого төлөвлөлт хийгдэж, төрийн ажилтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналт бий болно гэж үзсэн байна.

Өрхтэй харилцах дэвтэрийг хөтлөхдөө “Төрийн албан тушаалтан болон бусад байгууллага, хувь хүн өрхөд ажил үйлчилгээ, арга хэмжээг заавал гэрт нь очиж үзүүлэх ба мэдээ мэдээлэл, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө, зөвлөмж, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгаалал, мал эмнэлгийн үйлчилгээ, хандив тусламж зэрэг үйлчилгээг хүргэх бүртээ өрхийн дэвтэрт тэмдэглэл хийж, гарын үсгээр баталгаажуулна. Энэ нь төрийн албан хаагчдын хувьд ажил дүгнэх нэг үзүүлэлт болно.



ДҮГНЭЛТ

Шууд ардчилал-иргэдийн оролцооны онол, үзэл баримтлал, түүнийг Европын зарим оронд хэрэгжүүлж буй туршлагаас үзэхэд маш нарийн зохицуулалт бүхий олон үе шат, хэлбэр, арга хэрэгслүүдийг тодорхой зориулалтаар сонгож хэрэглэдэг байна. Бидний судалгаанаас үзэхэд манай оронд шууд ардчилал-иргэдийн оролцооны тухай ойлголт дөнгөж хөгжих шатандаа байна гэж хэлж болохоор байна. Тиймээс бид энэ асуудлыг нарийн судалж нэгдсэн ойлголттой болж, тодорхой үе шаттайгаар бодлого, эрх зүйн хүрээнд төдийгүй практик амьдралд гүнзгийрүүлэн хөгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдлаа.

Мөн иргэд оршин суугаа орон нутгийнхаа бодлого, шийдвэрийн талаарх мэдээллийг ихэнхидээ телевиз, өдөр тутмын сонин хэвлэл, орон нутаг дахь засаг захиргааны байгууллагаас илүүтэй авдаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Харин брошур буюу нугалмал хуудас зэрэг хэвлэмэл материал, төлөвлөлт загвар харуулсан самбар зэрэг тус орон нутагт байрлах, иргэддээ зориулсан мэдээлэл, баримтанд иргэд, олон нийт ач холбогдол бага өгдөг ба зорьж унших нь ховор байдаг байна.

Дөрвөн иргэн тутмын нэг нь орон нутгийнхаа хөгжил, иргэдийн амьдрал ахуйтай холбоотой асуудалд байнга оролцож байхад хоёр нь зарим үед оролцдог байна. Харин үлдсэн нэг нь ямар нэгэн байдлаар оролцоогүй байгаагаа илэрхийлсэн байна. Иргэдийн нас ахих тусам байнгын оролцоо нэмэгдэж байгаа бол нас залуужих тусам зарим үед оролцох оролцоо нэмэгдсэн дүн ажиглагдаж байна. Нас ахих тусам иргэдийн оролцоо тогтмолжих хандлагатай байгааг судалгааны үр харуулж байна.

Судалгааны дүнгээс харахад байнга болон зарим үед оролцдог хүмүүсийн 44-57 хувь нь цалин хөлстэй ажиллагч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тэтгэврийн насныхан байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн бусад хэлбэрүүд иргэдийн оролцооны идвэхи сул байгаа бол мал аж ахуй эрхлэгчдийн хувьд иргэний оролцооны идвэхи маш муу буюу огт оролцоогүй байна.

1. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Иргэний танхим”-ын талаар өгүүлсэн үгэндээ “Заавал, заал, танхим шаардаад байх хэрэггүй. Иргэд чинь цуглахдаа хаана цугладаг юм, тэр газраа иргэний танхимаа байгуулаад яв” гэж хэлснээс харахад иргэдийн оролцоо, үйл ажиллагаа чухал болохоос байр сав, заал чухал биш гэжээ. Гэтэл амьдрал дээр үйл ажиллагааг эрхэмлэж иргэдийн оролцоог хангах гэхээсээ илүү хүнд үзүүлэх хаягтай, төсвөөс багагүй хөрөнгө, зардал шаардсан, тоногдсон заал, танхим аймаг, сум бүрт бий болж аль хэдийнээ байгууллагын дүр төрхтэй болжээ. Тэгэхдээ үйл ажиллагаа тогтмолжоогүй, гол чиглэлээ орхигдуулж байна.
2. “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, тэнд байдаг бүтэц бол шууд ардчилал-иргэдийн оролцоог хангах, үйлчлэх алба” гэж ойлгох ёстой. Засаг даргын Тамгын газар бол Засаг даргад туслах, иргэдэд үйлчлэх үүрэгтэй гэж Ерөнхийлөгч хэлснээс үзэхэд Ерөнхийлөгчийн төсөөлж байснаар Иргэний танхим байгуулагдсанаар хүн хүчний нөөц шинээр шаардагдах хэрэггүй ажээ. Гэвч амьдрал дээр Иргэний танхимд зориулан ажлын байрны

тодорхойлолтууд гарч шинэ орон тоо бий болсон байна.

3. *Үйл ажиллагаа.* Иргэний танхим байгуулсан зорилго, сэдлээс харахад удирдлагын шат шатанд гарч байгаа бодлого шийдвэрийг, иргэд, иргэний нийгмийн болон аж ахуйн нэгж байгууллагуудаас гарах санал, хүсэлт санаачилгыг тусгах зорилгоор иргэдийн оролцоог хангасан өргөн хэлэлцүүлэг өрнүүлж зохион байгуулах явдал ажээ. Энэ талаар зарим ахиц, сайн эхлэл байгаа ч иргэний танхимд зохион байгуулагдаж буй арга хэмжээний дийлэнх нь хэлэлцүүлэг бус, өөр зүйлс байна.
4. *Санхүү.* Судалгаанд хамрагдсан газруудын байдлаас харахад “Иргэний танхим”-ын бүтэц бий болсоноор түүний үйл ажиллагааг хэвийн хангахын тулд орон нутгийн төсвөөс анхаарах шаардлага бий болжээ. Одоогийн байдлаар Иргэний танхимд ажиллах хүнийг зарим газар түшмэдийн, зарим газар улс төрийн, зарим газар гэрээт ажилтны статустай ажиллуулж эхний хоёр тохиолдолд нь шууд төсвөөс, сүүлийнхэд нь төсвөөс давсан орлогоор санхүүжүүлж байгаа байдал ажиглагдав. Тоног төхөөрөмж худалдан авах зардлыг янз янзаар үзэж зарим суманд ОНХС-ийн хөрөнгөөс гаргаж, түүнийг нь аудитын байгууллага зөрчилд тооцож акт тавьсан байна.
5. *Эрх зүйн орчин.* Аймгуудад “Иргэний танхим” байгуулсан ИТХ-ын шийдвэрийг нягталж үзэхэд, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20-р зүйлийн 20.14 (Иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу судлан шийдвэрлэх), 20.17 (Хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх), 20.1.10 (Орон нутгийн үүсгэл санаачилгыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тухайн нутаг дэвсгэр дэх төрийн бус байгууллага, сүм хийдтэй харилцах) гэсэн заалтуудыг үндэслэн Иргэний танхим байгуулсан байдалтай байна. Энэ нь албан ёсны бичиг баримтад тусгагдсан талаасаа ингэж харагдаж байгаа ч үнэн хэрэгтээ дээрээс гарсан чиглэлийн дагуу компанчилан хийгдсэн бүтэц, зохион байгуулалт маягтай үйл явц мэт харагдаж байна.
6. Иргэний танхим, ОНХС-ийн үйл ажиллагаа хоёрын холбоог эрх зүйн үндэслэлтэй болгох талаар зарим хүчин чармайлт гаргаж байгаа ч цаашид төгөлдөржүүлэх шаардлагатай байна.

Шууд ардчилал-иргэдийн оролцоо нь нэг талаар ардчилалын суурь, нөгөө талаар ардчилалд суралцах, талууд харилцан ойлголцох, зөвшилцөлд хүрэх боломж учраас түүнийг зөв хөгжүүлэх шаардлагатай юм. Ингэхийн тулд бүх түвшинд сургалт зохион байгуулж, нэгдсэн ойлголттой болж, янз бүрийн арга хэрэгслүүдийг зохих зориулалтаар нь хэрэглэж хэвших хэрэгтэй байна.

ЗӨВЛӨМЖ

1. Монгол улсын өнөөгийн нөхцөлд төрөө дээдэлж, хуульд хөтлөгдөж явах хандлага зохимжтой юу, иргэдийн сонирхолыг дээдэлж, түүнд хөтлөгддөг шууд ардчилалд шилжих нь зөв үү, эсвэл энэ хоёрыг оновчтой хослуулах боломж байна уу гэдэг талаар нухацтай судалгаа хийж судалгааны үр дүнд суурилсан бодлого боловсруулах,
2. Шууд ардчилал, иргэдийн санаачилга, оролцооны талаар олон улсын түвшинд хэрэгжиж сайн үр дүнгээ өгсөн үзэл баримтлал, арга, техникүүдээс манай өнөөгийн хөгжлийн түвшин, үндэсний уламжлал, онцлогт тохирсоныг нь зөв сонгож нутагшуулах, чингэхэдээ ганц нэгэн арга хэлбэрийг хэт туйлшруулж авч үзэхээс сэрэмжлэх,
3. Шууд ардчилал, төлөөлийн ардчилал хэмээх ойлголтуудыг маш ойлгомжтой зааглаж практик амьдралд тэдгээрийг хооронд нь зөрчилдүүлэх бус харин бие биений нь сул талыг нөхөн гүйцэтгэх зарчмаар хослуулах арга замыг хууль эрх зүйн үндэслэлтэйгээр тогтоох,
4. Иргэний танхимыг цаашид Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх захиргааны эсвэл нутгийн өөрөө удирдах байгууллагын дэргэдэх институцчилагдсан бүтэц хэлбэрээр бус энэ судалгааны ажлын 1-р бүлэгт дурьдсан эдүгээ цагийн хотын цуглаан (21-р зууны town meeting), задгай талбайн хуралдаан (Open Space Conference) хэлбэр рүү чиглүүлэх,
5. Манай сумын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд “Иргэний танхим” гэх маягийн бүтэц зайлшгүй бий болгох шаардлага байгаа нөхцөлд, хэрвээ түүнийг Засаг даргын харьяанд байгуулахаар бол аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын “...Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно” (Үндсэн хуулийн жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх заалт) гэсэн Үндсэн хуулийнхаа заалтыг, хэрвээ Иргэдийн төлөөлөгчдийн хурал талдаа байх нь тохиромжтой бол иргэдийнхээ санал хүсэлтийн дагуу “Нутгийн өөрөө удирдах байгууллага, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний ... асуудлыг бие дааж шийдвэрлэх ...” (Үндсэн хуулийн жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх заалт), Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” (Үндсэн хуулийн жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь заалт) гэсэн заалтуудыг мөрдлөгө болгон шийдвэрлэх,
6. “Шууд ардчилал-Иргэдийн оролцоо”, “ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтанд иргэдийг оролцуулах “Иргэний танхим” гэсэн гурвалсан холбоог хангах, оновчтой ажиллуулах чиглэлээр бодлого, эрх зүйн хүрээнд зарим ахицтай оролдлого гарсан байгааг тэмдэглэхийн хамт дутуу орхисон, сайтар бодож боловсруулаагүй, эсвэл хэтэрхий механик холболттой бичиг баримт заавар зэрэг нилээд байгааг цэгцлэх, Тухайлбал, Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 43-р (Заавар батлах тухай) тушаалд Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүргийн хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх гэсэн (7.4.7, 7.3.6-д) хэсэгт, иргэний танхим шинээр байгуулах, тохижилт техник тоног төхөөрөмж гэж оруулж өгсөн байна. Бидний судалгааны явцад “Иргэний танхим шинээр байгуулах” гэсэн хуулийн заалт олдсонгүй. Энэ мэт асуудлуудыг нэг мөр болгож шийдэх шаардлага судалгааны үр дүнгээс харагдаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Бодлого, эрх зүйн баримт бичгүүд

Монгол улсын Үндсэн хууль, 1992 он.

Ард нийтийн санал асуулгын тухай хууль, 1995 он.

Төсвийн тухай хууль, 2011 он.

“Нэг цонхны үйлчилгээ”-ний талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 153 тоот тогтоол.

“Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулах тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 97 тоот зарлиг.

Монгол улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. УБ., 2008 он.

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр. УБ., 2012 он.

Гарын авлага

Кейсийн судалгаа., Гарын авлага, УБ., 2014 он.

Сум, орон нутгийн хөгжлийг оролцооны аргаар төлөвлөх., Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх арга зүйн гарын авлага., МНУХ., УБ., 2013 он.

Орон нутгийн засаглалын төлөв байдлыг хэмжихүй: Хэрэглэгчийн гарын авлага., АЗҮХЧХГХ., УБ., 2010 он.

Мянганы хөгжлийн 9 дэх зорилго ба иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, санаачлага., АЗҮХЧХГХ., УБ., 2010 он

“Төсвийн үйл явц дахь иргэний нийгмийн оролцоо” сургалтын гарын авлага., АЗҮХЧХГХ., УБ., 2010 он.

“Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоо” гарын авлага., Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөн., УБ, 2011 он.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц дахь иргэдийн оролцоо., Олон нийтэд зориулсан гарын авлага., Монгол улс дахь Азийн Сангийн “Ирээдүйгээ Баталгаажуулах нь” хөтөлбөр., УБ., 2007 он.

НҮБ (2008). Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар. Улаанбаатар.

Багийн түвшинд иргэдийн оролцоо, эргэх холбоог сайжруулах нь: иргэдийн хурлын гарын авлага., Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн., УБ., 2013 он.

Судалгааны тайлан

Орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо., Мерси Кор Монгол ОУӨ, ТАН төсөл., УБ., 2007 он.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, мэдээллийн хүртээмж, иргэдийн оролцоо, санал өгөх, баталгаажуулах, хэрэгжүүлэх үйл явц., Үндэсний хөгжлийн хүрээлэн., УБ., 2014 он.

“Сумын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсөв, иргэдийн оролцоог үр дүнтэй ашигласан туршлага, сургамж”, Үндэсний хөгжлийн хүрээлэн, УБ., 2014 он

Аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын тамгын газрын дарга нарын улсын зөвлөлгөөн, Эмхэтгэл, ШХА, Нэг цонхны үйлчилгээ төсөл, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, УБ., 2013 он

Монгол улсын Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний талаарх статистикийн тойм, Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, УБ., 2013 он

Гадаад хэл дээрх эх сурвалжууд

Martin A. Novak, *Five rules for the evolution of cooperation*. In Science. 314. Nr. 5805, 2006-12-08, p. 1560-1563, PMC 3279745

Arnstein, S.R. (1969). *A Ladder of Citizen Participation*. In AIP Journal. July 1996.

Patrizia Nanz, Miriam Fritsche (2012). *Handbuch Buergerbeteiligung: Verfahren und Akteure, Chancen und Grenzen*, Bonn.

Fung, A. (2006). *Varieties of Participation in Complex Governance*. In *Public Administration Review*. December 2006. Special Issue.

Andreas Gross, Bruno Kaufmann (2002). *IRI Europa Laenderindex zur Volksgesetzgebung 2002. Ein Design- und Ratingbericht zu den direktdemokratischen Verfahren und Praktiken in 32 europaischen Staaten*, Amsterdam 2002, S. 13 (http://www.aktion-volksabstimmung.de/uploads/media/Europa_Laenderindex_2002_03.pdf).

Bertelsmannstiftung (2012). *Politik beleben, Buerger beteiligen: Charakteristika neuer Beteiligungsmodelle*. Guetersloh, 2. Auflage.

Bertelsmannstiftung (2012). *Politik beleben, Buerger beteiligen: Charakteristika neuer Beteiligungsmodelle*. Guetersloh, 2. Auflage.

Цахим эх сурвалжууд

www.legalinfo.mn

www.khural.mn

www.ubstat.mn

<http://tutsmashin.mn/static/about>

<http://www.news.mn/content/149040.shtml>

www.facebook.com/tutsmashin/

<http://itpta.gov.mn/mn/news/show/186>

(en.m.wikipedia.org) *Government in the United States*. 1997. p. 17

http://de.wikipedia.org/wiki/Direkte_Demokratie

<http://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC3279745/>

<http://www.forschungsstelle-direkte-demokratie.de/>

http://de.wikipedia.org/wiki/Vertrag_von_Lissabon

http://de.wikipedia.org/wiki/Europ%C3%A4ische_B%C3%BCrgerinitiative

<http://ec.europa.eu/environment/aarhus/>

https://www.coe.int/t/ngo/Source/Code_German_final.pdf

ТЭМДЭГЛЭЛ

ISBN 978-99973-0-540-4



9 789997 305404